

**ХУУЛЬ
САХИУЛАХЫН ИХ
СУРГУУЛЬ**

**МОНГОЛЫН
КРИМИНОЛОГИЧДЫН
ХОЛБОО**

**ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ АСУУДАЛ
ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ**

**2015 №4 (54)
13 дахь жилдээ**

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ

Д.ЗҮМБЭРЭЛЛХАМ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Б.БАТ-ЭРДЭНЭ
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Б.БАТЗОРИГ
ТАХАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД ДАРГА, ДОКТОР (Ph.D)

Б.БОЛДБААТАР
МОНГОЛЫН КРИМИНОЛОГИЧДЫН ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Н.ГАНБАДРАЛ
ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Ж.ДОЛГОРСҮРЭН
ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР

Н.ЖАНЦАН
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

А.ЛХАГВА
МОНГОЛ УЛСЫН ГАВЪЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Г.ЭРДЭНЭБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.ЭНХБОЛД
ДОКТОРАНТ

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

С.ГАНТУЛГА
ДОКТОР (Ph.D)

Б.МӨНХЗУЛ
МАГИСТР

Гарчиг.....

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Монгол Улс дахь гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ.....Л.Бат-Очир, Б.Мөнхзул
- Хүүхдийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд анхаарах асуудал.....Д.Анхзаяа

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийг Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн уламжлал.....Ж.Батням

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Мөрдөн шалгах ажиллагааны онол, практикийн асуудал.....Б.Эрдэнэбилэг
- Гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний хөгжил.....Н.Манлайбаатар
- Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.....Ц.Очгэрэл
- Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн нотлох баримт бүрдүүлэх.....А.Мөнх-Эрдэнэ
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал, мөрдөхөд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.....Б.Цогтбаатар
- Хүний эрх ба нийгмээс тусгаарлах албадлага.....Г.Амаржаргал
- Гэмт хэрэг мөрдөх ажиллагааны дэмжлэг үзүүлэх орчин үеийн чиг хандлага.....Я.Цэлмэн
- Таслан сэргийлэх арга хэмжээ, чиг хандлага.....Ц.Шийтэрчулуун
- Сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах сэтгэл зүйн тактикийн асуудал.....П.Эрдэнэбаатар

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Хэргийн газрын үзлэгт криминалистикийн мэргэжилтний оролцоо, анхаарах асуудал.....Д.Алтантуяа
- Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт шүүх эмнэлгийн шинжилгээ хийхэд анхаарах нь.....С.Аюушбаатар
- Мөр битүүмжлэхэд анхаарах асуудал.....Д.Сүхбат
- Шүүх сэтгэц гэм судлалын шинжилгээ нотлох баримтын эх сурвалж болох нь.....Б.Ерөөлт

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- Терроризмтай тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа ба хэсгийн байцаагчийн үүрэг, оролцоо.....Б.Баянмөнх

ТӨР, ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

- БНХАУ-ын захиргааны процессын эрх зүйн онцлог.....Ц.Мөнхдэлгэр

КРИМИНОЛОГИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Л.Бат-Очир

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад*

Б.Мөнхзул

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
тэнхимийн багш, цагдаагийн дэслэгч*

Монгол Улсад хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулахад төрөөс хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, иргэдийнхээ амар тайван аж төрөх нөхцөл бололцоог хангах явдал чухал асуудал билээ.

Монгол Улсын хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт нэмэгдэхийн хирээр эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг бодитой зөв үнэлж, дүгнэх улмаар, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тогтоож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй оновчтой төлөвлөх, боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, гэмт хэргийн улмаас хохирсон иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх ажилд төдийлөн ахиц дэвшил гарахгүй байгаа явдал нь гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах үйл ажиллагааны тулгамдаж буй асуудлын нэг болж байна.

Өнөөдөр олон нийт хэвлэл мэдээллийн хэрэгслээр гэмт хэрэг огцом өсч, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал хүндэрсэн, энэ нь Өршөөлийн тухай хууль батлагдсан болон эдийн засгийн байдалтай холбоотой гэх мэтээр тайлбарлаж байгааг харгалзан бодит нөхцөл байдал ямар байгааг 2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, статистик мэдээлэл дээр тулгуурлан дүн шинжилгээ хийж, нийт гэмт хэргийн өсөлт, бууралт, түүний шалтгаан нөхцөл, нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, улмаар цаашид гэмт хэргийн нөхцөл байдалд прогноз хийлээ.

Цагдаагийн ерөнхий газрын Судалгааны төв, Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд улсын хэмжээнд 2015 оны эхний 11 сард 24925¹ гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 611 хэрэг буюу 2.5 хувиар өсчээ.



Хэсэгчилсэн судалгаанаас харахад сүүлийн 5 жилд нийт бүртгэгдсэн гэмт хэрэг жилд дунджаар 4.5 хувиар өссөн байх ба 2015 онд хамгийн бага хувийн өсөлт ажиглагдаж байна.

¹ ЦЕГ-ын Судалгааны төвийн статистик мэдээ.УБ хот. 2015 он.

2015 оны эхний 11 сарын байдлаар өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 1006 буюу 9.9%, үүнээс бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэг 746 буюу 9.7%, бусдын эд хөрөнгийг залилан мэхлэх гэмт хэрэг 202 буюу 12.3%, аж ахуйн эсрэг гэмт хэрэг 215 буюу 57.4%, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодисыг хууль бусаар бэлтгэх, олж авах, хадгалах, тээвэрлэх, илгээх, борлуулах гэмт хэрэг 14 буюу 36.9%-иар өссөн байна.



Эдгээр гэмт хэргүүд өсөхөд нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүй, зохион байгуулалт, ёс суртахуун зэрэг гэмт хэргийн суурь шалтгаануудаас гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн далд зар сурталчилгаа, түүнд тавих хяналт сул, хяналтгүй байдал, иргэдийн жижиг, дунд үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх боломж муу, санхүүгийн эх үүсвэр байхгүй, эрх зүйн орчин дутмаг, төрийн бодлого, хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа, уялдаа холбоо, алба хаагчдын албандаа хандах хандлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдал, иргэд төрийн бодлого үйл ажиллагаанд итгэх итгэл буурсан, хэт улс төржилт, төрийн тогтворгүй байдал зэрэг нөлөөлсөн байх талтай.

2015 оны эхний 11 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийг бүтцээр нь авч үзвэл 16445 буюу 64.3% нь нийслэлд, 9091 буюу 35.6% нь орон нутагт үйлдэгджээ. Үүнийг өмнөх онтой харьцуулахад нийслэлд 866 гэмт хэрэг буюу 5.5%-иар өсч орон нутагт 255 гэмт хэрэг буюу 2.8%-иар буурчээ.




Нийслэлд үйлдэгдэж буй гэмт хэргийн өсөлт нь хүн амын өсөлт, хотжилттой зайлшгүй холбогдох ба хүн амын өсөлтийг графикаар харуулбал жилд дунжаар 1.9 хувиар тогтмол нэмэгдэж байна.

Нийслэлийн хүн амын сүүлийн 10 жилийн харьцуулалт:




Нийслэлд 2015 оны эхний 11 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийг дүүргээр нь авч үзвэл Багануур дүүрэг 30.3%, Налайх дүүрэг 26.9%, Сүхбаатар дүүрэг 22.4%, Баянгол дүүрэг 7%, Сонгинохайрхан дүүрэг 6%, Баянзүрх дүүрэг 1.5%-иар өссөн харин Багахангай дүүрэг 12.5%, Хан-Уул дүүрэг 6.7%, Чингэлтэй дүүрэг 4.8%-иар буурсан байна.

Нийслэлийн дүүргүүдэд 10000 хүн тутамд ноогдох гэмт хэргийн түвшинг тогтооход СБД-т 10000 хүнд 258 гэмт хэрэг ноогдож байна.




Харин орон нутагт 2015 оны эхний 11 сарын байдлаар 9091 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 255 гэмт хэрэг буюу 2.8%-иар буурчээ. Орон нутагт үйлдэгдэж гэмт хэргийн гаралт тогтвортой байгаа боловч нутаг дэвсгэрийн онцлогоос хамааран Хөвсгөл, Ховд, Сэлэнгэ, Архангай аймагт хүн ам, шилжилт хөдөлгөөн, зам харилцаа, нийслэлд ойрхон зэрэг онцлог шинжүүдээс хамааран тодорхой хувиар өссөн байна.

Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэргийг 2014-2015 оны байдлаар харьцуулбал:



Гэмт хэрэг, ялангуяа хүч хэрэглэсэн буюу хүнийг санаатай алах, бусдын бие махбодид гэмтэл учруулах, танхайрах, дээрэмдэх, булаах, хулгайлах, хүчиндэх, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүдийн гаралтыг цахим зураглалаар <http://crimemap.police.gov.mn/-aap> Цагдаагийн ерөнхий газраас үзүүлсэн байна. Энэ гэмт хэргийн цахим зураглалыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй шат шатны төрийн байгууллага, албан тушаалтнууд үйл ажиллагаандаа ашиглах нь зүйтэй. Гэмт хэргийн цахим зураглалаар тухайн нутаг дэвсгэрт хүч хэрэглэсэн гэмт хэргийн тархалтыг танин мэдэж, шалтгаан нөхцөлийг арилгах арга хэмжээ авахад чухал ач холбогдолтой. Тухайлбал, Баянзүрх дүүргийн хэмжээнд 2015 оны 11 дүгээр сарын 2-ноос 12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар иргэдийн өмчийн хулгайг доорх зургаар харуулсан байна. Үүнийг гэмт хэргийн төрөл, хороогоор, цаг хугацаагаар нь нарийвчлан үзэх боломжтой.



Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэрэг нь нийгмийн сөрөг зүйл болох архидалт, ажилгүйдэл, ядуурал зэрэг нийтлэг шалтгаан, нөхцөлөөс гадна дараах шалтгаан, нөхцөлийн улмаас үйлдэгдэж байгаа нь холбогдох статистикийн мэдээлэл, нийгэм дэх хандлага, ажиглалтын судалгаанаас дүгнэж болохоор байна. Үүнд:

❖ **Хотжих үйл явц буюу хот төлөвлөлт:**

Энэ оны 11 дүгээр сарын байдлаар бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 64% нь нийслэл хотод, 36% нь хөдөө орон нутагт бүртгэгдсэнээс үзэхэд, гэмт хэргийн гаралт “хотод төвлөрөх” хандлагатай болж байна. Мөн хотын төлөвлөгөөнд ороогүй буюу төлөвлөгөөгүй баригдсан олон барилга, орон сууцнууд гэмт хэрэг үйлдэх объектив хүчин зүйлийн нэг болж байна.

❖ **Төрийн үйлчилгээ иргэдэд ойртсон байдал**

Эрх зүйн шинэтгэл хийгдэж буй өнөө үед Цагдаагийн байгууллагын бүтэц орон тоог шинэчлэн тогтоож төрийн үйлчилгээ ард иргэдэд ойртсон, гэмт хэрэг, зөрчлийн гомдол, мэдээллийг бүртгэх бүртгэлийн тогтолцоо боловсронгуй болсон мөн иргэдийн эрх зүйн мэдлэг нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд эрхээ хамгаалуулах нь ихсэж гэмт хэргийн тоо нэмэгдэж байна.

❖ **Орлогын түвшин буюу хэрэгцээ:**

Америкийн сэтгэл судлаач А.Х. Маслоугийн “Хэрэгцээний тухай онол”-оор хүнд физиологийн, аюулгүй байдал, амьдралын, нийгмийн, хүндлэл хариуцлагын, авьяас чадвараа хөгжүүлэх гэсэн 5 хэрэгцээ хүн бүрт заавал байх учир хэрэгцээгээ хангах зорилгоор гэмт хэрэг үйлддэг байна. Хүн хэрэгцээгээ хангаж хүрэлцэхүйц орлогогүй, иргэдийн орлого нь амьдралын наад захын хэрэгцээг хангах боломжгүй, “Хүүхдийн мөнгө”-өөр амьдралаа залгуулдаг айл өрхийн тоо их, ажилгүйдэл, архидалтын түвшин өндөр хэмжээнд, буурахгүй байна.

❖ **Хувь хүний зан төлөв ухамсар:**

XX зууны сэтгэгчдийн нэг болох Австрийн мэдрэлийн эмч Зигмунд Фрейд: “Сэтгэц задлан шинжлэлийн онол”-ын дагуу хүний ухамсрын:

- Ухамсарт
- Ухамсрын өмнөх түвшин
- Ухамсарт бус гэсэн 3 түвшин байх бөгөөд үүний 3 дах болох ухамсарт бус түвшин нь хүний үл ухамсарлагдахуйд хадгалагдах буюу өмнөх мартсан таагүй дурсамж нь сэдэрч гэмт хэрэг үйлдэх шалтгаан болж байна.

❖ **Нийгмийн сэтгэл зүй:**

Гэмт хэргийн гаралтанд нийгмийн сэтгэл зүй дасан зохицож, хүлээн зөвшөөрч байх ёстой зүйл гэж хүлээн авах хандлага, гэмт зан төлөв төлөвшсөн хүмүүсийн хувьд гэмт хэргийг амьдралын эх сурвалжаа болгох явдал нь дадал зуршил болсон байна. Гэмт хэргийн талаар иргэд айх цочирдох, сонор сэргэгээр хүлээн авах, сэрэмжлэх байдал буурч байна.

❖ **Цахим ертөнц:**

Иргэд цахим мэдээллээр хангагдах, техник хэрэгсэл ашиглах, мэдээлэл солилцох, сүлжээнд орох зэргээр хувийн мэдээллээ алдах, улмаар кибер гэмт хэргийн хохирогч болох явдал гарсаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим мэдээлэл нь ихэвчлэн нийгмийн хар бараан амьдрал, гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл байгаа нь өсвөр насны залуучууд, хүүхдийн ёс суртахуун, зан төлөв, хүмүүжилд сөргөөр нөлөөлж байна.

❖ **Гэр бүлийн хүмүүжил:**

Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нар хүүхдийг хараа хяналтгүй орхих, хулгайлах гэмт хэрэг үйлдүүлэх, хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүүхдээ өмөөрөх, хаацайлах, гол буруутан нь төр засаг түүний явуулж буй алдаатай үйл ажиллагаанаас болсон мэтээр тайлбарлах явдал цөөнгүй байна.

❖ **Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чанар:**

Иргэдээс төлбөртэй мэдээлэл авах, тодорхой төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх нэгжийн бүтэц орон тоог нэмэгдүүлэх, мэргэшүүлэх, орчин үеийн техник хэрэгсэл ашиглах ажлыг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах нь зүйтэй юм. АНУ-д бүртгэгдсэн гэмт хэргийн 40 орчим хувийг иргэд мэдээлдэг гэсэн судалгаа бий. Гэмт хэргийн талаар мэдээлэл өгсөн иргэдэд тусгай сангаас урамшуулал олгодог. Цаашид Гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, мэргэшсэн багийн үйл ажиллагаатай уялдуулах, гэмт хэрэгтэй тэмцэх ажил нь дан ганц цагдаагийн байгууллагын чиг үүрэг гэж үздэг хандлагаас татгалзах шаардлагатай.

❖ **Хохирогчийн буруутай үйл ажиллагаа:**

Иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажилтнуудын сонор сэрэмжгүй болон хайхрамжгүй, хариуцлагагүй байдлууд ч гэмт хэрэг гарах таатай хөрс болж байна.

Гэмт хэргийн гаралтын хэтийн төлөв байдал:

Дээрх шалтгаан нөхцөлийг харгалзан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг оновчтой төлөвлөх шаардлагатай бөгөөд дараагийн 5 жилийн гэмт хэргийн прогноз буюу хэтийн төлөвийг жилийн дунджийг харгалзан дараах байдлаар таамаглан дэвшүүлж болно. Тухайлбал: 2018 онд 31740, 2019 онд 33041, 2020 онд 34395 болж нэмэгдэх төлөв ажиглагдаж байна.



Монгол Улсад 2015 оны 11 сарын байдлаар гэмт хэргийн гаралт 2.5%-ийн өссөн нь сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулж үзвэл хамгийн бага хувиар өссөн байна. Энэ өсөлт 10% доторх өсөлт бол хэвийн өсөлт, 10-15%-ийг өсөлттэй, 15-30%-ийг огцом өсөлттэй, 30%-иас дээш хувийг аюултай буюу илүү анхаарах шаардлагатай өсөлт гэж үздэг. Иймээс 2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийн өнгөрсөн оныхоос 2.5%-иар өссөн үзүүлэлт нь хэвийн өсөлт бөгөөд хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр гэмт хэрэг огцом өсөж байна, эрүүгийн нөхцөл байдал хүндэрсэн гэх мэдээ, мэдээллүүд нь таамаг төдий, хувь хүний үзэл бодол болох нь дээрх судалгаанаас харагдаж байна.

Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага өөрчлөгдөж байгаа өнөө үед гарч байгаа гэмт хэрэг, үйлдэгдэж байгаа шалтгаан нөхцөлд ч өөрчлөлт гарч, гэмт хэргийн үйлдэж буй арга, зэвсэг хэрэгсэл, сэдэлт нь харгис, хэрцгий шинжтэй болж, гэмт хэргийн нийгмийн хор аюул нь улам бүр өсөн нэмэгдэж, тэдгээртэй тэмцэх арга, хэрэгсэл, урьдчилан

сэргийлэх ажлыг шинэ түвшинд гаргах, тийм арга барилд шилжүүлэх цаг үе бидний өмнө тулгараад байна.

2015 оны эхний 11 сарын байдлаар урьд нь шүүхээр ял шийтгэгдсэн 1268 хүн дахин гэмт хэрэгт холбогдсон ба сард дунджаар урьд нь ял шийтгэгдсэн 115 хүн гэмт хэрэгт холбогджээ. Өршөөл үзүүлэх тухай хуулиар 11 дүгээр сард 2071 ялтан суллагдсанаас хойш өнөөг хүртэлх хугацаанд 125 хүн буюу 6% нь гэмт хэрэгт холбогдсон байна. Хорих байгууллагаас суллагдасдын хувьд нийгмийн тодорхой байр суурьгүй, ажил эрхлэлт муу, тодорхой орлогын эх үүсвэргүй, боловсролын түвшин хангалтгүй, суллагаад нийгмийн харилцаанд ухамсартайгаар оролцох чадваргүйгээр дахин гэмт хэрэг үйлдэн ял шийтгэгдэж байх тул тэднийг нийгмээс тусгаарлахгүй, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн зохист амьдралд ороход туслах зорилгоор Монгол Улсад пробаци²-н үйл ажиллагааг судлан хөгжүүлэх шаардлагатай.

ХҮҮХДИЙГ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

Д.Анхзаяа

*ХСИС-ийн Хилийн сургуулийн лаборант,
ахлагч, магистрант*

Хүүхэд гэнэн томоогүй зан, өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн агуулга, мөн чанарыг ойлгохгүй, бусдын нөлөөнд амархан автдаг зэргээс шалтгаалан гэмт хэрэг үйлдэх явдал цөөнгүй байдаг.

Америкийн нэгдсэн улсын эрдэмтдийн судалгаагаар хүүхдүүд хүний юмыг зөвшөөрөлгүй авах, дүрсгүйдэх, хэн нэгнийг шоглох зэргээр жижиг зөрчлийг ихээхэн гаргадаг ч цаашид 70-80 хувь нь дахин зөрчил гаргадаггүй байна. Тодорхой хэмжээний алдаа гаргах нь хүүхдийн өсөх явцад хэвийн үзэгдэл бөгөөд чангаар шийтгэх нь хүүхдийг гэмт хэрэг үйлдэхэд улам түлхдэг. Өсвөр насны хүүхдийг хууль дээдэлдэг бие хүн, гэмт хэрэгтэн болгох эсэх нь тэдэнтэй хууль зүйн хүрээнд хэрхэн харьцахаас ихээхэн шалтгаалдаг.

Хүүхдийг гэмт хэрэгтэн хэмээн “цоллох” нь тэднийг зохисгүй байдлаар бие авч явах байдалд хүргэдэг. Судалгаагаар цагдаагийн албан хаагч өсвөр насны хүүхэдтэй зүй бусаар харьцсан, гэмт хэрэгтэн гэж нэрлэж, хорих ял эдэлж байсан хүүхдүүд нийгэмд өсөрхөх, харгис авир гаргах, дахин гэмт хэрэг үйлдэх магадлал илүү болох нь тогтоогдсон. Хүүхэд гэмт хэрэг үйлдэх явдлыг таслан зогсоох хялбар арга байхгүй тул дэлхийн улсууд туршлагаа солилцож, суралцаар байна.

Хүүхэд гэмт хэрэг үйлдэх явдлаас урьдчилан сэргийлэх хамгийн үр дүнтэй бодлого, арга замыг НҮБ-ын Хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн чиглэл (Риядын үндсэн чиглэл)-д тусгасан байдаг. Энэ баримт бичигт хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхийн тулд хүүхэд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн нийгмийн үндсэн шалтгаан, нөхцөлд анхаарлаа хандуулах талаар заажээ. Дэлхийн улсуудын засгийн газраас

² Пробаци гэж **probatio** гэсэн латин үгнээс гаралтай ба Монгол хэлээр туршилт гэж орчуулагдах бөгөөд хорих ял эдлүүлэх үйл ажиллагааны явцад ялтныг гэмт хэрэгтэн бие хүн болж өөрчлөгдөхөөс урьдчилан сэргийлэх, улмаар нийгмийн харилцаанаас тусгаарлахгүйгээр гэмт зан үйлийг өөрчлөх, нийгмийн амьдралд дасан зохицуулан дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор Европын улс орнуудад XIX зууны сүүлчээр нэвтрүүлэн хөгжүүлжээ.

өсвөр насны хүүхдийг хөгжүүлэх, эрүүл аюулгүй амьдрах орчинг бүрдүүлэхэд дэмжих аливаа хөтөлбөрийг боловсруулах талаар заасан.

Хүүхэд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх хамгийн шилдэг арга бол хүүхдийн эрхийг хамгаалах, мэргэжил, боловсрол эзэмшүүлэх, сургууль завсардах, тэнүүчлэхээс сэргийлэх, эцэг, эхчүүдийн хараа хяналтыг сайжруулах, хүүхэд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэх газруудыг нэмэгдүүлэх, цагийн ажлын байр бий болгох, нийгмийн халамж, эрүүл мэнд, эрх зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх зэргээр нийгмийн хөгжлийг түргэтгэх өргөн хүрээтэй арга хэмжээ авах, ажилгүйдэл, ядуурал зэрэг гэмт явдлын суурь шалтгааныг багасгах явдал юм. Түүнчлэн, гэр бүл, нийгэм, найз нөхөд, сургууль, мэргэжлийн сургалтад хамруулах зэргээр бүх хүүхдийг нийгмийн амьдралд эргэн орох нөхцлийг бүрдүүлэхэд илүү анхаарах нь зүйтэй.

Төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран дараах ажил, арга хэмжээг зохион байгуулах нь зүйтэй:

- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг нийгэм хамт олонд тулгуурласан үйлчилгээ хөтөлбөрөөр дамжуулан зохион байгуулах;
- Хүүхдэд хорих ял оногдуулахаас аль болох татгалзах, эсхүл хамгийн эцсийн арга хэмжээ болгон авах;
- Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлж, хүүхэд гэр бүлийн орчинд хүмүүжих нөхцлийг бүрдүүлэх;
- Хүүхдийг тэнүүчлэхээс сэргийлэх, эцэг, эх, сурган хүмүүжүүлэгчийн хяналтыг нэмэгдүүлэх;
- Хүүхэд сургууль завсардахаас сэргийлэх, албан бус боловсрол, мэргэжлийн сургалтад хамруулах, туслалцаа үзүүлэх;
- Хүүхдэд гэмт хэргийн золиос болох, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл олгох ажлыг зохион байгуулах-зэрэг болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагаас гадна төрийн бус байгууллага, гэр бүл, сургууль, хэвлэл мэдээллийн байгууллага, иргэний оролцоо чухал үүрэгтэй тул гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, суртчилгааны ажлыг тэдгээрийн оролцоонд түшиглэн тогтмол явуулах шаардлагатай.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа гэмт хэргийн талаарх мэдээлэл нь гэмт хэргийн үйл явцыг нэг бүрчлэн мэдээлж байгаа нь хүүхдийг гэмт хэргээс сэргийлэхэд бус харин гэмт үйлдэлд суралцах, үйлдэх сэдлийг өдөөгч хүчин зүйл болох тохиолдол гарсаар байна.³

Өсвөр насны хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэвлэл, мэдээллийн хэрэгслийн дараах үүрэгтэй:

- Гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, нийгмийн хор аюулыг олон түмэнд таниулах, сэрэмжлүүлэх;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнийг таслан зогсоохтой холбогдсон шуурхай мэдээллийг эрх бүхий байгууллагын хүсэлтээр яаралтай нэвтрүүлэх;
- Хүчирхийлэл, аллага, садар самуун, гэмт хэрэг үйлдэхийг сурталчилсан, гэмт хэрэг үйлдэх аргыг нарийвчлан харуулсан нийтлэл, нэвтрүүлэг хийхгүй байх;
- Шүүхээр гэм буруутай нь нотлогдоогүй байхад хэнийг ч гэм буруутай гэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэхгүй байх-зэрэг болно.

³ Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудал. УБ., 52 дахь тал

Хүүхдийг нийгэмшүүлэх, нөхөн сэргээх хууль зүйн үйлчилгээ

Гэмт хэрэг үйлдсэн, хорих ял эдлээд суллагдсан хүүхдийг нийгэмшүүлэх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд анхаарах шаардлагатай. Риядын зарчимд хүүхдийг нийгэмшүүлэх үйл явцыг дараах чиглэлээр тодорхойлсон:

1.Гэр бүлийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх:

- Гэр бүл болон гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангах гэр бүлийн сайн сайхан байдалд анхаарах;
- Хүүхдийн өсөж хөгжих хамгийн таатай орчин нь гэр бүл гэдгийг анхаарч хүүхдийг гэр бүлээс нь аль болохоор тусгаарлалгүйгээр асуудлыг шийдвэрлэх, хамт байлгах боломжийг бүрдүүлэн, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх;
- Хүүхдийг нийгэмд гүйцэтгэх үүрэг, байр суурийг хүлээн зөвшөөрч, тэдний оролцоог хангах, тэдний үерхэл нөхөрлөл, үзэл бодлыг хүндэтгэн үзэх;

2.Олон нийтийн оролцоонд тулгуурлах:

- Хүүхэд залуучуудад дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн байгууллагатай хамтран ажиллах;
- Боловсролын байгууллагууд сургууль завсардсан хүүхдэд дэмжлэг үзүүлэх, сургалтад хамруулах, мэргэжил, боловсрол эзэмшүүлэх;
- Орон гэргүй, өөрийн гэр бүлд амьдрах бололцоогүй хүүхдийг халамжийн төв зэрэг газарт байрлуулан амьдрах орон байраар хангах;
- Хүүхэд, залууст чиглэсэн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх;

3.Хэвлэл, мэдээллийн хэрэгслийг ашиглах:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслийг хүүхэд залуусын нийгэмд гүйцэтгэж байгаа эерэг нөлөөг сурталчлахад чиглүүлэх;
- Садар самуун, хүчирхийллийг үзүүлэх, сурталчлахаас зайлсхийх;
- Хүүхэд эмэгтэйчүүдийн талаар мушгин гуйвуулсан сөрөг мэдээлэл тараахаас зайлсхийх;

Хүүхэд, гэр бүлийн хэрэг, маргааныг дагнан шийдвэрлэх шүүх байгуулах:

Хүүхдийн болон гэр бүлийн хэрэг, маргааныг дагнасан шүүхээр хянан шийдвэрлэх нь олон улсын жишигт нийцэх бөгөөд энэ нь үр дүнтэй болох нь олон улсын туршлагаас харагдаж байна. Тухайлбал, 1997 онд Филиппин улс гэр бүлийн шүүх байгуулсан бөгөөд тухайн шүүх:

- Асран хамгаалагч, харгалзан дэмжигчи тогтоох;
- Хүүхэд үрчлүүлэх;
- Эцэг, эх байх эрхийг түдгэлзүүлэх, хасах,
- Гэр бүлийн хүчирхийллийн асуудлыг хянан шийдвэрлэдэг.

Тухайн шүүхээс гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдсэн болох нь тогтоогдсон хүүхдэд ял оногдуулахаас гадна, дараах албадлагын арга хэмжээ хэрэглэдэг бөгөөд хэрэг маргааныг хянан шийдвэрлэхдээ хүүхдийг аль болох нийгэм хамт олны дотор засрах, хүмүүжүүлэх боломжийг олгоход чиглэдэг байна.

- Халамжийн төвд байрлуулах;
- Зөвлөгөө өгөх;
- Итгэл үзүүлэх;
- Барьцаа авч суллах;
- Олон нийтэд суурилсан хөтөлбөрт хамруулах зэрэг болно.

Монгол Улсад хэдийн гэр бүлийн дагнасан шүүх байхгүй боловч эрх зүйн шинэчлэлийн хүрээнд боловсруулагдаж, 2015 онд УИХ-аас баталсан Эрүүгийн хуульд өсвөр насны хүнд оногдуулах ялын төрөл, ял оногдуулах журам, түүнд хэрэглэх албадлагын арга хэмжээг тусгай бүлгээр зохицуулж өгсөн. Ингэснээр өсвөр насны хүний бие, сэтгэл зүйн онцлогийг харгалзан насанд хүрэгчдээс ялгамжтай ял оногдуулах, аль болох хорих ял оногдуулахаас зайлсхийж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг үр дүнтэй хэрэглэж, нийгэм, хамт олны дунд хүмүүжүүлэх боломж бүрдэнэ.

Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар, шүүх ердийн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж, нэгээс гурван жил хүртэл хугацаагаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авахаар заасан.⁴ Эндээс үзэхэд, насанд хүрээгүй хүнд оногдуулах ялын бодлого зөөлөрч, хүүхдийн эрхийг баталгаажуулах, хохирогчийн эрхийг сэргээн тогтоох, шударга ёсны тогтолцоо бүрдүүлэх эрх зүйн үндсийг улам бэхжүүлж, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхах нөхцөл бүрдэхээр байна.

Ном зүй

- Ш.Дуламсүрэн. Эрх нь хөндөгдсөн хүүхдийн хөгжил хамгааллын асуудлууд. УБ., 2008
- “Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл” судалгааны тайлан. УБ., 2006
- Хүүхэд-хөгжил. УБ., 2011
- Насанд хүрээгүй хүмүүсийн гэмт явдлын шалтгаан судлалын асуудалд. УБ., 2004

⁴ Эрүүгийн хууль. УБ., 2015

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Ж.Батням

Хууль сахиулахын их сургуулийн магистрант

ХЭРЭГЛЭГЧИЙГ ХУУРЧ МЭХЛЭХ, ТӨӨРӨГДҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙГ МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

Монгол Улсад 1990-ээд оноос нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санаанд эргэлт гарч, олон ургальч үзэл дэлгэрэхийн хирээр гэмт хэргийн бүтэц өөрчлөгдөж, өмнө огт үйлдэгдэж байгаагүй болон цөөн үйлдэгддэг байсан гэмт хэрэг цөөнгүй үйлдэгдэх болж, гэмт хэргийн субъект, үйлдлийн арга ч өөрчлөгдсөөр байна.

Зах зээлийн эдийн засагт шилжсэнтэй холбогдуулан хэрэглэгчийн эрх ашиг ихээр хөндөгдөх болж, энэ ч үүднээс 2003 оны 12 дугаар сарын 26-ны өдөр УИХ-аас Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль баталсан. Гэвч хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх, хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд гэм хор учруулах явдал байсаар байна. Иймд энэ төрлийн гэмт хэргийг Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжид хуульчилж ирсэн байдалд харьцуулсан судалгаа хийж, дүгнэлт боловсруулав.

Монголын ард түмэн төрт ёсны үзэл, хууль цаазын сэтгэлгээний 2200 гаруй жилийн уламжлалтай. Одоогоор бидэнд олдоод буй хууль цаазын эх сурвалжуудаас үзэхэд, хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх гэмт хэргийг Монголын эртний улсуудын болон Их Монгол Улс, Юан улс, Эзэнт гүрний бутралын үе, Манжийн ноёрхлын үеийн эрүүгийн хууль тогтоомжуудад хуульчлаагүй байна.

Богд хаант Монгол Улсын үед /1913-1919 он/ “Таван яам хамт нийлж хувьсган тогтоож айлтгаад, одоогийн дагаж шийтгүүлэн буй хууль дүрмийн дэвтэр бичиг” буюу “Жинхэнэ дагаж явах хууль, дүрэм” хэмээх 12 зүйл бүхий эрх зүйн актыг эмхтгэн мөрдөж байсны дотор дамын наймаа хийхтэй холбоо бүхий харилцааг зохицуулсан 1917 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн **“Аливаа чинээ бүхий наймаачин хүн нар хөдөө газраас ирэх хонь, мал, тос, өвс, түлээг зам тосон авах тухай цаазлан зогсоосон тухай дүрэм”**-д дараах байдлаар заасан:

Долоодугаар зүйл. Аливаа хүн жинлүүр жинг дураар хүнд, хөнгөнийг хэрэглэх нь их л завших хохироход хүрсний дээр харилцан хэрүүл шуугиан өдүүлэхийн тул хуучин дүрмийн ёсоор үнэхээр арван зургаан ланд нийлэлцэхэд тодорхойг нь хэрэглүүлэхээс гадна оросын пуд хэмээх тэгнүүр болбоос бага завших хохироход үл хүрэхийн тул адилхан тэгнүүр үйлдүүлж зээл ба пүүсийн зэрэг газарт байгуулан хэрэгжүүлж хүнд, хөнгөн жингээр мөлжих муу суртлыг арилгаж цаазалсугай. Хэрвээ зөрчин явагчид буй аваас уг жинг албанаа хураан авч мал тосон авагчдын нэгэн адил цээрлүүлэн шийтгэе.

Наймдугаар зүйл. Будаа, арвайн гурилын зэрэг юмыг чухам нэг жингийн шанагаар хэмжээлэн худалдахаас гадна дураар зүй бусын бага шанага үйлтгэж хэрэглэн шалтгаацин үлэмж үнэ нэмэн худалдваас цөм цаазалсныг зөрчигсдийн нэгэн адил шийтгүүлсүгэй.

Хоёрдугаар зүйл. Цаазалсныг зөрчиж зам тосож худалдан авсан хойно нэгэнт байцаан гарч ирвээс даруй чангалан шүүж тодорхойлон мөнхүү авсан зүйл үлэмж цөөнийг бодох үгүй жаран хоног гянданд хорьж, наян ташуур занчиж цээрлүүлэн уул мал юмын нэгэн дундуурыг уг эзэн хүнд олгож нэгэн дундуурыг албанд хурааж, хураасан зүйлийн

нэгэн дундуурыг байцаан гаргасан хүнд шагнасугай. Замд худалдсан эзэн хүнийг жар хоног гянданд хорьж, наян ташуур жанчиж цээрлүүлсүгэй.

1921 оны Ардын хувьсгал нь жинхэнэ ард түмний хүсэл зоригийг илэрхийлсэн шинэ эрүүгийн эрх зүй үүсч хөгжих эхлэлийг тавьсан. Улсын анхдугаар их хурал 1924 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр нээгдэж улс орны тулгамдсан олон асуудал шийдвэрлэсний дотор тус улсын анхны Үндсэн хуулийг 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр батлан гаргаж, хувьсгалын ялалтыг хуульчлан бэхжүүлж, ард түмний ардчилсан эрхийг тунхаглан зарлаж өгсөн нь хувьсгалт эрүүгийн эрхийн үндсэн бааз гол эх сурвалж болсон юм.⁵

Монгол Улсын анхны Эрүүгийн хууль буюу Шүүх цаазын бичгийн ерөнхий ангийг 1926 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр 6 бүлэг 41 зүйлтэй, тусгай ангийг 1926 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 24 бүлэг 187 зүйлтэй баталж, хэрэгжүүлсэн энэ түүхэн цаг мөч нь Монгол Улсын нийгэм дэх эрүүгийн эрх зүйн харилцааг бие даасан Эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр зохицуулах болсон түүхэн ач холбогдолтой үйл явдал юм.⁶

Тус хуулийн хорьдугаар бүлэгт **“Аливаа хэмжээ, жинлүүрийг хуурамчаар үйлдэх”**-тэй холбоотой гэмт хэргүүдийг хуульчилсан.

144 дүгээр зүйл: Аливаа тогтоосон хэмжээ, жинлүүрийг санаатайгаар өөрчлөн үйлдэж худалдааны газар хэрэглэгсэд буюу бусад худалдагсадыг 1-3 жил хүртэл гяндан хорих буюу 600-1800 төгрөг хүртэл торговоос зохимой.

145 дугаар зүйл: Аливаа худалдаачин хуурамч жинлүүрийг нуун далдалваас 3 сар хүртэл гяндан хорих буюу 150 төгрөг хүртэл торговол зохино.

146 дугаар зүйл: Аливаа худалдаачин хүн хэмжээ жинлүүрийг тогтоосон ёсоор үйлдсэн боловч албаны газрын тэмдэг даруулалгүйгээр хэрэглэвэл 3 сар хүртэл хорих буюу 150 төгрөг хүртэл торгоно.

1929 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн Засгийн газрын 30 дугаар хурал, Улсын 14 дүгээр бага хурал, Шүүх цаазын бичгийг шинэчлэн найруулж батлан мөрдөж эхэлснээр 1926 оны Шүүх цаазын бичиг хүчингүй болсон байна. 1929 оны Шүүх цаазын бичиг нь 1926 оны Шүүх цаазын бичгийн систем, зохион байгуулалтад үндсэн өөрчлөлт оруулаагүй хэрэглэхэд хялбар болгож сайжруулсан нь хуулийг бүхэлд нь шинээр батлах шалтгаан болсон.⁷

1929 оны Шүүх цаазын бичгийн арван есдүгээр бүлэгт **“Аливаа хэмжээ, жигнүүрийн хуурамчаар үйлдэх”**-тэй холбоотой гэмт хэргүүдийг хуульчилсан.

146 дугаар зүйл: Аливаа тогтоосон хэмжээ, жигнүүрийг санаатайгаар өөрчлөн үйлдэж худалдааны газар хэрэглэсэн буюу бусад худалдагсадыг 6 сараас 2 жил хүртэл хорих буюу 300-1200 төгрөг хүртэл торговоос зохимой.

147 дугаар зүйл: Аливаа худалдаачин хуурамч хэмжээ, жигнүүрийг нуун далдалваас 100 хоног хүртэл хорихгүйгээр албадан ажил үйлдвэр хийлгэх буюу 100 төгрөг хүртэл торговоос зохимой.

148 дугаар зүйл: Аливаа худалдааны хүмүүн хэмжээ жигнүүрийг тогтоосон ёсоор үйлдсэн боловч албаны газрын тэмдэг даруулалгүйгээр хэрэглэвээс 100 төгрөг хүртэл торговоос зохимой.

1929 оны Шүүх цаазын бичигт элдэв гэмт хэргүүдийг бүлэг бүрийн зохих зүйлүүдэд хутгалдуулан бичсэн, хувьсгалд тэрсэлсэн гэмт хэргүүдийг хэдэн бүлэг болгон

⁵ Г.Совд. Дурдсан зохиол. УБ., 1973. 55 дахь тал

⁶ Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971. 42 дахь тал

⁷ Б.Содовсүрэн. БНМАУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн хөгжилт. УБ., 1971. 48 дахь тал

бичсэнээс гадна аж ахуй ба албан тушаал ялангуяа хурьцалын гэмт хэргүүдийн ялыг хөнгөн заасан дутагдлууд гарсан учир ерөнхий ангийг 1934 оны 05 дугаар сарын 04-нд Сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж мөн сарын 24-нд Улсын бага хурлын тэргүүлэгчдээс 6 бүлэг 41 зүйлтэйгээр, тусгай ангийг 8 бүлэг 113 зүйлтэйгээр 1934 оны 08 дугаар сарын 24-нд сайд нарын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, мөн оны 10 дугаар сарын 08-нд Улсын бага хурлын Тэргүүлэгчдээс баталжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1934 оны 5 дугаар сарын 4-ны өдрийн 13 дугаар хурал, Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 5 дугаар сарын 24-ний 17 дугаар хурлаар Шүүх цаазын бичгийг шинэчлэн баталсан. Уг хуулийн 89 дүгээр зүйлд: ***Худалдааны явцад хэрэглэгдэх хэмжээ жигнүүрийг зөвшөөрөл үгүйгээр үйлдэх, түүнчлэн тэмдгийг даруулж батлуулахгүйгээр зарж худалдсан*** бол 1 жил хүртэлх хугацаагаар хорих буюу 1200 төгрөг хүртэл торгох ял шийтгэвэл зохино. ***Зохих тэмдэг үгүй жигнүүрийг хэрэглэсэн*** бол 300 төгрөг хүртэл торгож ял шийтгэвэл зохино.

1940 оны 06 дугаар сард хуралдсан 8 дугаар Ардын Их хурал БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг шинэчлэн баталж, улмаар 1942 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр БНМАУ-ын 25 дугаар бага хурлаас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийг 6 бүлэг 54 зүйл, тусгай ангийг 10 бүлэг 171 зүйлтэйгээр баталжээ. Энэ хуулиар нийгэм, төр, байгууллага, иргэдийн өргөн агуулгатай эрх ашиг, сонирхлыг хамгаалалтад авсан бөгөөд өмнөх хуулиудтай харьцуулбал тогтолцоо, бүтцийн хувьд илүү боловсронгуй болжээ. БНМАУ-ын Эрүүгийн хуулийн зургаадугаар бүлэгт “Аж ахуйн гэмт хэргүүдийг хуульчилсан. Тухайлбал,

145 дугаар зүйл: Худалдаа хийхэд буруугаар хэмжих жигнэх зэрэг худалдан авагчдыг мэхлэх, түүнчлэн юм худалдахад зөв бус хэмжүүр жигнүүр годил болон бусад жин хэмжүүрийн зүйлүүдийг хэрэглэх дэлгүүр, мухлаг, хоолны гуанз зэрэг газар өргөн хэрэглэгдэхүүний барааны жижиглэн худалдаалах үнийг зөрчих, эсвэл доод чанар дугаарын барааг дээд чанар дугаарын үнээр худалдах, мөн худалдан авагчаас барааны үнийн жагсаалтыг санаатайгаар дарагдуулах бол таван жил хүртэл хугацаагаар хорих ба хэрэв хөнгөтгөх шалтгаан байвал нэг жил хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэж шийтгэвэл зохино.

БНМАУ-ын Их хурлын 4 дэх удаагийн сонгуулийн анхдугаар чуулган 1960 оны 07 дугаар сарын 06-нд манай улсын түүхэн дэх гурав дахь Үндсэн хуулийг баталсан. Энэ суурь хуульдаа Эрүүгийн хуулийг нийцүүлэн боловсруулж, 1961 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн Ардын Их хурлын 2 дугаар чуулганаар баталж, мөн оны 04 дүгээр сарын 1-нээс дагаж мөрдсөн түүхтэй.

1961 оны Эрүүгийн хуулийн зургаадугаар бүлэгт “**Социалист аж ахуйн эсрэг гэмт хэрэг**”-ийг хуульчилсан:

129 дүгээр зүйл. Буруу жигнэх, хэмжих зэрэг бусад хэлбэрээр худалдан авагчдыг хууран мэхлэх

А.Дэлгүүр, мухлаг, гуанз болон худалдааны ба нийтийн хоолны бусад газруудад буруу хэмжих, жигнэх, жижиглэн худалдах үнийг нэмэх, буруу бодох, түүнчлэн худалдан авагчдыг бусад аргаар санаатай хууран мэхэлбэл хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар худалдааны ба нийтийн хоолны газарт ажиллах эрхийг хасах буюу олон нийтийн арга хэмжээ авахуулна.

Б.Энэ гэмт хэргийг их хэмжээгээр үйлдсэн, эсхүл худалдан авагчдыг хууран мэхэлсэн хэрэгт урьд шийтгэгдсэн этгээд үйлдсэн бол хөрөнгийн заримыг буюу бүгдийг хураах, эсхүл хураахгүйгээр хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорьж шийтгэнэ.

1961 оны Эрүүгийн хуулийн олон хэм хэмжээ гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тухайн үеийн шаардлагад илтэд нийцэхгүй болсон, төр, нийгэм, иргэдийн амин чухал олон эрх ашиг Эрүүгийн хуулийн хамгаалалтын гадна үлдсэн нь хийдэл үүсэх шалтгаан болсныг 1983 оны МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 316 дугаар тогтоолд тэмдэглээд гэмт хэрэгтэй тэмцэх үүрэгтэй хуулиуд тэр тусмаа Эрүүгийн хуулийг хоёр жилийн дотор шинэчлэх батлах талаар өгсөн шийдвэр заалтыг хэрэгжүүлэх хүрээнд энэ хуулийг БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 1986 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 217 дугаар зарлигаар шинэчлэн найруулж, ерөнхий ангийг 5 бүлэг 59 зүйлтэй, тусгай ангийг 13 бүлэг 242 зүйлтэйгээр баталж, 1987 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн.

Тус хуулийн зургаадугаар бүлгийн 170 дугаар зүйлд **“Худалдан авагч, захиалагчийг хуурч мэхлэх”** гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан:

1. Худалдаа, нийтийн хоол, нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний газарт барааг дутуу хэмжих, жинлэх, дүнг өсгөж бодох, жижиглэн худалдах үнэ, түүнчлэн хүн амд үзүүлдэг нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний үнэ, тарифийг өсгөх бусад аргаар худалдан авагч, захиалагч иргэдийг хуурч мэхэлсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих, нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хоёр мянга хүртэл төгрөгөөр торгох, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар худалдаа, нийтийн аж ахуй, ахуй үйлчилгээний газарт тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах ял шийтгэнэ.
2. Энэ үйлдлийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд буюу их хэмжээтэй, эсхүл худалдан авагч, захиалагч иргэдийг хуурч мэхэлсэн хэрэгт урьд ял шийтгэгдсэн этгээд хийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, худалдаа, нийтийн хоол, нийтийн аж ахуй, ахуй үйлчилгээний газарт тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасаж хоёроос зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай 1990 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталсан хуулиар 170 дугаар зүйлд заасан “Худалдан авагч, захиалагчийг хуурч мэхлэх гэмт хэрэг” багтсан зургаадугаар бүлгийн “Социалист аж ахуйн эсрэг гэмт хэрэг” гэсэн гарчгийг “Аж ахуйн эсрэг гэмт хэрэг” гэж өөрчилсөн нь зах зээлийн эдийн засагт шилжихтэй холбоотой өмчийн олон хэлбэрийн тэгш байдлыг хангахтай холбогдуулан оруулсан өөрчлөлт юм.

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1993 оны 02 дугаар сарын 15-ны өдөр баталсан хуулиар 170 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулахаар заасан торгох ялын хэмжээг өөрчилсөн⁸.

1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн бусад хуулийг бүхэлд нь шинэчлэх шаардлагатай уялдуулан УИХ-аас 1993 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Энэ хуулийн зургаадугаар бүлгийн /аж ахуйн эсрэг гэмт хэрэг/ 170 дугаар зүйлд **“Хэрэглэгчийг хуурч мэхлэх”** гэмт хэргийг дараах байдлаар хуульчилсан:

⁸ Б.Баярсайхан, С.Жанцан нар. “Монгол улсын эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал 1911-2009”. УБ.2011.629 дэх тал

1. Худалдаа, үйлчилгээний болон бусад байгууллагад барааг дутуу хэмжих, жинлэх, дүнг өсгөж бодох, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан эсхүл буруу заалттай хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатайгаар өөрчлөх буюу бусад аргаар хэрэглэгчийг их хэмжээтэй буюу удаа дараа хуурч мэхэлсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр нэг жил зургаан хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу жаран мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
2. Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд буюу онц их хэмжээгээр үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.-гэж заасан.

ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Б.Эрдэнэбилэг
ЦЕГ-ын Судалгаа, дүн шинжилгээний төвийн
дарга, цагдаагийн хурандаа

МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛД

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу 1992 оны УИХ-ын 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсад нийгмийн дэг журмыг хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл” баримт бичигт “...эдийн засаг, нийгэм, улс төрийн бүхий л хүрээнд хуулийг сахиулах, гэмт хэрэг, эрх зүйн зөрчилтэй тэмцэхэд чиглэсэн эдийн засаг, нийгэм, хууль зүйн цогцолбор арга хэмжээ авч хэрэгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон.”⁹

УИХ-аас 1998 онд баталсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-т хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах, хууль зүйн орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд 2002 онд Эрүүгийн хууль тогтоомж шинэчлэгдсэн билээ.¹⁰

2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар “Эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх хөтөлбөр”-ийг Ерөнхийлөгчийн Тамгын газраас боловсруулсныг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хурлаар дэмжиж улмаар 2011 онд “Эрх зүйн шинэчлэл ба шударга ёс” үндэсний чуулганаар мөрдөн шалгах ажиллагааг боловсронгуй болгох шаардлага, тулгамдсан асуудлыг тодорхойлсон.¹¹

“Эрүүгийн бодлого гэдэг нь: Хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх, эрх ашиг, сонирхлыг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор нийгэмд аюултай ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцох, тэдгээрт оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, тэдгээрийг хэрэглэх, эсвэл чөлөөлөх үндэслэл, журмыг тогтоох, түүнчлэн гэмт явдлын шалтгаан, нөхцөлийг судалж тогтоох, энэ үндсэн дээр урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр өгөөжтэй, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагуудын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төгөлдөржүүлэх талаар төрөөс баримталж буй чиглэл, удирдамж юм.

Төрийн эрүүгийн бодлогын агуулга, зорилт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд тусгагдан хэрэгжиж байна. Тухайлбал:

1. Эрүүгийн процессын хуулийг Эрүүгийн хуультай чанд нийцүүлэх, уялдуулах
2. Эрүүгийн процесст хүний эрх, эрх чөлөөг хангах механизмыг хангах
3. Эрүүгийн процессын хуулийг олон улсын эрүүгийн эрх зүйн зохицуулалтад нийцүүлэх

⁹ Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангах талаар гарсан баримт бичгийн эмхтгэл. УБ. 1998. 130-132 дахь тал

¹⁰ ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар Эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох ажилд ихээхэн хүчин чармайлт гарган бүхий л дэмжлэг тусалцаа үзүүлснийг дурдах нь зүйтэй.

¹¹ УИХ-ын 2010.07.15-ны өдрийн 48-р тогтоолоор батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний ...аюулгүй амьдрах... нөхцөлийг бүрдүүлэх ..., гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гээд 3.3.1.5-т “Хүний эрх, эрх чөлөөг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлж, энэ чиглэлд институци хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулна.” гэж заасан.

4. Нийгмийн шаардлагад нийцүүлж хууль хяналтын байгууллагын оновчтой тогтолцоог бий болгох эрх зүйн үндсийг бууруулах
5. Иргэний нэхэмжлэгчийн ойлголтыг нийгмийн хөгжлийн эрэлт шаардлагад нийцүүлэн шинээр тодорхойлох
6. Эрүүгийн процессыг шуурхай болгох
7. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчдийн хариуцлагыг дээшлүүлэх
8. Эрүүгийн процесст баримталбал зохих тодорхой зарчмуудыг шинээр хуульчилж мөрдүүлэх
9. Эрүүгийн процесст оролцогчдыг төрөлжүүлж, түүний эрх үүргийг нарийвчлан тодорхойлох
10. Эрүүгийн процессыг олон үе шат дамжлагагүй ямарч нөхцөлд шуурхай явагдах эрх зүйн орчин бүрдүүлэх зэрэг үзэл баримтлалыг иш үндэс болгох явдал юм. ¹²

XXI зууны Монголын эрх зүйн хөгжил нь ихэнхдээ Эх газрын эрх зүйн тогтолцоог баримжаалж хөгжиж байгаа хэдий ч цаашдаа Англо саксоны эрх зүйн үнэт зүйлсийг нутагшуулах /рецепци/, эрх зүйн конвергенц хийх замаар хөгжих хандлагатай байгаа хэдий ч өөрийн орны өвөрмөц онцлогыг тусгасан уламжлалт, хэдийнээ хэвшсэн эрх зүйн үнэт зүйлсээ уламжлал болгон хадгалан авч хөгжих шаардлагатай байгааг судлаачид илэрхийлдэг.

Үүний тулд “Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх төрийн бодлогыг тодорхойлох стратеги бодлогын баримт бичиг”-ийг эрдэм шинжилгээ судалгааны ажилд тулгуурлан эрх бүхий байгууллагаас батлах хэрэгцээ, шаардлагыг нээн харуулсан “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын мөн чанар, бодит байдал, чиг хандлага” олон улсын эрдэм шинжилгээний хурлаас гаргасан зөвлөмж, саналыг дэмжиж байна.

1. Хууль сахиулах ажиллагаа ба мөрдөн шалгах ажиллагаа

Хууль сахиулах буюу Law enforcement¹³ гэдэг нь ерөнхий утгаараа нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээний гэмт, зөрчлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх, түүнийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон хариуцлага хүлээлгэх нөхцлийг бүрдүүлэх, нийгэмшүүлж, хууль хэрэгжүүлэх зорилгоор явуулж буй нийгмийн тодорхой гишүүдийн зохион байгуулалттай үйл ажиллагаа байна.

Эндээс дүгнэлт хийхэд **хууль сахиулах** гэдэг нь хүний эрх, эрх чөлөөг хангах зорилгоор төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, итгүүлэн үнэмшүүлэх, албадлага хэрэглэх, хариуцлага хүлээлгэх эрх бүхий байгууллага, албан тушаалтны эрх, үүргийн үндсэн дээр хэрэгжиж байгаа тодорхой үйл ажиллагаа юм.

Хууль сахиулах ажиллагааны судлагдахуун болох criminal investigation буюу мөрдөн шалгах ажиллагаа нь “inquisitorial”, “accusatorial” эрүүгийн процессуудын онцлогыг доорхи хүснэгтээр харьцууллаа.

	Англо саксоны эрх зүйн бүлийн “Accusatorial” тогтолцоо	Ром германы эрх зүйн бүлийн “Inquisitorial” тогтолцоо
Эх сурвалж	Шүүхийн шийдвэр нь хууль тогтоомжийн адил эх сурвалж болно.	Хууль тогтоомж нь шүүхийн шийдвэрийн эх сурвалж болно.
Зорилго	Хүний эрхийг хамгаалж бодит үнэнийг эрэлхийлнэ.	Бодит үнэнийг тогтоож хүний эрхийг хамгаална.

¹² С.Жанцан “Гэмт явдалтай тэмцэх төрийн бодлогын мөн чанар, бодит байдал, чиг хандлага” илтгэл тус олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. 14 дэх тал

¹³ http://en.wikipedia.org/wiki/Law_enforcement

Субъект	<i>Талуудын нотлох баримт цуглуулах эрх тэгш байдал хангах, мэтгэлцээний үндсэн дээр шүүх хэргийг шийдвэрлэнэ.</i>	<i>Хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нотлох баримт цуглуулж бодит үнэнийг тогтоох зарчмыг хэрэгжүүлнэ.</i>
Арга	<i>Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан мөрдөн шалгах ажиллагаа шүүхийн хяналтанд хэрэгжинэ. Шүүхээр хэлэлцэгдсэн баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлж шүүх төвийг сахисан байр суурьтайгаар хэргийг талуудын мэтгэлцээний үндсэн дээр шийдвэрлэнэ.</i>	<i>Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад суурилсан яллах, цагаатгах нотлох баримтыг цуглуулах процесс явагдаж бодит үнэнийг тогтоох зорилгоор бүрдүүлсэн хавтаст хэргийг шүүх эцэслэн хянаж шийдвэрлэнэ. Өмгөөлөх талын гомдол, хүсэлт гаргах эрх хуулиар баталгаажна.</i>
Үе шат	<i>Хууль сахиулах байгууллагаас мөрдлөг явуулсны дараагаар гэм буруугаа хүлээсэн хүний хэргийг шуурхай шийдвэрлэх шүүхийн онцгой журмыг хэрэгжүүлдэг. Шүүхээс хэргийг нэмэлт мөрдөн шалгах ажиллагаанд буцаахыг хориглодог бөгөөд талуудын цуглуулсан баримтын хүрээнд хэргийг шийдвэрлэнэ.</i>	<i>Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтанд прокурор хяналт тавьж, шүүхэд хэргийг шилжүүлж шийдвэрлүүлэх, прокурор, шүүхийн даалгавраар дахин мөрдөн шалгах ажиллагаа явуулах процесс явагдана. Шүүхээс өмнөх шатанд прокурор хэргийг хэрэгсэхгүй болгож, шалгах аас татгалзах эрхтэй.</i>

Англо саксоны эрх зүйн бүлийн “accustorial” мөрдөн шалгах ажиллагааг явуулах эрх бүхий албан тушаалтан нь эрх зүйн дүгнэлт хийх үүрэггүй бөгөөд гагцхүү мөрдөн шалгах ажиллагааны үр дүнг нотлох баримтын хэмжээнд цуглуулсан эсэхээ шүүхэд гэрчлэх шаардлагатай тул прокурорын удирдлага дор мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх, хадгалах, хамгаалах талаархи стандарт, аргачлалыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог нь хүний эрхийг хангах зарчим болжээ.


Мөрдөн шалгах ажиллагааны эцсийн үр дүнг хэрхэн үнэлж дүгнэх, уг ажиллагааны явцад бий болсон нотлох баримтыг шүүхэд хэрхэн ашиглах талаар эрүүгийн процессын үе шаттайгаар холбоотойгоор “inquisitorial”, ”accusatorial” эрүүгийн процессын давуу шинжүүдээ харилцан авч ирсэн билээ.¹⁴

2. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын статистик түүнд хийсэн дүн шинжилгээ

2002 оны 9 дүгээр сарын нэгний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЭБШ хууль тогтоомж хэрэгжих явцад Монгол Улсад гэмт хэргийн статистикийн үзүүлэлтийг графикаар үзүүлээ.¹⁵

¹⁴ Ж.Ганбаатар. “Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал, цаашдын чиг хандлага”. илтгэл 2011

¹⁵ Дээрхи статистик үзүүлэлтээр 2007 оноос гэмт хэргийн илрүүлэлтийг нийт бүртгэгдсэн хэргээс бус харин бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих хүн тогтоогдоогүй үзүүлэлтээс тооцох болсон байна.



Статистикийн үзүүлэлт нь хууль эрх зүйн зохицуулалтын алдаа, хийдэл, зөрчил, програмчлал, мэдээллийг оруулж байгаа алба хаагчийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, ажлын үр дүнгээс улбаалсан болон хувийн хариуцлага, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаанаас шалтгаалсан хүчин зүйлүүд нь мэдээллийн бодит байдалд нөлөөлж харьцангуй тоон үзүүлэлтийг бий болгодог.

Дээрхи статистик үзүүлэлтээр 2014 онд 27318 гэмт хэрэг бүртгэгдсний 12585 буюу 46 хувь нь бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцогдвол зохих этгээд тогтоогдоогүй байсан бөгөөд түүний 6949 буюу 55,2 хувийг илрүүлж нийт бүртгэгдсэн хэргийн 7370 буюу 27 хувийг түдгэлзүүлсэн нь мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн үр дүнг илэрхийлж байна.

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахад учирдаг хүндрэл, бэрхшээлийн талаар судалгаанд оролцогчид¹⁶ өнөөгийн мөрдөн шалгах ажиллагааны дараах тулгамдсан асуудлыг дурьджээ.



3. Эрүүгийн хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах

Нэгдүгээрт: Эрүүгийн хуультай эрүүгийн процессын хуулийг нийцүүлэх

“Хууль тогтоох байгууллагаас олон хууль батлан гаргаж байгаа нь эрх зүйн шинэтгэлд ахиц дэвшил гарч байгаа хэдий ч тэдгээр хуулиудад хэн ямар эрх үүрэгтэй

¹⁶ Тус судалгааны асуулгад Нийслэлийн цагдаагийн хэлтсүүдийн 513 алба хаагч хамрагдсан байна. Судалгааны төв.

талаарх нэгэн адил материаллаг хэм хэмжээнээс бүтсэн нэг хэвийн, амьдралын хөрсөнд буухгүй байгаа нь хууль хэрэгжихгүй байгаагийн тод илрэл юм.

Харин “Юуг хэзээ, хаана, хэрхэн, яаж хийх?” гэдэг эгэл боловч арга ажиллагааны амин чухал ач холбогдолтой асуудлыг дорвитой хөндөж материаллаг хуульд нийцсэн журмыг журамлан шинэтгэж чадахгүй байна.

Материаллаг хуулийн хэм хэмжээгээр тодорхойлогдсон агуулгыг хэзээ, хаана, яаж /ямар арга хэлбэрээр/ хийж гүйцэтгэхийг гагцхүү процессын хэм хэмжээгээр л журамлаж, тохируулах боломжтой.”¹⁷

Шударга ёс гагцхүү шударга процессоор тогтоогддог гэдэгтэй судлаачид санал нэгддэг. Тухайлбал, Бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ нь нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192.000 төгрөгнөөс бага бол эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан шийдвэрлэж түүнийг илрүүлэх, хариуцлага тооцох механизм үгүйлэгдэж хохирогчийн эрх ашиг зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.

ХБНГУ-ын шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор Бернд Шюнеманн “Хуулийн дагуу гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа-Эрүүгийн хуулийн суурь зарчим ба эрүүгийн процессын америк загвар” илтгэлдээ эрүүгийн материаллаг болон процессын хуулиудын уялдааг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Эрүүгийн хуулийн суурь зарчмууд болох

- хуульд тулгуурлах зарчим /principle of legality/ нь цаашаа хэд хэдэн дэд зарчимд хуваагдана.
- гэм бурууг тогтоох зарчим /principle of culpability/.
- ял гарцаагүй байх зарчим /seventy of punishment/.
- эцсийн аргын зарчим /principle of last resort/. Эрүүгийн эрх зүйн эдгээр үндсэн зарчмаас улбаалан эрүүгийн процессын үндсэн зарчмуудыг мөн гарган авч болох юм. Эрүүгийн процессын журмыг тогтоохдоо тэр нь бодит үнэн /material truth/ хэмээх зүйлд хүргэхээр байх ёстой. Өөрөөр хэлбэл тухайн этгээдийн гэм буруутай эсэхийг /beyond reasonable doubt/, мөн гэмт хэргийн нотолгоог хөдөлшгүй тогтоосон байх нь чухал.”

Хоёрдугаарт: Процессын хуулиудын уялдаа холбоог хангах

Манай Улсад хууль сахиулах ажиллагааны үндэслэл, журмыг ЭБШ шийтгэх, Гүйцэтгэх ажлын тухай, Шүүх шинжилгээний тухай, Захиргааны хариуцлагын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон Гаалийн тухай хууль, Татварын ерөнхий хууль зэрэг байгууллагын эрх хэмжээг тогтоосон салбарын 10 орчим хуулиар зохицуулж байгаа ч гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг шалгах хойшлуулшгүй ажиллагааны дийлэнх нь зохицуулалтгүй байсаар байна.

Ялангуяа зөрчлийн хэрэг бүртгэлтэд цагдаагийн байгууллага, гааль, татвараас гадна 40 орчим чиглэлд улсын байцаагчийн эрх бүхий субъект оролцож холбогдох журам хуульд хэт ерөнхий байдлаар зохицуулагдсан учраас УЕП-ын тушаалаар¹⁸ болон байгууллагын хэмжээнд батлагдсан журмаар¹⁹ нөхөх хэлбэрээр зохицуулахад хүрсэн билээ.

¹⁷ Ч.Чимэд “Үндсэн хуулийн үзэл баримтлал ба захиргааны процессын онол, практикийн асуудал” илтгэлээс

¹⁸ “Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хойшлуулшгүй ажиллагаа явуулах журам”-УЕП-ын 2008.05.28-ны өдрийн 123 дугаар тушаал.

¹⁹ “Мэргэжлийн хяналтын Улсын байцаагчаас захиргааны зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах, түүнд прокурор хяналт тавих журам” Улсын ерөнхий прокурор, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2012 оны А/34,303 дугаар хамтарсан тушаал.

Ийнхүү манай улсад гэмт хэрэг болон захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг тусгай хуулиар зааглан тодорхойлж, өөр өөрөөр тогтоосон нь хууль сахиулах үйл ажиллагаанд баримтлавал зохих олон улсын жишиг зарчмууд зөрчигдөх ялангуяа ялгаварлан гадуурхах, шүүхээс гадуур хэнийг ч гэм буруутайд үл тооцох зарчмын хэрэгжилт хангалтгүй түвшинд байгааг хүний эрхийн олон судалгаа илтгэн харуулж байна.

Энэ нь мөрдөн шалгах ажиллагааг ялгаатай байдлаар хэрэгжүүлэх, ялангуяа захиргааны зөрчлийг хянан шийдвэрлэх нэрийн дор хяналтгүйгээр хүний эрхийг хязгаарладаг, хүний эрхэд халддаг олон сөрөг үр дагаврыг авчирч байгаа тул хууль сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үндэслэл, журмыг нэгтгэн хуульчлах шаардлагатай байна.

Эрх зүйн хийдэл, алдаа, давхардлыг бий болгож, улмаар хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдахгүй байх Үндсэн хуулийн зохицуулалтыг гажуудуулах нөхцөл болж байгааг өөрчлөх шаардлага тулгарч байгаа нь цаашид зөрчил шалгах, гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг нэг стандартаар хэрэгжүүлэх шаардлагыг нөхцөлдүүлж байна.

Тухайлбал, Япон, Австрали, БНСУ, Англи зэрэг улсууд нь гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх, шалгах эрх бүхий цагдаа, мөрдөх болон хилийн алба, татвар, гааль зэрэг хууль сахиулах байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид нэгдсэн зарчим, журмаар хэрэгжих эрх зүйн баталгааг бүрдүүлж төрөлжсөн хуулиар зохицуулжээ.

4. Олон улсын хүний эрхийн стандарт болон Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн орчинг нийцүүлэх, шинэтгэх

Манай улс нь НҮБ-ын гишүүн улсын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хуульчлан тогтоохдоо Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт²⁰, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид²¹ заасан суурь зарчимд нийцүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13-т “... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...” гэж заасан.

Иймд мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дараах асуудлыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мөрдөн шалгах ажиллагааг хүний эрхийг хүндэтгэх зарчимд тулгуурлан шинэтгэж, гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч шалгахдаа хойшлуулшгүй гэх үндэслэлээр хүний эрх, эрх чөлөөг дур мэдэн хязгаарладаг байдлыг халж, гагцхүү шүүхийн зөвшөөрлөөр хуулийн дагуу явуулдаг зохицуулалт бий болгох шаардлагатай. Тухайлбал, нэгжлэг, хураан авах, хөрөнгө битүүмжлэх, сэтгэцийн дүгнэлт гаргуулахаар яллагдагчийг эмнэлэгт албадан эмчлэх гэх мэт.

2. 2002 оны ЭБШ хуульд гэмт хэргийн ангиллаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг тусгаарласныг халж гэмт хэрэг, түүнийг үйлдсэн хүнийг олж тогтоох ажиллагааг хэрэг

²⁰ 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдөр. Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200А (XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

²¹ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо баталж, 1987 оны оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

бүртгэх ажиллагаа харин гэмт хэрэгт сэрдэгдэн баривчлагдсан үеэс мөрдөн байцаах ажиллагаа явагдах эрх зүйн үндсийг сэргээх зүйтэй.²²

3. Монгол Улсын ЭБШ хууль тогтоомжид хохирогч, гэрчийн эрх зүйн байдал олон улсын стандартад зарим талаар ойртож нийцсэн боловч тэдгээрийн аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт, түүнчлэн тэдгээрт тусламж үйлчилгээ үзүүлэх механизм буюу нийгмийн сэтгэл зүй, халамж, хамгаалал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх цогц тогтолцоо үгүйлэгдсээр байна.

4. Дээр дурьдсанчилан хууль сахиулагч, мөрдөгчдөөс гэмт хэргийн тухай гомдол, мэдээллийг бүртгэх, хүлээн авах, шалгах хойшлуулшгүй ажиллагааны явцад цугларсан үр дүн нь нотлох баримтад тооцогдохгүй байгаа нь ЭБШ ажиллагааны зорилтод сөргөөр нөлөөлж байгаа учраас төрөлжсөн эсхүл нэгдсэн стандартад оруулж хүний эрхийг хамгаалах зүйтэй. Түүнчлэн захиргааны зөрчил шалгах эсхүл иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад цуглуулсан баримт мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэсэн нөхцөлд цуглуулах нь цаг хугацаа алдах, хууль сахиулах байгууллагын хүнд суртал гэсэн ойлголтыг иргэдэд төрүүлдэг.

5. Гэм буруу, ял оногдуулах шүүх хуралдаан явагдах үндэслэл нь мөрдөн шалгах ажиллагааны үр дүн учраас уг ажиллагааг олон үе шат, дамжлагагүй, ямарч нөхцөлд шуурхай явагдах эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал, гэмт хэргийг мөрдөн шалгах явцад цуглуулсан баримт, мэдээлэл нь тухайн хүнийг гэмт хэрэг үйлдсэнд холбогдуулан баривчлах факт болох төдийгүй тухайн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тохиолдолд түүнд гэм бурууг тогтоох шүүх хуралдааныг алгасан шүүхээс хуульд заасан хөнгөн ял оногдуулах шүүхийн механизмыг бүрдүүлэх нь чухал.

Харин ЭБШ хуульд тодорхой зарим төрлийн хөнгөн гэмт хэргийг хялбаршуулсан журмаар хэрэг бүртгэлт явуулах, түүнд тавих прокурорын хяналт улмаар тухайн хуулиар харъяаллуулсан хөнгөн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэх процедурыг анх удаа нэмэлтээр хуульчлан баталгаажуулсан нь дээрхи хялбаршуулсан онцгой журам гэж дүгнэгдэхгүй байна.

6. Гүйцэтгэх ажил явуулах төрийн байгууллага, эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны эрх зүйн үндэс болсон Монгол Улсын хуулиудад материаллаг хэм хэмжээг агуулсан байгаагаас зарим тодорхой төрлийн үйл ажиллагааг явуулах процедур өнөөг болтол үгүйлэгдэж байгаа тухай судлаачид тэмдэглэсэн байдаг.²³

Монгол Улсын ЭБШ хуульд гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан баримт сэлт, мэдээллийг нотлох баримт болгох эрх зүйн зохицуулалтыг судалваас гүйцэтгэх ажлын хүч техник хэрэгсэл хэрэглэх хуульд заасан үндэслэл нь байгаа гэж үзсэн ч гүйцэтгэх ажлын тодорхой арга, хэрэгсэл ашиглаж баримт, сэлт, мэдээлэл цуглуулах, илрүүлэх, бэхжүүлэх, шалгах нарийвчилсан журам, нөхцөл²⁴ нь өнөөг болтол Гүйцэтгэх ажлын тухай болон ЭБШ хуульд баталгаажуулагдаагүй байна.

7. Мөрдөн шалгах ажиллагаанд шинжлэх ухаан техникийн ололт амжилтийг ашиглах нөхцлийг бүрдүүлж хуульчлан баталгаажуулах шаардлагатай. Энэ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарт нийтлэг анзаарагддаг дутагдал нь нотлох баримт цуглуулахдаа байцаалтыг хэт шүтэх хэвшмэл сэтгэлгээ хэдийнээ төлөвшиж ялангуяа *”тодорхойлолт авах”* *”тайлбар авах, гаргуулах”* *“байцаалт”*-аар иргэдийг чирэгдүүлэх, бусад байцаан шийтгэх тодорхой ажиллагаа явуулахгүйгээр сэжигтэн, яллагдагчийг хэргээ хүлээх

²² 1963 оны ЭБШ хуульд дээрх агуулгаар хэрэгжиж байсан.

²³ 3. Төрмандх. “Хүнийг санаатай алах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх асуудал” диссертаци.

²⁴ “Гүйцэтгэх ажлын заавар”-аар зохицуулж буй зарим харилцаа.

шаардлага тавих зэргээр эрүүдэн шүүж өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг зөрчих явдал нь хэргийг шүүхээр шийдвэрлэх үед мэдүүлгээс буцаж байнга хүндрэлийг бий болгодог билээ.

21-р зуунд төрийн тогтолцоо, иргэний харъяаллыг үл харгалзан иргэншил, соёл, мэдээлэл, эдийн засаг, санхүү, хуулийн бодлого, иргэний нийгмийн зарчим ялангуяа эрх зүй нийтлэгших үзэгдэл зэрэг нь дэлхий нийтийн шинжтэй болж тэр ч утгаар Монгол Улс олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж²⁵ үндэсний хууль тогтоомж ялангуяа мөрдөн шалгахад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, хангах ажиллагааг олон улсын жишиг стандартад нийцүүлэх шаардлагатай билээ.

5. Хууль сахиулах байгууллагын оновчтой тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлэх

Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хөгжил, зүй тогтолын сөрөг үр дагаврын илэрхийлэл болох гэмт хэрэг, зөрчлийн хандлагыг цаг хугацааны хувьд хожуу танин мэдсэнээс практик амьдрал нь түүнтэй тэмцэх онол, хууль сахиулах эрх зүйн зохицуулалт, бодлого, стратеги, тактикийг боловсронгуй болгохыг шаардаж байдаг.

Гэмт хэрэг, зөрчлийн арга, хэлбэр, орчин үеийн техник хэрэгсэл, мэдээллийн солилцооноос мөрдөгчийн мэдлэг, бие дааж ажиллах болон багаар ажил гүйцэтгэх чадвар түрүүлж хөгжсөн байх ёстой.

Олон улсын жишиг дагуу хууль сахиулах байгууллагын чиг үүргийг оновчтой болгох, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож мөрдөн шалгах байгууллага, мөрдөгчийн мэргэшсэн үйл ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах баталгаа болно.

Энэ нь нийгмийн хөгжлийн шаардлагаар мөрдөн шалгах ажиллагааг мэргэшсэн алба байх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна.

Францын их сэтгэгч Фрэнсис “Өөрчлөлт, өөрчлөлтийн дотроос хүний оюун ухаанд хийх өөрчлөлт нь хамгийн их хөдөлмөр, цаг хугацаа, доромжлол шаарддаг” хэмээсэн бөгөөд ихэнх нөхцөлд удирдах хүмүүс, хуучинсаг судлаач, бүр эрдэмтэд хүртэл шинэ зүйлд “сэжигтэйгээр” ханддаг бөгөөд зөвхөн өөрийнхөө мэдлэг, чадвар, эзэмшсэн мэргэжил, итгэл үнэмшил, уламжлал, эдийн засгийн сонирхолдоо нийцсэн зүйлийг л илүүтэй дэмжиж, эвлэрч байдаг. Иймд шинэчлэлийг хэлбэрдэх, хагас дутуу хэрэгжүүлэх нь төөрөгдөлд оруулдаг учраас огт хийгээгүйгээсээ ч илүү хортой талаар профессор Т.Ёндон “Хуулийн математик” илтгэлдээ дурьджээ.

Эрүүгийн процессын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд инноваци нэвтрүүлэхээс гадна хууль сахиулагчийн эрх зүйн соёл, ухамсрыг төлөвшүүлэх, тэдгээрийн мэдлэг, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор эрх зүйн сургалтыг зохион байгуулах нь уг хуулийн үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх, үр нөлөөг дээшлүүлэн хүний эрх эрх чөлөөг хангах, хамгаалах нэг чухал нөхцөл мөн.

²⁵ Үндсэн хууль 10 дугаар зүйл 3 дахь хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХҮЙН СЭТГЭЛГЭЭНИЙ ХӨГЖИЛ

Товч агуулга:

Гэмт хэрэг мөрдөхүй нь эрүүгийн процессын эрх зүйн сэтгэлгээ, түүний хөгжил, криминалистикийн шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагаас шууд хамаарах бөгөөд уг сэдвээр дээрх асуудлыг хөндөх төдий авч үзлээ.

Түлхүүр үг:

- *Гэмт хэрэг мөрдөхүй – CRIME INVESTIGATION*
- *Уламжлалт хандлага – TRADITIONAL THOUGHTS*

Гэмт хэрэг нийгмийн үзэгдлийнхээ хувьд түүний хөгжлийн хүрсэн түвшин хийгээд өөрийн гарал үүслээрээ үүсэн бий болох, өөрчлөгдөх /үгүй болох эсхүл үгүйсгэгддэг/ зүй тогтолтой байдаг гэж үзвэл гэмт хэргийг мөрдөх нь мөн л тэрхүү зүй тогтолтой харилцан хамааралтай байна. Энэхүү хамаарлыг социодинамикийн үүднээс авч үзвэл хөгжлийнхөө дээд эрэмбэ рүү өөрөөр хэлбэл энгийнээс илүү нарийн руу чиглэсэн тасралтгүй хөгжих үйл явц гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр боловсронгуй гэж үзэж байгаа үйл явц аажмаар өөрчлөгдөн хувьсаж байдаг зүй тогтол байдаг.

Нийгмийн хөгжил хөдөлгөөний үйл явцад тасралтгүй хөгжиж ирсэн бүхий л үздэгдэл юмсыг дагалдаж ямагт түүний сүүдэр болох гэмт хэрэг, гэмт зан үйл энэхүү цаг үеийг хүртэл тасралтгүй орон зайгаа үлдээсээр ирлээ.

Хэдийгээр хүн төрөлхтний түүхийн үйл явцад сайн, муу хоёр үйл зэрэгцсээр ирсэн хэдий ч түүний аль аль нь өөрийн өөрийн гэсэн өрсөлдөөнийг үүсгэн бий болгож хөгжлийн төлөөх сэтгэлгээний хязгааргүй тэмүүллийг бий болгожээ. Үүнийг диалектикт эсрэг тэсрэг нэгдэл тэмцлийн категороор тайлбарлаж түүний гүнд нэвтрэх учиртай. Нийгмийн амьдралд үл тэвчих гэмт хэрэг хэмээх ойлголт байдаг бол түүнийг үйлдэн амьдралынхаа салшгүй хэсэг болгож орших мөн нэг хэсэг байдаг нь тэдгээрийг салшгүй эсрэг тэсрэг болохыг илэрхийлэх боловч харилцан нэгдэлтэй ухагдахуун болох нь эндээс илэрнэ.

Тийм ч учраас сэтгэлгээний хувьд бие биеэ үгүйсгэх атлаа түүхийн бүхий л цаг үед оршин байсаар байгаа нь гарцаагүй түүнийг сэтгэлгээний хөгжлийнх нь хувьсал, хөгжилт, хөдөлгөөнд нь авч үзэх шаардлага байгаа нь ажиглагдаж байна.

Монголчуудын эрх зүйн сэтгэлгээний хөгжлийг шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж хууль цаазын сэтгэлгээний түвшинд гарсан хувьсал, өөрчлөлт, эрхийг ойлгох үзэл, сэтгэлгээний шинж чанарыг шалгуур болгон дараах байдлаар ангилан авч үзсэн нь бидний хувьд анхааран авч үзэж дүгнэлт хийх ангилал мөн. Үүнд:

1. Заншлын эрх зүйн үзэл, сэтгэлгээний үе,
2. Зүй ёсны эрх зүйн үзэл, сэтгэлгээнд шилжсэн үе,
3. Манж-Чин улсын эрх зүйн нөлөөнд байсан үе,
4. Өрнийн эрх зүйн соёл сэтгэлгээ нэвтэрсэн үе,
5. Социалист эрх зүйн сэтгэлгээний үе,

6. Орчин үеийн эрх зүй сэтгэлгээний төлөвшил²⁶ гэж авч үзсэнийг тэмдэглүүштэй. Энэхүү ангилалыг иш үндэс болговол гэмт үйлдлийг хэрхэн мөрдөн мөшгиж байсан талаарх зарим таамаглалыг дэвшүүлж болох юм.

Түүхийн хөгжлийг бид формацийн болон соёл иргэншлийн онолоор үечлэн хувааж авч үзэж ирсэн хэдий ч орчин цагт дээрх онолд тулгуурлан эрдэмтэн судлаачид илүү хялбар эсхүл нэлээд нарийн хэсгүүдэд хуваан авч үзэж харилцан адилгүй судлах боллоо. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны хөгжил гүнзгийрэх тутам түүнд асар олон судлах зүйл, судалгааны арга зүй бүхий салбарууд бие даан хөгжиж аажмаар тэдгээр шинжлэх ухааны хувийн онцлог, мөн чанар, зорилтоос нь шалтгаалж ямар ч байдлаар ангилж авч үзэх болов.

Гэмт хэрэг мөрдөх гэдэг ойлголт нь харьцангуй урт хугацааг туулж ирсэн хэдий ч хүн төрөлхтний түүхийн цаг үетэй харьцуулбал харьцангуй залуу ойлголт болно. Учир нь гэмт хэрэг гэж хэзээ анх хуульчилсан болохыг бид одоо ч нарийн тогтоогоогүй байгаа учраас гэмт хэрэг мөрдөхүйн тухай хэлэлцэх нь мөн л тодорхойгүй ойлголт болох нь эндээс урган гарах учиртай.

Дурьдан байгаа сэдвийн хүрээнд аливаа гэмт хэргийн шинжтэй үйлдлийг тогтооход уламжилж ирсэн хандлага нь дорнын уламжталт арга, технологид суурилсан мөн нүүдэлчдийн ахуйн өвөрмөц онцлогийг агуулсан хоёрдмол шинж илэрнэ.

Эрх зүйн сэтгэлгээний уг сурвалж үеийг бид Хүннүгийн төрийн байгуулалт хийгээд түүнээс хойш XIII зууныг хамруулан авч үзвэл энэ үед хамаарах мөрдөхүйн баримт сэлт хомс болох нь тодорхой. Гэвч бидний таамаглаж байгаагаар нүүдэлчдийн аж төрөх өвөрмөц онцлогт тулгуурласан онцлог бүхий мөрдөхүйн арга барил байсан нь тодорхой.

Энэ үеийн мөрдөхүйд зан заншил, бөө мөргөл, хаан эзний хүсэл хийгээд түүний үзэл санаа, шийдвэр хүчтэй нөлөөлж байсан нь болов уу. Өөрөөр хэлбэл, гэмтнийг мөшгөх, эрэх хайх нь хаанаас шадарлан байгаа итгэл хүлээсэн хүмүүс гүйцэлдүүлэх явдал түгээмэл байсан гэх үндэслэл байна.

Энэ үеийн мөрдөхүйг бидний таамаглаж байгаагаар зөн билэг, итгэл бишрэл давамгайлсан тэнгэрийн хүүгийн үзэл хандлага давамгайлж байсан үе гэж үзэж болох талтай байна. Үүний талаар шинжлэх ухааны доктор Н.Лүндэндорж “Тэнгэрийн үзэл бол хүннүгээс эхлэн Монголчуудын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний тулгуур зарчим, эх сурвалж, төр шүтэх үзлийн оюун санааны үндэс болж ирсэн байна²⁷” гэж ерөнхий байдлаар дүгнэсэн байна.

Нүүдэллэн амьдрах хэв маяг нь суурин иргэншлээс өвөрмөц онцлогтойн дээр өөр хоорондоо диалектик зөрчилтэй учир арга билгийн хийгээд үнэт зүйлс, төр ёс, ахуй уламжлал, зан заншлийн өөр баримжаатайгаар зэрэгцэн хөгжиж ирсэн билээ.

Тийм ч учраас аливаа хэрэг заргыг мөрдөн мөшгөх нь сэтгэлгээний хувьд тэрхүү диалектик зөрчлийг илтгэхийн сацуу оюун санааны үндэс болсон тэнгэризмд тулгуурласан байхыг үгүйсгэх аргагүй билээ.

Хүннүгийн дараа оршин байсан төр улсуудын хувьд ч мөн дээрхээс өөр өвөрмөц онцлогтой сэтгэлгээний хэв шинж байсан байх магадлалтай хэдий ч энэ тухайд нийтлэг тал байсан болохыг эрдэмтэн судлаачид хүлээн зөвшөөрч байгаа тул ерөнхийлөн хамааруулж болох юм.

Үүнээс хойш түүхэн хугацааг бид “Заншлын эрх зүйн үзэл, сэтгэлгээний үе” гэж хамааруулан авч үзэж байна. Энэ хугацааг XII-XV зууны сүүл, XVI зууны эхэн үеийг хамаарах бөгөөд үзэл санааны түүхэн сурвалж нь эртний Монголчуудын өвөг улсуудын

²⁶ Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ., 2002 он. 182-243 дах талд үзнэ үү.

²⁷ Н.Лүндэндорж. Дурьдсан бүтээл. 185 дах тал.

эрх зүйн үзэл, сэтгэлгээний соёл, уламжлал юм²⁸ гэж үзсэн байна. Энэ утгаараа Монголчуудын сэтгэлгээний гол чиглэл болсон зан заншил нь гэмт хэрэг мөрдөхүйн үзэл сэтгэлгээнд нөлөөлж байсан болохыг дүгнэж болох юм.

Эрх зүйн сэтгэлгээний өвөрмөц байдлаараа энэ үеийн гол эх сурвалж болгодог “Их засаг” хуулийг судлаачид зарим талаар уг хуулийн үндсэн эх сурвалж нь тогтсон ёс, заншил байсан²⁹ гэж дүгнэдэг. Сэтгэлгээний хувьд хүлээн зөвшөөрч харин тухайн заншлын хувьд хэлбэршин тогтсон хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг хэрхэн мөрдөн мөшгөх тухай асуудал бидэнд ховор байна.

Гэвч Чингис хаан найман шарга агтаа дээрэмдүүлээд араас нь хөөж олох хүртлээ өвсний налархайгаар мөшгөн³⁰ буцаан авсан байдаг. Мөн нэгжлэг хийсэн асуудал Монголын нууц товчоонд бий. Тэмүүжин тайчуудад баригдаж оргоод нуугдсан, улмаар тайчууд Тэмүүжинг олохын тулд айлуудаар нэгжлэг хийсэн Сорхон-шар Тэмүүжинг хэлэлгүй нуусан тухай тэмдэглэсэн байна. Энэ нь Монголчууд мөр илрүүлэх хийгээд мөрдөхүйн арвин туршлагатай байсныг илтгэнэ. Үүнийг хэрэг явдал мөрдөхүйн сэтгэлгээний хувьд байгалийн хууль, зүй тогтол, түүнд гарсан өөрчлөлтийг уламжлалт арга, туршлагаараа мэдэж гүйцэтгэж байсан оюун санаа, зан суртахуун, дадал, уламжлалт арга барилын илрэл гэж үзэж болно.

Харин энэ цаг үеэс хойш “Зүй ёсны эрх зүйн үзэл, сэтгэлгээнд шилжсэн үе”-ийг XVI зууны эхэн үеэс авч үзсэн нь тухайн үед “Алтан хааны цааз” гарсантай холбоотой хэмээн үзсэн байна. Энэ үед Монголд улс төрийн хямрал, бутрал гарч улмаар түүнийг намжаан нэгдмэл хүчирхэг байдлыг бий болгохын төлөө Түмэдийн алтан хаан /1507-1582/ тэмцэж³¹ энэхүү зорилгоор хууль цааз бататган гаргахыг эрмэлзэж байсны илрэл нь энэхүү “Алтан хааны цааз” бичиг юм.

Зүй ёсны эрх зүйн үзэл сэтгэлгээний үед түгээмэл ач холбогдол бүхий харилцааг зүй ёс, шударга чанарын үүднээс үнэлж, хууль зүйгээр нарийвчлан зохицуулах болсноор эрх зүйн үзэл сэтгэлгээ реалист чиг хандлагатай болох нөхцөл бүрэлдэж эхэлсэн³² бөгөөд гэмт хэргийн бүрэлдэхүүн ямар нэг хэмжээгээр уг хуулинд тусгалаа олсон³³ гэж үзсэн байна. Тухайлбал, энэ хууль ихэс дээдэс, ядуу дорд хүмүүс бүгдэд хамааралтай гэж субъектийг “Арван наснаас доош бол хулгайчид үл тооц, дээш бол тооц” гэж субъектийн насыг, гэмт халдлагад өртөгдөж болох объект /ашиг, сонирхол/, халдлагын зүйлүүдийг нэг бүрчлэн тооцон заасан байна. Үүнд: “Жанчин нүд тэсэлбэл, шүд хугалбаас, үс сахал тасалбаас, гар хөл хугалж тахир дутуу болговоос” гэж зааснаас тодорхой харагдана³⁴ гэж тэмдэглэсэн байна. Түүнчлэн “Муу уршгаар буюу муу санаагаар түймэр тавих”, “Эцэг эх нь охиноо элдэв аргаар /зорилгоор гэж шинжлэх ухааны доктор С.Жанцан үзсэн/ хүнд өгөх”, “Эндүүрээд хүн үхүүлэх” гэж гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг, онцолбол, гэм буруугийн хэлбэрийг хуульчилж байсан нь дэвшилттэй юм³⁵ хэмээн тусгайлан тэмдэглэсэн байна.

²⁸ Н.Лүндэндорж. Дурьдсан бүтээл. 193 дах тал.

²⁹ Энэ тухай академич С.Нарангэрэл, шинжлэх ухааны доктор С.Жанцан, Н.Лүндэндорж, Д.Лүндээжанцан нар өөр өөрсдийн бүтээлдээ санал нэгтэй тэмдэглэсэн байдаг.

³⁰ Монголын нууц товчоо. 2-р бүлэг. 90 дэх хэсэг. /Монголын нууц товчоонд нэвтрэхүй тусгай хэвлэл/ УБ., 60-61 дэх тал.

³¹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009 он. 53 дах тал.

³² Н.Лүндэндорж. Дурьдсан бүтээл. 214 дэх тал.

³³ С.Жанцан. Дурьдсан бүтээл. 53 дах тал.

³⁴ С.Жанцан. Дурьдсан бүтээл. 53 дах тал.

³⁵ С.Жанцан. Дурьдсан бүтээл. 53 дах тал.

Энэ үед “Алтан хааны цааз”, “Арван буянт номын цааз”, “Хутугтай сэцэн хун тайжийн шашны бичиг”, “Халхын цааз эрхэмж бичиг”, “Монгол – Ойрадын цааз” гэх зэргээр нэлээд олон хууль тогтоомж үйлчилж байлаа.

Дээрхээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Өөрөөр хэлбэл, нэгэнт хуульчлан тогтоосон хэм хэмжээг эрх бүхий албан тушаалтан сахиулах ёстой бөгөөд гэмт хэргийн дээр дурьдсан бүрэлдэхүүнийг тогтооход тэднээс мөрдөхүйн сэтгэлгээний нэлээд ахисан түвшний мэдлэг, ур чадвар шаардаж байсан нь хэн бүхэнд ойлгомжтой болов уу гэж үзэж байна. Энэхүү цаг үеийг гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний шинэ хандлага бүрэлдэж эхэлсэн үе гэж бид үзэж байна.

Манж Чин улсын эрх зүйн нөлөөнд байсан эрх зүйн сэтгэлгээний хувьд нэлээд өвөрмөц шинж давамгайлна. Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний түүхээс үзэхэд колони орны зовлон бэрхшээл хэдийгээр хүнд бэрх боловч колонийн эзэн орон нь тухайн колончлогдож буй орноос иргэншил, соёл, хүч чадлаар ямагт давуу байдаг учир түүний нөлөөгөөр дэвшил, өөрчлөлт ч мөн дагалдаж байдаг нь түүхийн үнэн³⁶ гэж үзсэн нь бидний хувьд анхаарууштай асуудал мөн.

Өөрөөр хэлбэл, Монгол улс тухайн цаг үедээ гарч ирсэн хүчирхэг иргэншлийг хүлээн зөвшөөрч тэдний колонид байсан хэдий ч эрх зүйн сэтгэлгээний хийгээд гэмт үйлдлийг хэрхэн мөшгөх тухайд хуучин уламжлалт арга барил дээр нэмэгдэж ахиц гарсан гэж үзэж болох талтай билээ. Хэм хэмжээ тогтоох нь илүү нарийвчилсан хэв маягтай болж Халх журам хэмээх хууль гарсан нь Монголын хууль цаазын чухал түүхэн баримт бичиг болж үлдсэн нь онцгой чухал үйл хэрэг билээ. Энхүү хуулиар дараах ялын төрөл хэлбэрийг тогтоосон нь эрх зүйн үзэл сэтгэлгээнд нэлээд ахиц гарсан явдал байлаа. Үүнд:

Цаазаар авах, Ташуурдах, Цөлөх, Хорих, Хэргэм зэрэг эвдэх, Торгох, Хөрөнгө хураах³⁷ гэх зэргээр ял ногдуулахаар тогтоосон нь энэхүү ял шийтгэлтэй гэмт хэргүүдийг мөрдөх сэтгэлгээнд ихээхэн өөрчлөлт /реформ/ орж эхэлсний илэрхийлэл мөн гэж үзэж болно.

Тухайлбал, судлаач Б.Жаргалсайхан “Монголын криминалистикийн түүхийн хуудаснаа нэмэрлэхүй” судалгааны ажилдаа Төр гэрэлтийн 30-р оны /1850/ зуны сүүл сарын шинийн долооноо үйлдэгдсэн хүн нас барсан хэрэгт хэмжилт хийж, боож нас барсан тухай тэмдэглэсэн байна³⁸. Түүнчлэн энэхүү хэргийг шалгахдаа шархач мэргэжилтнийг оролцуулан тэмдэглэл үйлдсэн нь гэмт хэрэг мөрдөхүйд хамтын ажиллагааны тактикийн шинжтэй үйл ажиллагааг зохион байгуулж явуулсан тухай баримтыг нухацтай судалсан байна.

Энэ нь Монголчуудын түүхийн хуудаснаа үлдсэн нэлээд анхааран судлууштай баримтын нэг нь болов уу хэмээн үзэж байна. Гэмт хэрэг мөрдөхүйд сэтгэлгээний хувьд нэлээд шинэлэг хэлбэрээр буюу баримт нотолгоонд тулгуурлаж гэм бурууг хэлэлцэх түүхэн хуудас ийнхүү үлдсэн нь оюун санаа, танин мэдэхүйн хувьд нэгэн шинэ үзэгдэл байсан байна. Манж-Чин улсаас улбаатай байж болох сэтгэлгээ, соёлын интеграц солилцооны түүхэн баримт ийнхүү үлдсэн байж болохоор байна.

Энэ үеийг бид гэмт хэрэг мөрдөхүйд тактикийн шинжтэй эргэлт орж эхэлсэн үе гэж үзэхэд ташаарч байгаа мэт санагдахгүй байна. Өөрөөр хэлбэл, урьд гэмт хэрэг мөрдөхүй нь энэ үед байсан шиг баримтжуулж, нотлох баримт бүрдүүлэх, түүндээ тулгуурлаж шийдвэр гаргаж байсан баримт үндсэндээ үгүй байна.

Өрнийн эрх зүйн соёл сэтгэлгээ нэвтэрсэн үеийг бид Манж-Чин улс хийгээд Хятадын соёлын хар, өмхөрч байгаатай холбогдуулан эрх биш Монголчуудын оюун

³⁶ Н.Лүндэндорж. Дурдсан бүтээл. 220 дах тал.

³⁷ С.Жанцан. Дурдсан бүтээл. 63 дах тал.

³⁸ <http://www.criminology.mn/index.php?option=newsm&id=35&lang=1>

санааны хийгээд ахуй, уламжлал, тусгаар тогтнолоо дахин сэргээх гэсэн их эрмэлзлийн үр дүнд харилцах улс орнуудын тоо олширч капиталист эсхүл түүнийг алгасан социализмыг байгуулах гэсэн хоёрдмол түүхэн сонголтоос сүүлчийнхийг сонгон авч улмаар Орос улсын хүчирхэгжин буй дор интеграцлагдсан билээ. Бид үүнийг оюун санаа, ахуй, соёлын хувьд өрнөдөөс судлан, суралцаж эхэлсэн сэтгэлгээний түүхэн цаг үе байсныг тэмдэглэж байна.

Энэхүү түүхэн үе нь шинжлэх ухааны доктор Н.Лүндэндоржийн дүгнэснээр “1911 оны Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд тогтсон Богд хаант Монгол улсад монголчуудын аливаа зүйлийг хүлээн авах чадвар, хандлага нь өрнийн эрх зүйн үзэл сэтгэлгээ, соёл нэвтрэх, хүлээж авах бололцоо бүрдсэн³⁹” хэмээн үзсэнийг дэмжиж байна. Энэ нь тухайн цаг үедээ байгалийн болон бусад шинжлэх ухаан, технологийн гайхалтай нээлтүүдийг үзэж, судлах, танин мэдэх, үр дүнг нь хүртэх нэн таатай бололцоог бүрдүүлсэн сэргэн мандалтын он жилүүд байлаа.

Марксист философи, онол, сэтгэлгээ нь ертөнцийн хамгийн үнэн философи, онол болж хэт туйлсрах явдал Монгол оронд дүр төрхөө олж идеалист философийг шүүмжлэх болов. Үүний баримт болж “ертөнцийг үзэх шинжлэх ухааны материалист үзэл бий болох замаар нийгмийн сэтгэлгээний зүй тогтолт хөгжил явагдсаныг философийн бүх түүх харуулж байна⁴⁰” хэмээн тэмдэглэсэн нь үзэл сэтгэлгээний уламжлалт хэв маягаас татгалзах үндэс болж эхэлжээ.

Ингээд монголчууд өрнийн соёл сэтгэлгээний үр дүнд анхны үндсэн хуулиа батлан түүнд нийцүүлэн бусад хууль тогтоомж мөн боловсруулж эхэлсэн байна. Гэвч гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний хувьд Оросын эрдэмтдийн онол хүчтэй нөлөөлж “Гэмт хэрэг үйлдсэнээ хүлээн мэдүүлэх нь нотлох баримтын хамгийн гол эх сурвалж мөн⁴¹” гэсэн үзэл баримтлалыг хэт дөвийлгөн, уламжлалт арга барилууд өөрчлөгдөж эхэлсэн нь өнгөрсөн зууны талыг нь нөмрөх харанхуй үе байсан гэж бид үзэж байна.

Үүний дараа социалист эрх зүйн сэтгэлгээний үеийг туулсан бөгөөд энэ үеийг хэд хэд ангилан авч үзэж болохоор байгаа бөгөөд өгүүлэл бичигчийн хувьд энэ талаар онцгойлон авч үзэх, ул суурьтай шинжлэн судлах шаардлагатай хэмээн үзэж орхилоо.

Орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний төлөвшилт нь 80-аад оны сүүл 90-ээд оны эхэнд тохиосон юм. Энэ үеийн эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн гол хандлага – эрх зүйн үзэгдэл, харилцаа, хэм хэмжээ, үзэл бодлыг хүн төрөлхтний түгээмэл үнэт зүйлийг суурь баримтлал, тулгуур зарчим, шалгуур болгож, эрх зүйн плюрализмын үүднээс эрэгцүүлж, үнэлж, дүгнэж, судалж, шинжилж, бодож боловсруулж байгаад оршино⁴² хэмээн үзсэн нь дэмжүүштэй дүгнэлт билээ. Тийм ч учраас гэмт хэрэг мөрдөхүйн консерватив хандлага, хэв шинжтэй нэг талыг барьсан гэмт хэрэг мөрдөхүйгээс ангижрах түүхэн шилжилт энэ цаг үед хийгдэж байна. Гэмт хэрэг мөрдөхүйн сэтгэлгээний хөгжилд сүүлийн 80 гаруй жилийн улбаа байсаар байгаа нь одоогийг практикт байгаа үнэн дүр төрх билээ.

Дүгнэлт, санал:

1. Эрхийн сэтгэлгээ төлөвшин хөгжих явцад соёл иргэншлийн түүхэн шилжилтүүдийн үед харилцан адилгүй соёлын солилцоо, интеграци явагдаж хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт амжилтаас Монголчууд ихээхэн зүйлсийг нэвтрүүлж

³⁹ Н.Лүндэндорж. Дурдсан бүтээл. 224 дэх тал.

⁴⁰ П.Н.Федосеев. Коммунизм ба философи. /2 дах хэвлэл/ УБ., 1977 он. 7 дах тал.

⁴¹ Оросын эрдэмтэн Ушинский энэ үзэл сэтгэлгээ, онолын үндэслэгч бөгөөд энэ нь өнгөрсөн зууны гэмт хэрэг мөрдөхүйн онол, сэтгэлгээний үндэс болж байсныг энд тэмдэглэж байна.

⁴² Н.Лүндэндорж. Дурдсан бүтээл. 243 дах тал.

гэмт хэргийг мөрдөн мөшгөх туйлын өндөр соёлтой байсан нь ажиглагдаж байна. Гэвч нийгмийн хөгжлийн явцад бид харгис хэрцгий, мунхаг үеийг даван туулж өдгөө ирсэн болой.

2. Монголчууд XX зууны босгон дээр түүхэн сонголт хийсэн нь өрнийн сэтгэлгээ, соёл нэвтрэх түүхэн үйл явц болж гэмт хэрэг мөрдөхүйд өрнийн онол, сэтгэлгээ хүчтэй нөлөөлж байсан түүхэн баримтууд нэлээд байгаа нь бидний соёлыг хүлээн авч нутагшуулах чадвартайг илтгэж байна. Сэтгэлгээний гайхалтай соргог мэдрэмжтэй ард түмний хувьд XXI зууны хөгжлийн дэлхий нийтийн баримжааг алдахгүй байх нь биднээс эрдэм мэдлэг, технологийн өндөр ур чадвар шаардаж байгаа тул өдөр бүр бид мэдлэг боловсролоо дээшлүүлэх шаардлагатай болжээ.

3. Гэмт хэрэг мөрдөхүйд аль нэг онол, сэтгэлгээ хүчтэй нөлөөлөх түүхэн үйл явцын дунд бид алдаж онож байсан нь цаашид бид тэдгээр алдааг гаргахгүй байх түүхэн сургамж болжээ хэмээн үзэж байна. Энэ нь гэмт хэрэг мөрдөх явцад эрх зүйн сэтгэлгээ, төлөвшилт, шилжилтүүд ямар чухал болохыг илтгэж байгаа дүгнэлт билээ. Ийм ч учраас аливаа өөрчлөлт, шинэчлэлт нь цаг хугацаа хийгээд нийгмийн гишүүдийн эрхийн талаарх сэтгэлгээнээс ихээхэн хамааралтай. Энэ цаг үе нь хүний эрхийг дээдлэх, либерал ардчилсан сэтгэлгээ давамгайлсан цаг үе учраас хууль сахиулагчдаас энэ талаарх онолын мэдлэгийн өндөр түвшинд шаардаж байгааг анзаарахгүй байж боломгүй байна.

4. Өнөөгийн соёл иргэншил, сэтгэлгээний хөгжил нь хууль сахиулагчдаас иргэний эрхийг хүндэтгэн, хамгаалах түгээмэл шаардлагыг нөхцөлдүүлж байгаа нь туйлын тодорхой боллоо. Энэ ч утгаараа өрнийн хийгээд дорнын аль ч үнэт зүйлийн баримжааг алдахгүй гэмт хэрэг мөрдөхгүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлагаа тодорхойлж явахгүй бол хэт өрнөжсөн мөн чанар, агуулгыг нь ойлгохгүй маш бэрхшээлтэй зүйлс тулгарах магадлал байсаар байна.

5. Гэмт хэрэг мөрдөхүй нь эрүүгийн процессын өөрчлөлт, шинэчлэлтэй хамааралтай бөгөөд сэтгэлгээний хувьд сүүлийн 80 орчим жилийн хугацаанд өөрчлөлт огцом гараагүй гэж үзэж болох юм. Энэ нь гэмт хэрэг мөрдөхөд тулгамдсан асуудлын нэг байсаар байна.

Ц.Очгэрэл

*ЦЕГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх албаны Хэрэг
бүртгэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа*

ХЭРЭГ БҮРТГЭХ, МӨРДӨН БАЙЦААХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

1.Хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагааны нөхцөл байдлын талаар

2015 оны 9 сарын байдлаар улсын хэмжээнд 20976 гэмт хэрэг бүртгэгдсэн, үүнээс 5587 буюу 23.7 хувийг эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 4972 хэрэг буюу 21.0 хувийг түдгэлзүүлж, 1620 хэрэг буюу 6.9 хувийг нэгтгэж 9356 буюу 39.7 хувийг хэрэгсэхгүй болгох саналтай, 372 буюу 1.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж, 1679 хэрэг буюу 7.1 хувь ажиллагаанд байна гэсэн тоон мэдээ гарсан байна.⁴³

⁴³ МТТ-ын Гэмт хэрэг, захиргааны зөрчлийн статистик мэдээ 2015,09 сар


Гэмт хэргийн илрүүлэлт урьд оны мөн үеэс 6296 буюу 20,7 хувиар өссөн эерэг үзүүлэлт байгаа ч бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг 10428 буюу 14.6 хувиар нэмэгдсэн сөрөг үзүүлэлт гарсан байна.⁴⁴

Гэмт хэргийн гаралт 2013-2014 онд 7.7 %-14.8 % иар өссөн, 2015 оны 09 сарын байдлаар 6.1 хувиар өсөлттэй гэсэн дүн мэдээ гарсан байна.

Гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж буй эдийн засгийн болон нийгмийн олон шалтгааныг хөндөлгүй, тодорхой төрлийн зарим гэмт хэргүүд гэмт хэргийн өсөлтөд хэрхэн нөлөөлж байгаа, эдгээр гэмт хэргүүдийг мөрдөн шалгах явцад гарч байгаа байцаан шийтгэх ажиллагааны хүндрэл бэрхшээлийг бүрэн шийдэж, засаж арилгаж чадахгүй байгаагаас гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн хангалтгүй байна гэсэн хандлагаас асуудлыг харж, судалгаа хийх, даван туулах арга замыг тодорхойлох явдал шаардлагатай гэж үзэж байна.

Гэмт хэрэгтэй тэмцэх албанд ажиллаж байгаа судлаачийн хувьд гэмт хэргийн гаралт, түүнтэй тэмцэж байгаа цагдаагийн байгууллагын гол үйл ажиллагаа болох хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явц дахь тулгамдсан асуудлуудыг Цагдаагийн байгууллагын мэдээлэл судалгааны нэгжээс жил бүр гаргадаг статистик мэдээний тоон үзүүлэлт болон гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа албадын гаргасан танилцуулганд орсон олон төрлийн тоо мэдээ, судалгаанд дүн шинжилгээ хийж, хүндрэл бэрхшээлийн шалтгаан нөхцөлийг тодотгож, цагдаагийн байгууллага, ажилтнууд хэрхэн даван туулах арга замын талаар санал бодлоо солилцохыг зорьсон.

Нийт гэмт хэргийн 60 дээш хувийг /2013 онд 60,8%, 2014 онд 60,5 %, 2015 оны 09 сарын байдлаар 61,5%/ эзэлж байдаг бусдын өмчийг хулгайлах болон бусдын биед гэмтэл учруулах гэмт хэргийн гаралт тогтмол нэмэгдсээр ирсэн байдлыг харьцуулж авч үзье .⁴⁵



Улаанбаатар хотод нийт гэмт хэргийн 64,6 %-ийг буюу 13554 бүртгэгдсэн, үүнээс хулгайлах 32,9%, хүний биед гэмтэл учруулах гэмт хэрэг 25,9%-д хүрч зөвхөн энэ хоёр төрлийн гэмт хэрэг 9 сарын байдлаар 7964 буюу 58,8 %-ийг эзэлж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа хийгдсэн байна⁴⁶, үлдэх 4 дүгээр улиралд дээрх тоо, хувь нэмэгдэж 65 дээш хувьд хүрэх магадлалтай гэсэн урьдчилсан таамаглал байна.

Иймд хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны дийлэнх нь дээрх хоёр төрлийн гэмт хэргүүдэд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан ажиллагааг явуулж байгаа бөгөөд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын ажлын 60-аас дээш хувь ноогдож байна үзэж болно.

⁴⁴ мөн статистик мэдээ 2015,09 сар

⁴⁵ Монгол улс дахь 2014 оны гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал эмхтгэл 96, 97, 106 хуудас

⁴⁶ Мөн статистик мэдээ 2015,09 сар

Өөрөөр хэлбэл, хулгайлах, болон бусдын биед гэмтэл учруулах гэж зүйлчлэгдсэн хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмт хэргүүдэд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулах явцад, гэмт хэргийг мөрдөн шалгаж шийдвэрлэхэд гарч байдаг хүндрэл бэрхшээлийн дийлэнх нь бий болдог.

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд энэ хоёр төрлийн гэмт хэргийн эзлэх хувь жил бүр нэмэгдэхээс гадна, шийдэж чадаагүй тулгамдаж буй асуудлын хэмжээ улам л хуримтлагдсаар байна.

Зарим төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргүүдэд хийгддэг байцаан шийтгэх ажиллагаа цаг хугацаа, хүч хөдөлмөр орсон их ажиллагаа шаардсан байдаг боловч ажиллах алба хаагч нь дадлага туршлагатай, хяналт тавих прокурор, дарга нарын байнгын удирдлаганд ажилладагаар хүндрэл бэрхшээл харьцангуй бага боловч гардаг.

2.Хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагаанд байнга гарч байгаа хүндрэл, бэрхшээл, шалтгаан нөхцөл

Хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагаанд байнга гарч байгаа хүндрэл, бэрхшээлийн шалтгаан нөхцөлийг алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой болон бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой бий болдог гэж зааглан, боловсронгуй болгох арга замын талаар тусад нь авч үзэх хэрэгтэй юм.

Улаанбаатар хотын дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажил хариуцсан тасгийн дарга нараас хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагаанд гарч байдаг хүндрэл бэрхшээлийн талаар явуулсан асуулганд ирүүлсэн хариултанд хийсэн харьцуулсан судалгаагаар доорхи хүндрэл бэрхшээл үүсгэж байгаа хүчин зүйлүүдийг дээрх байдлаар хоёр хуваан, дараалалд оруулахыг оролдсон болно.

1.Алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой бий болсон:

Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад алба хаагчдын үйл ажиллагаатай холбоотой бий болдог хүндрэл, бэрхшээлүүдээс байнга давтагдан яригддаг, шийдвэрлэж чадаагүй, шийдвэрлэх боломж байгаа дараах шалтгаануудыг сонгон авч үзье.

а.Нэг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчид ноогдох ажлын ачаалал харьцангуй их байдгаас иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн гомдол мэдээлэл, болон үүсгэн шалгаж байгаа эрүүгийн хэргийг хуулийн хугацаанд, бүрэн гүйцэд шалгаж шийдвэрлэхэд учир дутагдалтай байдаг энэ нь байцаан шийтгэх ажиллагааны чанарт хамгийн их нөлөөлж байна.

б.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын ажлын дадлага туршлага, хууль хэрэглэх чадвар сул байгаа нь зохиомол ачаалал үүсгэдэг, ЭБША-ны зөрчил дутагдал гаргадаг, прокурорын хараат байдалд ордог байдал түгээмэл байна.

в.Хэсгийн байцаагч, эрүүгийн төлөөлөгч нар хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байгаа тохиолдолд гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах ажиллагаанд ажлын дадлага туршлага, мэдлэг шаардлагын түвшинд хүрэхгүй байгаагаас ЭБША-ны зөрчлүүд ихээр гарч байна.

г.Тасгийн дарга хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулж байгаа алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаа, шалгаж байгаа гомдол, мэдээлэл, эрүүгийн хэрэг бүртэй танилцаж хяналт тавьж ажиллах боломж муу байгаа нь алба хаагчдын ажлын чанар үр дүнд нөлөөлж байна.

д.Тасгийн даргын эзгүйд хэрэг бүртгэгч нар Мөрдөн байцаах тасгийн дарга, ахлах мөрдөн байцаагч нарт хэрэг бүртгэлтийн хэрэг материалыг танилцуулан, прокурорт шилжүүлж байна. Хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуулийн дагуу чанартай явуулахад хүндрэл үүсгэж байна.

е.Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдолтой гомдол мэдээлэл, гэмт хэрэг шалган шийдвэрлэхэд алба хаагч төдийгүй албан тушаалнуудын ойлголт, дэмжлэг учир дутагдалтай байдаг.

ё.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын сарын дундаж ачааллыг харьцуулахад 1 мөрдөн байцаагч 13 эрүүгийн хэрэг, 17 гомдол, мэдээлэл, хэрэг бүртгэгч 8 эрүүгийн хэрэг 25 гомдол, мэдээлэл шалгаж шийдвэрлэж байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нар нэг сард дунджаар 10,5 хэрэг, 21 гомдол, мэдээлэл шалгаж санд карт шивэх, хэрэг өргөдлийг шалгахад бичдэг тогтоолыг бичихэд сард нийтдээ 57,8 цагийг зарцуулах тооцоо гарсан байдаг.

Шийдвэрлэх болон боловсронгуй болгох арга зам

1а. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн ажлын нормативыг тогтоох нь чухал бөгөөд алба хаагчдыг эрүүл мэндийг хамгаалахад хэрэгтэй юм.

1б. Ажлын дадлага туршлага эзэмшүүлэх, хууль хэрэглэх мэдлэг чадварыг сайжруулах сургалтыг прокурорын байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулах шаардлагатай.

1в. Дээрх алба хаагчид хуулиар харьяалуулсан өөр чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байдаг, ЦЕГ-ын даргын тушаалаар эрх олгох байдлаар зохицуулсан, хэрэг бүртгэх ажиллагааг хоёр дахь ажил байдлаар ханддагтай холбоотой байдаг.

1г. Тасгийн дарга нар ЭБШХ-д заасан эрх үүргийн хүрээнд ажиллах, алба хаагч нартай ажиллаж мэргэжлийн удирдлагаар хангах, арга барил дутагдалтайгаас үүдэн гардаг. Ажлын арга барил, зохион байгуулалт сайжирснаар шийдэгдэх боломжтой.

1д. ЭБШХ-ийн хүрээнд бүтэц зохион байгуулалт хийж, ахлах хэрэг бүртгэгч бий болгосноор шийдэгдэх боломжтой.

1е. Цагдаагийн байгууллагаас хамгийн ихээр анхаарал тавьж байгаа гэмт хэрэг, зөрчил, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан хаагч, дарга, прокурор, шүүхийн байгууллагын хамтын ажиллагааны үр дүнд асуудал шийдвэрлэгдэх боломжтой.

1ё. Санд лавлагаа шивэх комьютерыг өндөр хурдны интернеттэй холбогдох технологийг шийдсэнээр хугацаа багасаж асуудлыг шийдэх боломжтой юм.

2. Бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой

а. Үйлдэгдсэн гэмт хэргийн хохирлын хэмжээг тодорхойлох нь хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажиллагаанд тулгамдсан гол асуудлын нэг болоод байна. Одоогийн нөхцөлд эрүүгийн хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн үнэлгээг дүүргийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх “Үнэлгээний комисс” албан тушаалтнууд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн гаргасан үнэлгээний хуудсанд үнийн дүнг тавих байдлаар тогтоож байна. Энэ байдалд ЭБШ ажиллагааны зарим оролцогч нар гомдол гаргаж, энэ үйлдлийг хууль бус гэж гомдол гаргадаг. Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 3.1.1-т “үнэлгээчин” гэж хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг ойлгоно гэж заасан. Мөн хуулийн 5.1. Хөрөнгийн үнэлгээг дараахь үндэслэлээр хийнэ: 5.1.1. үнэлгээчин болон үйлчлүүлэгч харилцан тохиролцсон; 5.1.2. хуульд тусгайлан заасан тохиолдолд эрх бүхий этгээдийн шийдвэрээр гэж тус тус хуульчилж өгсөн.

Зарим төрлийн шинжилгээний дүгнэлтүүд голчлон шүүх нягтлан бодох бүртгэлийн дүгнэлтүүд гарахдаа цаг хугацаа алдаж гардгаас ЭБША-ны зөрчил үүсэх хэргийг шийдвэрлэх хугацаа алдах тохиолдлууд гарч байна.

б. 2013 оны 10 дугаар сараас эхлэн Прокурорын байгууллага эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа этгээдийг Монгол улсын хилээр гадагш нэвтрүүлэхгүй байх асуудлыг хариуцан холбогдох байгууллагад уламжлан шийдвэрлэж байна. Энэ журмаар зөвхөн эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдаж, батлан даалт болон гадагш

явахгүй байх баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан этгээдийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн саналыг үндэслэн Монгол улсын хилээр гадагш нэвтрүүлэхгүй байх арга хэмжээ авдаг. Харин эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдаагүй боловч эрүүгийн хэрэгт холбогдуулан шалгах шаардлагатай, эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийг Монгол улсын хилээр гадагш нэвтрүүлэхгүй байх, нэвтэрсэн тохиолдолд саатуулах арга хэмжээ авах ямар ч боломжгүй болсон. Үүний улмаас гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд хуулийн байгууллагаас зугтаж, ял завших, хохирсон иргэд уурлаж бухимдах зэрэг нөхцөл байдал бүрдсэн ба нилээдгүй тооны эрүүгийн хэрэг \гэмт хэрэг үйлдсэн этгээд нь тодорхой\ сэжигтэн, яллагдагчаар татагдвал зохих этгээд нь тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр түдгэлзэж байна.

в.Эрүүгийн хэргийн сэжигтэн, яллагдагч нарт хуульд заасан үндэслэл журмын дагуу, шүүгчийн захирамжаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авдаг. Зарим тохиолдолд цагдан хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч нар “өлсгөлөн зарлах” хэлбэрээр таслан сэргийлэх арга хэмжээгээ өөрчлүүлж батлан даалтанд гарах хууль бус аргыг хэрэглэж байна. Өлсгөлөн зарлах асуудал сүүлийн үед ихсэж, өлсгөлөн зарлавал батлан даалтанд гаргадаг гэсэн буруу ойлголт сэжигтэн, яллагдагч нарын дунд байх болсон.

г.Цагдан хорих 461 дүгээр ангид хоригдож байгаа сэжигтэн, яллагдагч нарын сэтгэцийн байдлыг тогтоолгох шинжилгээ хийлгэхээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв рүү авч явахад цаг хугацаа их зарцуулдаг, сэжигтэн, яллагдагч оргон зайлж болох эрсдэл тулгардаг, цагдаагийн алба хаагчийн амь нас, эрүүл мэндэд аюултай байдал бий болох зэрэг асуудал тулгарч байна.

д.Хулгайлах гэмт хэргийн дуудлагын дагуу хийгдэж буй хойшлуулшгүй ажиллагаа, ул мөр илрүүлэх, бэхжүүлэх ажиллагаа хангалттай сайн хийгдэхгүй байна. Энэ төрлийн гэмт хэргийн “хэргийн газрын үзлэг” нь зөвхөн гарын мөр, гутлын мөр илрүүлэх чиглэлээр хийгдэж байгаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж илрүүлэх ажиллагаанд тус дөхөм болж чадахгүй байна.

е.Хэргийн холбогдогч байсаар байхад прокурорын дуудсан цагт ирээгүй гэх үндэслэлээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтанд буцаадаг тохиолдол гарч байна. Иймд прокурорт хэрэг шилжсэн тохиолдолд хяналт тавьж буй прокурор холбогдогчийг хэргийн хамт хариуцан хүлээн авч шаардлагатай тохиолдолд Шүүхийн байгууллагын адил таслан сэргийлэх арга хэмжээг дахин авч байх.

ё.Шүүх эмч нар цогцосны гадна үзлэгт оролцохдоо цогцосны байдлын талаар хэт товч мэдээлэл өгөх, нас барсанаас хойш хэдэн цаг өнгөрсөн байх боломжтой талаар шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж хэлэхгүй тохиолдол гардаг. Энэ байдалд анхаарч цогцосны гадна үзлэгийг дэлгэрэнгүй байдлаар мөрдөн байцаагчид мэдээлэл өгч, нас барсан хугацааг тогтоож буй арга, аргачиллын талаар дэлгэрэнгүй тайлбарлан тэмдэглэлд тусгуулж байх

з.Цагдаагийн байгууллагын төсөвт эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардал тусгайлан батлагдаж байгаагүйгээс хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг шуурхай явуулахад хүндрэл учирч байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар байцаан шийтгэх ажиллагааны зардлыг төр хариуцахаар хуульчилсан боловч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах ажиллагаанд хохирогч, түүний төлөөлөгч, гэрч, хөндлөнгийн гэрч, мэргэжилтэн, шинжээч, орчуулагч, хэлмэрчийг оролцуулах, шинжилгээ хийлгэж үнэлгээ, дүгнэлт гаргуулах зэрэг хөрөнгө мөнгө шаардсан байцаан шийтгэх ажиллагаатай холбогдож гарсан бусад зардлуудыг сэжигтэн, яллагдагчаар гаргуулан төлбөр хийлгэж байна.

Эдийн засгийн хохирол ихтэй гэмт хэргүүдэд санхүүгийн шинжээч томилоход мэргэшсэн шинжээч, нягтлан бодогч оролцуулах тохиолдолд ажлын хөлсийг цаг,

хоногоор тооцож хэт өндөр өртөг зардлаар дүгнэлт гаргаж иргэд байгууллагад чирэгдэл учруулж байна.

Шийдвэрлэх болон боловсронгуй болгох арга зам

2а. Хуульд зааснаар үнэлгээ хийж байгаа этгээд нь хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байх, эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэлгээ хийх буюу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн үнэлгээ хийх талаар гаргасан тогтоол, шийдвэрийн дагуу үнэлгээ хийж байх асуудлыг шийдвэрлэх

2б. Эрүүгийн хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татаж шалгах шаардлагатай, эрэн сурвалжлагдаж буй этгээдийг улсын хилээр гадагш нэвтрүүлэхгүй байх, нэвтэрсэн тохиолдолд саатуулан мэдэгдэж байх асуудлыг прокурор, шүүхийн байгууллагатай хамтран шийдвэрлэх

2в. Тухайн сэжигтэн, яллагдагч өлсгөлөн зарласнаас хойш тодорхой хугацаа өнгөрсний дараа өлсгөлөнг зогсоож, албадан эмчилгээнд оруулдаг байх талаар хуульд тусгаж өгөх

2г. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн шинжээч эмч нарыг тогтсон цаг хугацаанд Цагдан хорих байранд ирж ажиллуулж байх асуудлыг ХЗЯ-д хүргүүлж шийдвэрлүүлэх

2е. УИХ-аар хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа хуулиуд шинэчлэгдэн батлагдсанаар дээрх асуудлууд шийдвэрлэгдэх боломжтой болно. Ингэснээр прокурорын хяналтын шатнаас яллагдагч оргон зайлдаг явдал багасна.

2ё. Шүүх шинжилгээний төв, шүүх эмч хамтын ажиллагааг сайжруулах, сургалт зохион явуулах, Шүүх эмчээс шаардлагатай мэдээллийг хууль журмын дагуу авдаг болох талаар харилцан ойлголцох

2з. Байцаан шийтгэх ажиллагааны зардлыг Цагдаагийн байгууллагын төсөвт суулгах асуудал шийдвэрлэгдэх боломжтой.

Дүгнэлт

Дээрх шалтгааныг багасгаж чадвал хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явц дахь хүндрэл бэрхшээл байхгүй болж иргэдээс цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд өгч байгаа үнэлэмжид эерэг хандлагыг нэмэгдүүлэх нэгэн бодит боломж болж байна.

Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчдын гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх ажилд илүү цаг зарцуулах нөхцөл бололцоог хууль зүйн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай.

А.Мөнх-Эрдэнэ

Үндэсний тагнуулийн академийн дэд захирал

**КОМПЬЮТЕРИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ
ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТ БҮРДҮҮЛЭХ НЬ**

Гэмт хэрэг мөрдөхөд тулгамдаж буй асуудал сэдэвт эрдэм шинжилгээний хурлын сэдвийн хүрээнд тодорхой төрлийн гэмт хэргийг мөрдөхөд тулгамдаж буй асуудлуудыг дэвшүүлэн хэлэлцэхээр зарлагдсан байх тул өөрийн судалгааны ажлын хүрээнд авч үзэж буй Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн ЭБША-ны явцад

хууль сахиулах байгууллагад тулгамдаж буй зарим асуудлуудад та бүхний анхаарлыг хандуулахыг хүслээ.

Компьютер ашиглан үйлдсэн гэмт хэрэг хэдийд анх гарсныг нарийн хэлэхэд хэцүү хэдий ч “Компьютерийн гэмт хэрэг” гэдэг нэр томъёо 1960-аад оны эхэн үед электрон тооцоолон бодох машин ашиглан үйлдсэн гэмт хэргийн анхны тохиолдлыг илрүүлсний дараа анх Америкт дараа нь Европын улсуудын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хэрэглэгдэх болжээ. Тухайн үед криминологийн болон эрүүгийн эрх зүйн үндэслэл байхгүй байсан хэдий ч уг нэр томъёог хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон эрдэмтэн судлаачид өргөн ашиглах болсон байдаг.

Судалгааны байгууллагуудаас гаргасан тоо баримтаас харахад, компьютерийн гэмт хэргээс учирч буй хохирол нь мансууруулах бодисын хууль бус эргэлтээс олдог орлоготой тэнцэх болжээ. Зөвхөн АНУ-д иймэрхүү гэмт хэргийн улмаас учирч буй хохирол 100 миллиард долларт хүрч байгаа нь гэмт этгээдүүд манай улсын ДНБ-нээс даруй 5 дахин их орлого олж буй хэрэг юм. Тус улсын далд эдийн засагт бий болж буй хууль бус энэхүү орлого бол илэрч тодорхой болсон хэсэг нь бөгөөд илрээгүй үлдэж буй хувьд үүнээс хэд дахин өндөр байж болох талаар хуулийн байгууллагууд нь хүлээн зөвшөөрч байна. Харин дэлхий нийтийн хувьд 500 тэрбум ам.долларын хохирол амсдаг гэсэн тооцоо байгаа юм. Вашингтонд төвтэй Үндэсний стратеги, олон улсын судлалын хүрээлэнгийн эдийн засаг, арга зүйн мэргэжилтнүүд цахим сүлжээний хамгаалалтын “McAfee” компанитай хамтран дээрх судалгааг явуулсан байна.

Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг нь үндэстэн дамнасан шинж чанартай болж орчин үеийн технологийг ашиглан үндэсний мэдээллийн нөөц баялаг, түүний эрх ашигт заналхийлэх, аливаа халдлагаас хамгаалах асуудал нь өдгөө нэг үндэстний хэмжээнд бус, дэлхийн олон улсын өмнө хурцаар тавигдаж байгаагийн тодорхой илрэл нь 1989 онд Европын холбооноос батлан гаргасан зөвлөмж, Европын зөвлөлөөс 2011 онд батлан гаргасан “Кибер гэмт хэрэг”-тэй тэмцэх тухай Будапештийн конвенц юм. Энэхүү олон улсын хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актаас өөр томоохон түвшний хамтын ажиллагаа, механизм одоохондоо байхгүй байна. Конвенцид богино хугацаанд дэлхийн 53 улс нэгдэн орсон нь уламжлалт бус, шинэ төрлийн энэхүү гэмт хэргийн хор аюул улс гүрнүүдэд хэр зэрэг тулгамдаж байгаа нь тодорхой харагдаж байгааг илэрхийлсэн хэрэг юм.

Конвенцийн хэм хэмжээ нь 3 үндсэн бүлэг асуудлыг зохицуулахад чиглэгдсэн байна.

Үүнд:

1. Компьютерийн мэдээллийн хүрээн дэх гэмт хэргийн тухай эрүүгийн эрх зүйн нэгдсэн ойлголтыг бий болгох
2. Энэ төрлийн гэмт хэрэгт нотлох баримт цуглуулахад чиглэгдсэн үндэсний эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн арга хэмжээнүүдийг хооронд нь ойртуулах
3. Ийм гэмт хэрэг хилийн чанадад үйлдэгдсэн тохиолдолд олон улсын хэмжээнд хамтран ажиллах хэлбэрүүдийг тогтооход чиглэгдсэн байхаар зохицуулагдсан байна.

Кибер гэмт хэрэг нь дэлхийн улс гүрнүүдийн нэгэн адил Монгол Улсын хувьд ч үүсэж буй аюул заналын нэг билээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6-д “Мэдээллийн салбарт үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэс мөн” гэж тодорхойлсон.

Харин Монгол Улсын хувьд Эрүүгийн хуулийн XXV бүлэгт “Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийг тусгаж өгсөн ч мэдээллийн технологийн үсрэнгүй хурдаар хөгжиж байгаа кибер орон зай дахь нийгмийн харилцааг

зохих түвшинд хамгаалахад учир дутагдалтай байна гэж үзэх үндэслэл байгаа. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 226-229 дүгээр зүйл ангиудад Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг гэж төрлийн объектоор ангилан тусгаж өгсөн байгаа явдал нь цаг үеийн бодит шаардлага хангахгүй, зохицуулах зарим төрлийн харилцааг орхигдуулж байна гэж судлаачид дүгнэдэг.

Будапештийн конвенцод Компьютер ашиглан үйлдсэн 9 төрлийн гэмт хэргийн 16 төрлийн үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцож дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хориглосон байдлаар хуульчлахыг нэгдэн орсон гишүүн улс орнууддаа зөвлөдөг.

Будапештийн конвенцийн гол зорилгын нэг нь энэ төрлийн гэмт хэрэгт нотлох баримт цуглуулахад чиглэгдсэн үндэсний эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн арга хэмжээнүүдийг хооронд нь ойртуулах явдал болохыг өмнө дурьдсан. Мэдээллийн технологийн хөгжлийн хурд минут, секундээр хэмжигдээд байгаа өнөө үед кибер гэмт хэрэг өдүүлэгчдийн эсрэг тэмцэх чадавхийг бүрдүүлэх нь аливаа улсын Засгийн газар, хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагын хувьд нэн тэргүүний тулгамдсан зорилтын нэг байх ёстой.

Reporters without Borders гэж Канадад төвтэй олон улсын хэмжээнд хэвлэлийн эрх чөлөөнд судалгаа хийж, тайлан илтгэл гаргадаг байгууллага бий. Тус байгууллагын хийсэн сүүлийн үеийн судалгаагаар Монгол улс **“no censorship country”** буюу **интернетийн бүрэн эрх чөлөөтэй улс орон** гэсэн ангилалд хамрагдсаар өнөөдрийг хүрсэн нь мэдээллийн аюулгүй байдлыг хангах орчин талаасаа харвал сайшаалтай үзүүлэлт биш юм. Интернет хэрэглээний хяналтгүй байгаа байдал нь кибер гэмт хэрэг өдүүлэгчдийн хувьд гэмт хэрэг үйлдэх таатай орчин болох бүрэн боломжийг олгож байна.

2010-2013 онд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тухайлбал, “Wikileaks.org” сайтаар Монгол Улсын Засгийн газар Английн “Finfisher” компаниас өндөр өртөг бүхий тагнуулын програм хангамж 1.358.260 еврогоор худалдан авсан мэдээлэл тархсан нь нэгэнт нийтэд ил болсон мэдээлэл бөгөөд хакерууд тус компаний “database”-д халдаж олзолж авсан байдаг. Мөн саяхан АТГ Итали улсын “Hacking team” компаниас 220.000 еврогоор “Remote control system” буюу сүлжээний хяналтын систем худалдан авсан тухай мэдээлэл тархсан. Энэ нөхцөл байдлаас дүгнэлт хийж үзвэл мөрдөн байцаалт явуулах чиг үүрэг бүхий ТЕГ, АТГ гэсэн байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай техникийн шийдэл бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т зааснаар Комьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдэд мөрдөн байцаалт явуулах чиг үүргийг цагдаагийн байгууллага хүлээж байгаа. Тус хуулийн 27.4 “цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч нь энэ хуулийн 27.1, 27.3-т зааснаас бусад **хүндэвтэр, хүнд, онц хүнд** гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулна” гэж заасан байна.

Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлгийн Компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн 4 зүйл ангид заагдсан гэмт хэргүүдээс 229.1-д заасан “Компьютерийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр устгах, хаах, өөрчлөх болон хуулбарлах зорилгоор компьютерийн програм зохион бүтээх, програмд өөрчлөлт оруулах, нянтай программыг тусгайлан зохион бүтээх, түүнийг мэдсээр байж ашигласан, тараасан...” үйлдэл нь хөнгөн гэмт хэргийн бүрэлдэхүүнийг агуулж байгаа. Үүнээс бусад төрлийн кибер гэмт хэргүүдэд цагдаагийн байгууллага мөрдөн байцаалт явуулах эрх зүйн зохицуулалт үйлчилж байна.

Кибер гэмт хэрэгтэй тэмцэх, кибер гэмт хэргийг илрүүлэх, шүүхийн өмнө нотлох баримт бүрдүүлэх үйл ажиллагааг **“Цахим форенсикс”** гэж нэрлэдэг. Цахим форенсикс

явуулах энэ чиг үүргийг ЭЦГ-ийн “Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс” хариуцан ажиллаж байна. 2015 онд цагдаагийн байгууллагын удирдлага тус хэлтсийг шинээр төлөвлөн, бүтэц орон тоог өргөжүүлэн зохион байгуулсан нь сайшаалтай.

Цахим форенсикс явуулах чадавхыг дээшлүүлснээр дараах ач холбогдолтой юм.

1. Хэдийгээр кибер гэмт хэрэг өдүүлж буй этгээдүүд өөрсдийн өдүүлсэн кибер гэмт хэргийг нуун далдлах зорилгоор өөрсдийн файл, мэдээллийг устгах, хатуу дискээ форматлах зэрэг үйлдлийг байнга хийдэг боловч цахим форенсиксийн чадамжийг хангаж чадсанаар устгасан файл, и-мэйл, мэдээллийг сэргээх техникийн бүрэн боломж бий.

2. Гэмт этгээдүүд хууль бус гэмт үйлдлүүдээ нуух аргуудыг гаргууд эзэмшсэн байдаг. Цахим форенсиксийн хүрээнд хайлтын технологи ашиглан нуусан файлуудыг олох техникийн чадамж бий болсныг гадны өндөр хөгжилтэй улс орнуудын хууль сахиулах байгууллагууд нэгэнт ашиглаж эхэлсэн.

3. Кибер гэмт хэрэг өдүүлэгчид өөрсдийн гэмт үйл ажиллагааны ул мөрийг баллахын тулд, эсвэл баригдахгүйн тулд утасгүй сүлжээ ашиглах, бусад хэрэглэгчдийн IP хаяг ашиглах, интернет кафе ашиглах нь түгээмэл тул тэдний энэхүү үйл ажиллагааны эсрэг шуурхай арга хэмжээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тухайн улсын Хууль тогтоох байгууллага, холбогдох эрх бүхий байгууллагаас цахим форенсикс явуулах чиг үүрэгтэй хууль хяналтын байгууллагуудад интернет үйлчилгээ үзүүлэх компаниуд, нийлүүлэгчидтэй хамтран ажиллах боломжийг нь хууль зүйн хүрээнд нээж өгдөг.

Практикт цахим форенсикс явуулж буй мөрдөн байцаах чиг үүрэг бүхий байгууллагууд процессын ажиллагаа явуулахдаа хэдий ЭБШ хуульд заасны дагуу нотлох баримт бүрдүүлэх ажиллагааг явуулж байгаа боловч зайлшгүй анхаарах мэргэжлийн үйл ажиллагааны дутагдал ажиглагдсаар байгаа юм. Тухайлбал:

❖ Хэргийн газраас нотлох баримтаар хураан авч буй компьютер, гар утас гэх мэт санах ой бүхий төхөөрөмжийг битүүмжлэлгүй, хатуу дискийг хуулбарлалгүй авч явдаг үйлдэл нь мөрдөн байцаагч, шинжээч тухайн компьютер тухайн сэжигтний өдүүлсэн гэмт үйл ажиллагааг нотлохдоо тодорхой эрх ашигт автагдан шийдвэрлэх боломжийг олгож байна гэж үзэх үндэстэй. Эд мөрийн баримтаар хураагдсан компьютер, гар утас зэрэг санах ой бүхий төхөөрөмжүүдэд агуулагдаж буй мэдээллийг тухайн үеийн байгаа байдлаар нь хуулбарлан авч тэр хуулбар дээрээ процессын ажиллагаа явуулан дүгнэлт гаргаж, шүүхэд танилцуулахдаа эх компьютерт агуулагдаж буй мэдээллийн хэмжээ, агуулгатай бүрэн нийцэж буй талаарх шинжээчийн дүгнэлтийн хамт танилцуулдаг жишиг олон улсын түвшинд нэвтэрсэн байна.

❖ Мөрдөн байцаагч, шинжээч тухайн кибер гэмт хэргийн нотлох баримтаар хураагдсан санах ой бүхий хатуу дисктэй төхөөрөмж дээр ажиллахдаа автоматаар болон зориудаар интернет холболт хийгдэхгүй нөхцөлийг бүрдүүлж ажиллах шаардлага тавигддаг. Энэ нь эрсдэл дагуулдаг тул нотлох баримт устах, өөрчлөгдөх зэрэг үйлдлээс зайлсхийх арга болдог ач холбогдолтой юм.

❖ Мөн тухайн компьютер дээр агуулагдаж байх вируст үнэлгээ хийхийг АНУ-ын шүүхийн практик шаардах болсон байна.

Эрүүгийн цагдаагийн газрын Цахим гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст жилд дунджаар 30-70 орчим энэ төрлийн гэмт хэргийн шинжтэй үйлдэл шалгагдаж, шийдвэрлэгдэж байна. Сүүлийн жилүүдэд энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байгаа нь зайлшгүй анхаарч судлах ёстой асуудал мөн.

Эцэст нь компьютерийн мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнийг олон улсын жишгийн дагуу дахин авч үзэж, Эрүүгийн хуульд тусгах

зайлшгүй шаардлага байгаагийн зэрэгцээ кибер гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий нэгжүүд, чадавхийг хууль сахиулах чиг үүрэг бүхий аль нэг байгууллагын эгнээнд нэгтгэн дахин төлөвлөн зохион байгуулж, нэгдсэн бодлого удирдлагаар хангаж ажиллах нь манай орны эрүүгийн нөхцөл байдалд оновчтой хувилбар байх болно гэдгийг судлаачийн хувьд цохон тэмдэглэж байна.

Б.Цогтбаатар

*Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
мөрдөх хэлтсийн ахлах мөрдөн байцаагч,
цагдаагийн дэд хурандаа*

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЖУРМЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, МӨРДӨХӨД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Эрүүгийн хуулийн 23 дугаар бүлэгт тодорхойлсон Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргүүдээс аль зүйл хэсэгт заасан гэмт хэрэг нь Монгол Улсад зонхилон үйлдэгдэж байна вэ гэдгийг тогтоож, эдгээр гэмт хэргийг мөрдөхөд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар санал дэвшүүлсэн.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг сүүлийн 10 жилд бүртгэгдсэн байдлыг харуулбал:

Он	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	Нийт
Хэрэг	35	50	54	88	277	318	264	300	461	338	378	2563

Үүнээс шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг:

Он	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	Нийт
Хэрэг	14	23	12	26	111	124	117	168	211	180	175	1161
Ял шийтгүүлсэн хүн	23	41	30	50	212	261	187	282	330	277	268	1961

Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилд байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг: 2011 онд 270, 2012 онд 461, 2013 онд 338, 2014 онд 378, 2014 оны эхний 8 сард 168, 2015 оны эхний 8 сард 144 нийт 1624 хэрэг бүртгэгдсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулвал:

ЭХ-ийн 23 дугаар бүлэг		2011 онд	2012 онд	2013 онд	2014 онд	2014 оны эхний 8 сар	2015 оны эхний 8 сар	Нийт
202-р зүйл	Агаар бохирдуулах							
203-р зүйл	Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих	34	50	55	37	30	29	205
204-р зүйл	Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчих				1	1	1	2

205-р зүйл	Байгаль орчныг бохирдуулах							
206-р зүйл	Химийн гаралтай хорт бодис, үйлдвэрлэлийн хог хаягдал цэвэрлэх, тээвэрлэх, булшлах журам зөрчих							
207-р зүйл	Газрын хөрс, усыг бохирдуулах			1	5			6
208-р зүйл	Усны тухай хууль тогтоомж зөрчих		1	4	2		1	8
209-р зүйл	Ургамлын өвчин, хортон амьтантай тэмцэх талаар тогтоосон журам зөрчих							
210-р зүйл	Байгалийн объектыг санаатай эвдэх, гэмтээх, устгах							
211-р зүйл	Ойн тухай хууль, тогтоомж зөрчих	241	277	202	255	132	81	1056
212-р зүйл	Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих	5	16	7	8		2	38
213-р зүйл	Ой, хээрийн түймэр тавих	7	16	13	11		3	50
214-р зүйл	Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох	12	97	52	50	21	24	235
214-р зүйл	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомж зөрчих	1	4	4	9	3	6	24
Нийт		300	461	338	378	168	144	1624

Судалгаагаар цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн байгаль орчны эсрэг нийт гэмт хэргийн дотор “Ойн тухай хууль тогтоомж зөрчих” гэмт хэрэг 65-70 хувь, “Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих” гэмт хэрэг 11-13 хувь, “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэг 12-15 хувийг эзэлж байна.

Дээрх 3 хэрэг нь энэ төрлийн гэмт хэргийн 92-95 хувийг эзэлж байна.

Бүртгэгдсэн нийт хэргийн 45.3 хувь нь шүүхээр шийдвэрлэгдсэнээс ойн тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэрэг 865 буюу 74.5 хувийг, ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 196 буюу 16.8 хувийг, хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох гэмт хэрэг 45 буюу 3.8 хувийг тус тус эзэлж байна.

2015 оны эхний 8 сард иргэд байгууллагаас ирүүлсэн 694 гэмт хэргийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснээс 144 буюу 20.7 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн, 442 буюу 63.6 хувийг нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна.

2015 оны эхний 8 сард бүртгэгдсэн гэмт хэрэг урд оны мөн үетэй харьцуулахад 14.2 хувиар буурсан. Үүний дотор:

Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 38,6 хувиар, Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 3.3 хувиар буурсан боловч Байгалийн ургамлын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг 2 дахин, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг 14.2 хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд түдгэлзүүлсэн 174 хэрэг байна, үүнээс 107 буюу 61.4 хувь нь эзэнгүй, 27 буюу 15.5 хувь нь сэжигтэн яллагдагч оргон зайлсан эсхүл хаана байгаа нь тодорхойгүй, 34 буюу 19.5 хувь нь шаардлагатай гэрч хохирогч байхгүй үндэслэлээр түдгэлзүүлсэн байна.

Үүнээс үндэслэн байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал нь дээрх 3 төрлийн хэргийн гэмт хэргийн нөхцөл байдалтай голлон хамааралтай байх тул эдгээр хэргийн өнөөгийн нөхцөл байдал, мөрдөхөд тулгамдаж буй асуудлын талаар авч үзэх нь зүйтэй байна.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн талаар:

2015 оны 01 дүгээр сарын уул уурхайн статистик мэдээгээр хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 2691, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо 1396, хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 1295, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай 10.6 сая га, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай 1.1 сая га, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай 9.5 сая.га, нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрлийн талбайн эзлэх хувь 6.8%, үүнээс ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь 0,8 хувь, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь 7,7 хувь, ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь 17.6%, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд уул уурхайн үйлдвэрлэлийн эзлэх хувь 68.7% байсан бол 2015 оны 09 дүгээр сарын байдлаар хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо 3136, ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо 1459, хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо 1677, хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай 13.3 сая га, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай 1.2 сая га, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай 12.1 сая.га, нийт нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрлийн талбайн эзлэх хувь 8.5%, үүнээс ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь 0,8 хувь, хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайн эзлэх хувь 7.7 хувь, ДНБ-д уул уурхайн салбарын эзлэх хувь 17.1%, аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлд уул уурхайн үйлдвэрлэлийн эзлэх хувь 66.2% байна.

Үүнээс харахад:

д/д	Харьцуулах зүйл	2015 оны 01 дүгээр сар	2015 оны 09 дүгээр сар	Харьцуулалт
1	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо	2691	3136	445 буюу 16,5 хувиар өссөн
2	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн тоо	1396	1459	63 буюу 4,5 хувиар өссөн
3	Хайгуулын тусгай зөвшөөрлийн тоо	1295	1677	382 буюу 29,4 хувиар өссөн
4	Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл бүхий талбай	10.6 сая га	13.3 сая га	2,7 сая га буюу 25,4 хувиар өссөн
5	Нийт нутаг дэвсгэрт	6.8%,	8,5%,	1,7 буюу 25

тусгай зөвшөөрлийн талбайн эзлэх хувь			хувиар өссөн байна
---------------------------------------	--	--	--------------------

Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилд хууль бусаар ашигт малтмал хайх, олборлох 211 гэмт хэрэг бүртгэгдсэнээс шүүхээр 24 гэмт хэрэгт 28 хүн ял шийтгүүлсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 11,3 хувь нь л шүүхээр шийдвэрлэгдсэн байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох болон мөрдөн байцаах ажлын үр дүн муу байгааг харуулж байна.

Нийт түдгэлзүүлсэн хэргийн 21 буюу 12,0 хувь нь хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг байна.

Энэ төрлийн гэмт хэрэг мөрдөхөд гарч буй хүндрэл, тулгамдаж буй шалтгаан, нөхцөл байна. Үүнд:

- Сүүлийн жилүүдэд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид Газрын тухай, Ойн тухай, Усны тухай, Ашигт малтмалын тухай хууль тогтоомж, Засгийн газрын 2010 оны 308 дугаар тогтоолоор баталсан “Бичил уурхай ашиглах журам” зэргийг илт зөрчсөн “Нөхөн сэргээлт хийлгэх тухай” олон тооны тогтоол, шийдвэр гаргасан. Эдгээр шийдвэр нь эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх санхүүгийн эх үүсвэрээ тухайн газарт олборлолт явуулж ашигт малтмал ашиглах хууль бус боломж олгосон учир нөхөн сэргээлт нэрийн дор хууль бусаар олборлолт явуулах боломжийг хангаснаар энэ бизнесийн үйл ажиллагаанд олон аж ахуйн нэгж, иргэд оролцох хүсэл сонирхолтой болсон. Тухайлбал: Сэлэнгэ аймгийн Ерөө сумын засаг дарга, ИТХ-ын дарга нар 2015 онд 82 аж ахуйн нэгж иргэн, нөхөрлөлтэй нөхөн сэргээлт хийх, зардлаа эвдэгдсэн газарт байгаа ашигт малтмалыг дахин олборлож олох эрх олгосон шийдвэр гаргасан байна.
- Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлж, бүртгэхэд зайлшгүй хийгдэх байгаль орчинд учирсан хохирлын хэмжээг тогтоолгох шинжилгээний зардал цагдаагийн байгууллагын төсөвт байхгүйгээс гэмт хэрэг бүрэн бүртгэгдэхгүй, шийдвэрлэгдэхгүй байгаагаас хэрэг, зөрчил таслан зогсоогдохгүй байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар 2015 оны 3 дугаар улиралд хууль бус олборлолттой холбоотой 25 гомдол мэдээлэл шалгаснаас 3-д нь буюу 12 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэсэн байна. Энэ нь байгаль экологид учирсан хохирлыг бодитой тогтоож чадахгүй байгаагаас шалтгаалж байна.
- Байгаль орчны эсрэг гэмт хэрэг ялангуяа хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг нь тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник ашиглан үйлдэгддэг. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, техникийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураах зохицуулалт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, мөн Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хуулиудад тусгагдсан боловч Улсын дээд шүүхийн 2006 оны 01 тоот тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийнх нь өмчлөлийнх болох нь тогтоогдсон нөхцөлд улсын орлого болгоно гэж тайлбарласнаар энэ заалтын хэрэгжилт зогсонги байдалд орсон. Гэмт хэрэг үйлдэгсэд өөрийн өмчлөл, эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, техник хэрэгслийг ашиглахаа больсон, бусдын эзэмшлийн өмч хөрөнгийг түрээслэх, түр хугацаагаар ашиглах болсон учир хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй болж иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай эрүүгийн хариуцлагын зорилго бүрэн хэрэгжих нөхцөлийг үгүйсгэж байна. Тодруулбал: Байгаль хамгаалах журмын эсрэг

гэмт хэрэг сүүлийн 5 жилд 1740 бүртгэгдэж шүүхээр 48,9 хувь буюу 851 хэрэг шийдвэрлэгдсэн ба эдгээр гэмт хэргийг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, тусгай зориулалтын техник хэрэгсэл 66 ширхэгийг улсын орлого болгосон ба эдгээр хууль бус мод бэлтгэл, агнуурын хэрэгт хураагдсан судалгаа байна.

- Энэ төрлийн гэмт хэрэг өссөн үндсэн нэг шалтгаан нь Улсын Их Хурал 2015.02.18-ны өдөр “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж хязгаарлалтанд орсон зарим тусгай зөвшөөрлүүдийн захын цэгийг шинэчлэн тогтоож сэргээх шийдвэр гаргасныг олон нийт ялангуяа хууль бус олборлогчид урт нэртэй хуулийг цуцалсан мэдээлэл түгээж үйл ажиллагаагаа эхэлсэн явдал юм.

Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн талаар:

Монгол Улсын ойн сангийн нийт талбай 18.3 сая.га, 140 гаруй зүйлийн мод, сөөгөөс бүрэлдэх бөгөөд 1.4 тэрбум шоометр модны нөөцтэй ба нутаг дэвсгэрийн 11.89 хувийг эзлэх бөгөөд ойрхог чанар нь 8.03% байна. Үүний 76.3% хувийг болц гүйцсэн хөгшин ой эзэлж байна.

Монгол Улсын ойн сангийн ихэнх хувийг эзлэх шилмүүст, навчит ойн талбай сүүлийн 12 жилийн өөрчлөлтөөс үзэхэд ойгоор бүрхэгдсэн талбай 289.8 мян.га талбайгаар хорогдсон байхад ойгоор бүрхэгдээгүй талбай 868.4 мян.га талбайгаар нэмэгдсэн байна.

Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Ойн судалгаа хөгжлийн төвөөс хийсэн судалгаагаар, Монгол Улсад жилд хоёр сая шоометр, үүнээс нийслэлд 540 мянган шоометр түлээний хэрэгцээ байгаа боловч улсын хэмжээнд жилдээ 667 мянган шоометр түлээ хэрэглэж байна. 2009-2014 онд жил бүр 503.8-1128.4 мян.м³ буюу дунджаар жилд 841.0 мян.м³ мод ойгоос бэлтгэн иргэд, аж ахуйн нэгжийн мод ба модон материал, түлшний хэрэгцээг хангаж байгаа, өөрөөр хэлбэл бодит хэрэгцээнээс гурав дахин бага түлээ нийлүүлж байгаа нь тогтоогдсон байна.

Монгол Улсад бүртгэгдэж байгаа байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн 65-70 хувийг энэ төрлийн гэмт хэрэг эзэлдэг боловч сүүлийн жилүүдэд тогтмол буурч байгаа. Сүүлийн 3 жилд бүртгэгдсэн гэмт хэрэг 6.5-27.8 хувиар буурсан эерэг статистик харагдаж байгаа боловч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байгаа шалтгаан, нөхцөл арилахгүй байна.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилд хууль бус мод бэлтгэлтэй холбоотой 975 гэмт хэрэг бүртгэгдсэнээс шүүхээр 591 гэмт хэрэгт 899 хүн ял шийтгүүлсэн байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт шалгагдсан ихэнх хүмүүс нь ажил орлогогүй тул хууль бусаар мод бэлтгэж ашиг олох гэсэн санаа зорилготой байдаг бөгөөд шүүхээс оногдуулсан ялыг тэнсэн хянан харгалздаг учир давтан гэмт хэрэг үйлдэх тохиолдол гарсан байна. Иймд гэмт хэргийг илрүүлэх иргэдийн оролцоог дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах шаардлагатай байна .

Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийг шийдвэрлэхэд хохирлын хэмжээг хэрхэн тооцох асуудалд шүүх прокурорын байгууллага нэгдсэн ойлголтонд хүрч чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, экологи эдийн засагт учруулсан бодит хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар гурав дахин нэмэгдүүлж тооцоход шүүх шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан, Эрүүгийн хуулийн хууль ёсны байх зарчмыг зөрчсөн гэж дүгнэдэг.

Энэ төрлийн хэргийн шийдвэрлэлтэнд судалгаа хийхэд мод бэлтгэх зөвшөөрөл, гарал үүслийн гэрчилгээ олгох эрх бүхий албан тушаалтнуудын хариуцлагагүй үйл

ажиллагаа нь уг зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэн шалгах шалтгаан болж байгаа бөгөөд эрхийн бичигт газар, цаг хугацаа, хэмжээг бичихгүй орхигдуулж нөхөн бичиж өгч байгаа нь хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгох үндэслэл болсон байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 211 дүгээр зүйлд “Зохих зөвшөөрөлгүйгээр ой мод бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, боловсруулсан..” гэж заасан байхад хууль бусаар бэлтгэсэн модыг үл таних хүнээс худалдан авч тээвэрлэсэн хэргийг шүүх шийдвэрлэхдээ заавал бэлтгэсэн хүнийг олж тогтоолгохоор нэмэлт мөрдөн байцаалтанд буцаадаг, зарсан хүнийг нь олж тогтоох боломжгүйгээс хэрэг шийдвэрлэгдэхгүй байдалд хүрч ял завших нөхцөл бүрдүүлсэн байна. Иймд хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэрэглэх талаар зохих байгууллагад асуудал тавих шаардлагатай байгаа.

Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн талаар:

Эрс тэс уур амьсгалтай манай оронд өөр хоорондоо ялгаатай эко системд дасан зохицсон олон зүйлийн ан амьтан бүртгэгдсэнээс 28 зүйл амьтан нэн ховор, 72 зүйл амьтан ховор амьтад байна. Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор зүйл, төрөл, хүйс бүрээр өөр өөр үнэлгээ тогтоосон байдаг. Ан агнуурын тухай хууль тогтоомж зөрчсөн гэмт хэрэг нь ихэнхдээ нууц далд аргаар үйлдэгддэг гэмт хэрэг байдаг.

Манай улс амьтан, ургамлыг хамгаалах, зохистой ашиглах чиглэлээр олон улсын 4 конвенцид нэгдэн орж, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудлыг 6 үндэсний хөтөлбөрт тусган, харилцаа зохицуулсан 6 хууль, тэдгээрт нийцүүлсэн 20 гаруй журмыг мөрдөн хэрэгжүүлж байна.

Ховор, нэн ховор амьтдын түүхий эдийг уламжлалт анагаах ухааны эмийн жор, үзвэр, гоёл, бөөгийн эдлэл, хэрэгсэл, өмсгөлд болон сүлжээ рестораны махны хэрэгцээнд хэрэглэхээс гадна БНХАУ-ын зах зээл дээр эрэлт хэрэгцээ ихтэй, өндөр үнээр борлогддог тул хятад иргэдээс захиалга авч ан амьтдыг хууль бусаар агнах, барих, ангийн гаралтай түүхий эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, орон нутгийн удирдлага, албан тушаалтнууд тухайн жилийн батлагдсан агнуур зохион байгуулалтыг зөрчиж дур мэдэн ховор ан амьтан агнах зөвшөөрөл олгодог нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд нөлөөлж байна.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 4 жилд хууль бус агнууртай холбоотой 176 гэмт хэрэг бүртгэгдсэнээс шүүхээр 81 гэмт хэрэгт 181 хүн ял шийтгүүлсэн байна.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2014 оны мөн үеэс 3,3 хувиар буурсан боловч нийт түдгэлзүүлсэн хэргийн 50 буюу 28,7 хувь ан агнуурын хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийг шалган шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудал:

1. Байгаль орчны эсрэг гэмт хэргүүд нь Эрүүгийн хуульд заасан хохирол учирсан байхыг шаарддаг материаллаг бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг бөгөөд үүнийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас үнэлгээний эрх авсан хувийн аж ахуйн нэгжүүд шинжилгээний үндсэн дээр тогтоож байна. Эдгээр ашгийн төлөө байгууллагууд нь шинжилгээний төлбөрийг цагдаагийн байгууллагаас нэхэмжилдэг ба манай байгууллага төлбөрийг хэрэгт холбогдож буй аж ахуйн нэгжүүдээр төлүүлж байгаа нь маргаан үүсгэх, улмаар төлбөр төлөгдөхгүй бол дүгнэлтээ авч хэргээ шийдвэрлэж чадахгүйд хүрэх, эсхүл үндэслэл муутай дүгнэлт гаргах, хохирлын хэмжээг илтээр багасгах зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэд сөргөөр нөлөөлж байна.

Цагдаагийн байгууллага 2014, 2015 оны төсөвт 3.1 тэрбум төгрөгийг эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зардалд тусгуулах санал хүргүүлсэн боловч Сангийн яам хянаж хассан байна.

Нэгэнт төсөвт зардал суугаагүй учир цагдаагийн байгууллагаас төлбөр төлөх боломжгүй болсон. Шинжилгээ хийсэн үнэлгээний байгууллага нь төлбөр барагдуулахгүй бол дүгнэлт өгөхгүй гэсэн шаардлага тавьж, бид байгаль орчны эсрэг үйлдсэн гэмт хэргийг хуульд заасан үндэслэл журмын дагуу илрүүлж, шийдвэрлэх боломжгүй болж гэмт этгээдүүд ял завшиж байна. Одоо зөвхөн Мөрдөн байцаах газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтэст 10 хэрэгт 185.0 сая орчим төгрөгийн шинжилгээний зардлын нэхэмжлэл ирсэн байна.

2. Байгаль орчны эсрэг гэмт хэрэг гол төлөв тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник ашиглан үйлдэгддэг ба гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, техникийг хураах шийдвэр Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 48 тоот зарлиг болон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 2 дахь заалтуудад тусгагдсан боловч Улсын дээд шүүхийн 2006 оны 01 тоот тогтоолоор гэмт хэрэг үйлдсэн этгээдийн өөрийнх нь өмчлөлийнх болох нь тогтоогдсон нөхцөлд улсын орлого болгоно гэж тайлбарласан.

Иймд гэмт хэрэг үйлдэгсэд өөрийн өмчлөл, эзэмшилд бүртгэлтэй тээврийн хэрэгсэл, техник хэрэгслийг ашиглахаа больсон, бусдын эзэмшлийн өмч хөрөнгийг түр хугацаагаар гуйх эсхүл түрээслэх байдлаар авч ашигладаг аргатай болсон учир хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй болж иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх тухай эрүүгийн хариуцлагын зорилго бүрэн хэрэгжих нөхцөлийг үгүйсгэж байна.

Хэрэв хуулийн энэ заалтыг өмчийн харьяалал харгалзахгүйгээр улсын орлого болгодог байхаар зохицуулалт хийвэл байгаль орчны эсрэг гэмт хэрэг бодитой буурах боломжтой гэж үзэж байна.

Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг сүүлийн 5 жилд 1740 бүртгэгдэж шүүхээр 48,9 хувь буюу 851 хэрэг шийдвэрлэгдсэн ба эдгээр гэмт хэргийг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, унаа хөсөг, тусгай зориулалтын техник хэрэгсэл 66 ширхэгийг улсын орлого болгосон ба эдгээр хууль бус мод бэлтгэл, агнуурын хэрэгт хураагдсан судалгаа байна.

3. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг нь төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр, зөвшөөрөлтэй холбогдож тэдний эрх ашигт шууд нөлөөлж байдаг учир орон нутгийн хууль сахиулах байгууллага уг хэргийг илрүүлэх, шалгаж шийдвэрлэх явцад сөрөг нөлөө үзүүлэх, цагдаа, прокурорын байгууллагын алба хаагчдын мэдлэг ур чадвараас шалтгаалан орон нутагт мөрдөхөд хүндрэл учирдаг байна. 2012 оноос хойш, ялангуяа 2014 оны 04 дүгээр сараас хойш аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас уул уурхайн улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийлгэх сонгон шалгаруулалтыг зохион байгуулах журам баталж журмын дагуу иргэд аж ахуйн нэгжээс хандив авч эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийлгэх нэрээр хууль бусаар олборлолт хийлгэж байгаа нь мөрдөн байцаалтын ажиллагаанд хүндрэл учирч нэг талаасаа орон нутгийн төр, захиргааны байгууллага зөвшөөрсөн, нөгөө талаасаа хууль зөрчсөн зэрэг эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж байна.

4. Байгаль орчны хууль тогтоомж, эрх зүйн актуудын зөрүүтэй байдал нь хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэнд хүндрэл учруулж байна. Тухайлбал: Монгол Улсын Засгийн газрын 1995.08.25-ны өдрийн “Ховор ургамлын жагсаалт батлах тухай” 153 дугаартай

тогтоолд Засгийн газрын 2004 оны 165 дугаартай тогтоолоор нэмэлт оруулж Сибирь хуш мод, нарсны төрлийн модны үр зэрэг нь ховор ургамлын жагсаалтад багтсан байдаг.

Гэтэл Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011.11.29-ний өдрийн А-415 дугаартай “Экологи, эдийн засгийн үнэлгээ батлах тухай” тушаалаар зарим ашигт ургамлын Экологи, эдийн засгийн үнэлгээг батлахдаа “Сибир нарс-Pinussibirica” ургамлыг элбэг ургамлын жагсаалтад оруулсан нь тухайн этгээдэд гэм буруу тооцож хариуцлага хүлээлгэхэд хүндрэл учруулж байна.

Мөн Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийг шийдвэрлэхэд хохирлын хэмжээг хэрхэн тооцох асуудалд шүүх, прокурорын байгууллага нэгдсэн ойлголтонд хүрч чадаагүй байна. Өөрөөр хэлбэл, экологи эдийн засагт учруулсан бодит хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар гурав дахин нэмэгдүүлж тооцоход шүүх шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан, Эрүүгийн хуулийн хууль ёсны байх зарчмыг зөрчсөн гэж дүгнэдэг. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 203, 211, 212 дүгээр зүйлүүдэд үйлдлийг “Зохих зөвшөөрөлгүйгээр” худалдсан, худалдан авсан, хадгалсан, бэлтгэсэн, тээвэрлэсэн, боловсруулсан.” гэж заасан байхад прокурор, шүүх шийдвэрлэхдээ заавал бэлтгэсэн хүнийг олж тогтоолгохоор нэмэлт мөрдөн байцаалтанд буцаадаг, зарсан хүнийг нь олж тогтоох боломжгүйгээс хэрэг шийдвэрлэгдэхгүй байдалд хүрч ял завших нөхцөл бүрдэж байна. Иймд хуулийн заалтыг нэг мөр ойлгож хэрэглэх талаар зохих байгууллагад асуудал тавих шаардлагатай байна.

5. Монгол Улсын усны сан бүхий газар нийт нутаг дэвсгэрийн 686.8 мянган га буюу 0.44 хувийг эзэлж байна. Судалгаагаар нийт 229.7 га хохиролд өртсөнөөс гадаргын болон гүний усны бохирдолттой 6.1 га, ашигт малтмалын олборлолтоос хохиролд өртсөн эрэг хавийн газар 58.7га, бусад шалтгаанаар хохирсон 164.9 га газар бүртгэгджээ. Улсын хэмжээнд ашигт малтмалын олборлолтоос эвдрэлд өртсөн эрэг хавийн газар, бусад шалтгаанаар хохиролд орсон газар Говь-Алтай, Ховд, Хөвсгөл, Төв, Сэлэнгэ, Завхан аймагт хамгийн их байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 208 дугаар зүйл, Усны тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэг нь заавал ан амьтан, шувуу, загас олноор үхсэн байхыг шаардаж байгаа нь энэ төрлийн хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна.

6. Сүүлийн жилүүдэд нутаг дэвсгэрийн баруун, зүүн, өмнөд хэсэгт хөрсөн дээр ил болон далд байгаа байгалийн өнгөт чулууг иргэд их хэмжээгээр түүж чулуу авдаг ченжүүдээр дамжуулан БНХАУ-д гарган худалдах явдал их хэмжээгээр гарч байгаад судалгаа дүгнэлт хийж Байгалийн өнгөт болон үнэт чулуу түүх, олборлох энэ төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллах №10 дугаартай зааварчилгыг нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэст хүргүүлсэн боловч чулуунд үнэлгээ хэрхэн тогтоох талаар эрх зүйн зохицуулалт байхгүйгээс энэ төрлийн гэмт хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд хүндрэл гарч байна.

7. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилд хураагдсан эд зүйл, эд мөрийн баримтуудыг хадгалах байр сав, харуул хамгаалалт байхгүйгээс хэргийн эд мөрийн байдал алдагдах, солигдох, хэмжээ багасах, муудах зэрэг эрсдэл тогтмол гарч байгаад цагдаагийн байгууллага анхаарал хандуулж асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсон байна.

Шийдвэрлэх арга зам:

1. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамнаас “Байгаль орчинд нарийвчилсан үнэлгээ тогтоох тусгай зөвшөөрөл” авсан аж ахуйн нэгжээр шинжилгээ хийлгэж төсвөөс их хэмжээний төлбөр төлөх үүргээс чөлөөлөх, байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдын зүгээс мөрдөн байцаагч нь ашиг, хувь хүртэх зорилгоор хувийн хэвшлийн аж ахуйн

нэгжийн бизнест дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна гэсэн сөрөг ойлголт, алба хаагчдийн гэмт хэрэг, зөрчилд холбогдох эрсдэлийг арилгах үүднээс Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнд экологи-эдийн засгийн шинжилгээний нэгж байгуулах саналыг Хууль зүйн яаманд хүргүүлэх;

2. Цагдаагийн байгууллагын жил жилийн төсөвт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 99 дүгээр зүйлд заасан байцаан шийтгэх ажиллагааны зардлыг тусгаж байх асуудлыг зохих байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;

3. Аймаг, орон нутгийн удирдлагууд уул уурхайн үйл ажиллагааны улмаас ухагдаж эвдэгдсэн газруудыг нөхөн сэргээх журмыг орон нутгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, сонгон шалгаруулалт зарлах, эвдэгдсэн газрын технологийн үлдэгдлийг дахин олборлож ашиглах замаар нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулж Ашигт малтмалын тухай хууль тогтоомж зөрчиж, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олобрлох гэмт хэргийн шалтгаан болж байгаа талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүргүүлэн хянуулж, хууль бус шийдвэрүүдийг хүчингүй болгуулах асуудлыг тавих;

4. Байгаль орчны хууль тогтоомж, эрх зүйн актуудын зөрүүтэй байдлыг зохих байгууллага албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэх, хуулийн байгууллагууд хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар хамтарсан зөвлөмж шийдвэр гаргуулах;

5. Байгалийн өнгөт болон үнэт чулуунд хэрхэн үнэлгээ тогтоох асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлж шийдвэрлүүлэх;

6. Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төслийн 9.4 дүгээр хэсгийн 3 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн тээврийн хэрэгсэл, уналга, зэвсэг, хэрэгсэл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд” хураана гэж заасан байх тул үүнээс “байсан нь тогтоогдсон тохиолдолд” гэдгийг хасч гэм буруутай этгээдийн “өмчлөлд байгаа эсэхээс үл хамааран” түүнийг хураан авч байхаар өөрчлөх саналыг тус хуулийн ажлын хэсэгт ажиллаж байгаа алба хаагчаар дамжуулан шийдвэрлүүлэх;

7. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчилд хураагдсан эд зүйл, эд мөрийн баримтуудыг хадгалах байр сав, харуул хамгаалалт байхгүйгээс хэргийн эд мөрийн байдал алдагдах, солигдох, хэмжээ багасах, муудах зэрэг эрсдэл тогтмол гарч байгаад онцгой анхаарч энэ асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх;

8. Төв, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг, зөрчил шалгаж шийдвэрлэх талаар прокурорын байгууллагатай хамтран аргачлал боловсруулж хүргүүлэх зэрэг шийдвэрлэх арга зам байна гэж үзлээ.

ХҮНИЙ ЭРХ БА НИЙГМЭЭС ТУСГААРЛАХ АЛБАДЛАГА

“Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”

(Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйл)

“Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй”

(Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйл)

“...Халдашгүй чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно...”

(Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалт)

Хүний эрх бол хүнээс салшгүй, заяамал бөгөөд хүн төрөлхтний үнэт зүйл болох хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хамгаалах, хангах явдал юм.

Эрх зүйн онолын хувьд хүний эрх, эрх чөлөө нь ямарч тохиолдолд хэмжээ хязгааргүй дур зоргыг илэрхийлдэггүй⁴⁷ бөгөөд “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д “Хүн бүр эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг зүйн дагуу зөвшөөрөн хүндлэх, ёс суртахууны шударга шаардлагыг биелүүлэх, ардчилсан нийгэмд байдаг хэв журам, бүх нийтийн сайн сайхан байдлыг хангах, үүднээс хуульчлан тогтоосон зохих хязгаарлалт⁴⁸-нд л захирагдана⁴⁹” гэжээ.

Хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийн баталгаа нь сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих үндэслэл, журамтай шууд холбоотой байдаг. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээ нь хувь хүнийг хууль бусаар, дур мэдэн аливаа хэлбэрээр эрх чөлөөг нь хязгаарлахгүй байх, хуулийн дагуу хязгаарласан тохиолдолд хүний эрхийн аливаа зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах хууль зүйн баталгааг бүрдүүлсэн байхыг шаарддаг. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагаас батлан гаргасан олон улсын гэрээ, нийтээр дагаж мөрдөх зарчим, стандартаар шүүхээс өмнө хэн нэгний эрх чөлөөг хязгаарлах үндэслэл нь бодит нөхцөл байдалд тулгуурласан байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, ирээдүйд бий болж болзошгүй нөхцөл байдлыг төсөөлөн аливаа хүний эрх чөлөөг хязгаарлахгүй байхыг оролцогч улсуудад үүрэг болгосон байдаг.


Үндсэн хууль болон олон улсын гэрээ, конвенцоор хамгаалагдсан хүний халдашгүй байх, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх, чөлөөтэй зорчих, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх зэрэг эрх нь хязгаарлагддаг албадлага нь нийгмээс тусгаарлах албадлага

⁴⁷ Х.Эрдэнэбат. Хүний халдашгүй эрх, УБ.,2002. 37 дахь тал


⁴⁸ Хүний эрхэд хязгаарлалт хийх гэж нийгэм, улс орон, хүний эрх, эрх чөлөө, хууль зүйн дэг журмыг хамгаалах, сахиулахын тулд тодорхой хязгаарлалт хийж болно.

⁴⁹ Хүний эрх, ОУ-ын гэрээ, хэлэлцээрүүдийн эмхтгэл, НҮБ, УБ.,1992, 8 дугаар тал

билээ. Энэхүү албадлагыг хэрэглэж буй өнөөгийн байдал, үндэслэл, журмын талаарх зарим асуудлыг хөндөх нь энэхүү илтгэлийн гол агуулга бөгөөд хөндөх болсон шалтгаанаа дараах тоо баримтаар илэрхийлж байна.



Монгол улсад сүүлийн 5 жилийн байдлаар 127302 гэмт хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд нийт 113320 хүнийг холбогдуулан шалгажээ⁵⁰.



Улсын дээд шүүхийн шүүн таслах ажиллагааны тайлангаас авч үзвэл сүүлийн 5 жилд нийт **3760** сэжигтэнд баривчлах, **21572** сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих, нийт **25332** буюу гэмт хэрэгт сэрдэгдэгсдийн **29 хувь** буюу **4 хүн тутмын нэгд** нь энэ төрлийн албадлага хэрэглэсэн гэсэн баримт байна⁵¹. Энэ тоо нь зөвхөн шүүхийн захирамжаар баривчлагдсан сэжигтний тоо бөгөөд Цагдаагийн байгууллагаас гаргасан мэдээллээс⁵² үзвэл зөвхөн **2014 онд нийт 364 сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчилсан** бөгөөд **хүндэвтэр гэмт хэрэгт 174**, хүнд гэмт хэрэгт 82, онц хүнд гэмт хэрэгт 67 сэжигтнийг тус тус баривчилсан байна. Үүнээс үзвэл мөрдөн байцаагчийн тогтоолоор баривчлагдсан нийт сэжигтний 54 хувийг хүндэвтэр гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүмүүс эзэлж байгаа нь анхаарал татаж байна.


Хүний эрхийн үндэсний комиссын хяналт шалгалтын мэдээ⁵³нд дурьдсанаар “цагдан хорих 461 дүгээр ангид 2015 оны 1 дүгээр сард нийт 413 сэжигтэн, яллагдагчийн 173 нь сэжигтнээр баривчлагдсан байв. Гэтэл тэднийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1. дэх хэсэгт заасан журмын дагуу шүүгчийн захирамжаар баривчилсан тохиолдол огт байхгүй байсан юм” гэжээ.

⁵⁰ ЦЕГ, Мэдээлэл судалгааны төв, Монгол улсад 2009-2014 онд бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа

⁵¹ Монгол улсын шүүхийн 2009-2014 оны шүүн таслах ажиллагааны тайлан мэдээ

⁵² ЦЕГ, Мэдээлэл судалгааны төв, Монгол улсад 2009-2013 онд бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаа


⁵³ <http://www.mn-nhrc.org/>



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайлан мэдээ⁵⁴-нээс үзвэл жилд дунджаар 6600 орчим ялтан хорих ял эдэлж байна⁵⁵.



Бидний тохиолдлоор авч судалсан цагдан хорих тухай 69 захирамжийн 17 нь онц хүнд, 20 нь хүнд, 31 хүндэвтэр, 1 хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайлан мэдээ⁵⁶-нээс үзвэл ял эдлэгсдийн дийлэнх нь хүнд, онц хүнд гэмт хэрэгт ял шийтгэгдсэн болох нь ажиглагдаж байна.

Судалгааны явцад цуглуулсан тоон үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийвэл:

1. Монгол улсад жилд ДУНДЖААР

- 21000 гэмт хэрэг бүртгэгдэж

⁵⁴ ШШГЕГ-ын 2010-2014 оны үйл ажиллагааны тайлан

⁵⁵ Хорих байгууллагад ял эдлэж буй нийт хүмүүсийн албан ёсны тоо нь нууцлалын зэрэгтэй гэх учир тоймчлон авсан болно.

⁵⁶ ШШГЕГ-ын 2009-2013 оны үйл ажиллагааны тайлан

- 19000 хүн холбогдон шалгагдаж
- 5600 хүнд баривчлах, цагдан хорих албадлага хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, практикт эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж буй 4 хүн тутмын 1 нь эрх чөлөөгөө хязгаарлуулж, нийгмээс тусгаарлагддаг байна.

2. Монгол улсад жилд ДУНДЖААР⁵⁷

- 6600 ялтан ял эдэлж,
- 2800 яллагдагч хорих ял шийтгүүлж, түүнийг биеэрээ эдэлж
- 2581 ялтан суллагдаж байна.

3. Монгол улсад жилд ДУНДЖААР

- Ял эдлэгсдийн 17.6 хувь нь хүндэвтэр гэмт хэрэгт ял шийтгэгдсэн байгаа бол нийгмээс тусгаарлах албадлага авагдсан этгээдүүдийн 44.5 хувь нь хүндэвтэр гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байна.

Дүгнэвэл: Эдгээр тоонууд юу илэрхийлж байна вэ? Дүгнэлт хийж үзвэл ял эдэлж байгаа 6600 хүнээс тухайн жилдээ суллагдаж байгаа 2500 ялтныг хасч, үлдэгдэл дээр нь хорих ялаар шийтгүүлж байгаа 2800 хүнийг нэмбэл дараагийн жилд шоронд 6900 ялтантай байх магадлалтай байна. Гэтэл бүртгэгдсэн гэмт хэрэгт шалгагдаж байгаа 19000 хүнээс 5600 хүнд нийгмээс тусгаарлах албадлага хэрэглэсэн байгаа нь эдгээр хүмүүсийн хэд нь хорих ял шийтгэгдэж, хэд нь ХӨТЯ шийтгэгдсэн, хэдийнх нь хэрэг хэрэгсэхгүй болсон бэ? гэдэг нь бидний анхаарлыг зүй ёсоор татаж байна. Тэгэхээр бид үүнд нарийн задлан шинжилгээ хийх шаардлагатай.

Асуудал юунд байна вэ?

1. Монгол улсын ЭБШ хуулийн 58-р зүйлийн 58.1-т зааснаар сэжигтнийг “...хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт **сэрдэгдэх** хангалттай баримт байгаа ... бол” баривчилж нийгмээс 72 цаг хүртэл хугацаагаар тусгаарлахаар хуульчилсан байна. Ийнхүү хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдсэн хүн бүрийг баривчлахыг үүрэг болгосон заалт нь үйлдсэн хэргийн нөхцөл байдал, хүний хувийн байдал зэргийг харгалзан баривчлахгүй байх хувилбарыг үгүйсгэж, үүний улмаас хүний эрх зөрчигдөх, төрийн албан тушаалтны зүгээс эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, энэ явдал нь сэжигтний хувьд ЭБШ ажиллагаа хэвийн явагдах нөхцөлд саад учруулах ямар нэгэн санаа сэдэлт бий болоогүй үед ч албадлага хэрэглэх боломжийг эрх бүхий албан тушаалтнуудад олгож байна.

Дээр дурдсан үндэслэл нь зөвхөн сэжигтнээр тооцох үндэслэл болох байтал түүнийг баривчлах эрх олгосон хуулийн зохицуулалт нь ЭБШ ажиллагааны явцад хүний халдашгүй байх эрхийг хангах, гэм буруугүйд тооцох зарчмын агуулгатай зөрчилдөж, сэжигтэнд өөрийнхөө эсрэг мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэн, хүч хэрэглэж байгаа эрүүдэн шүүх нэг хэлбэр⁵⁸ болж байна.

Мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5-д “хойшлуулшгүй тохиолдол”-д хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтнийг шууд баривчилж 24 цагийн дотор тогтоолыг прокурор шүүхэд хүргүүлнэ” гэсэн заалтаас сэжигтнийг баривчлах албадлагын арга хэмжээг прокурорт танилцуулалгүй, шүүгчийн захирамжгүйгээр баривчлах байранд хүргэх ажиллагааг хуульчилжээ. Энэ талаар Улсын дээд шүүхийн 2004 оны 7 тоот тогтоол

⁵⁷ 2009 онд 3074, 2010 онд 2543, 2011 онд 2781, 2012 онд 2940, 2013 онд 2522, 2014 онд 2441 хүн хорих ялыг биечлэн эдлэхээр шийтгэгджээ. УДШ-ийн 2009-2013 оны шүүн таслах ажиллагааны тайлан мэдээ

⁵⁸ Д.Зүмбэрэлхам, Монгол улсын ЭБШ эрх зүй дэх гэм буруугүйн презумпци, УБ.,2005. 99 дэх тал

гарч тайлбарласан ч энэ нь сэжигтнийг баривчлах бус сэжигтнээр тооцох үндэслэл болсон байна. Түүнчлэн өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох чадваргүй болтлоо мансуурсан, согтуурсан сэжигтнийг эрүүлжүүлэх арга хэмжээг тайлбарласан нь сэжигтний эрх зүйн байдлыг дордуулан улмаар сэжигтнээр тооцох үндэслэл байгаа тохиолдолд гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр шүүгчийн захирамжгүйгээр шууд баривчлан эрх чөлөөг нь хязгаарлах нөхцлийг бүрдүүлсэн байна.

Санал 1: Шинээр боловсруулж буй Эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд сэжигтнийг баривчлах албадлагыг хасах. Ингэснээр сэжигтнийг баривчлах ажиллагааг тухайн этгээд гэмт хэрэг үйлдсэн болох нь нотлох баримтаар тогтоогдож, түүнийг мөрдөх ажиллагаа явуулж буй байгууллагад хүргэх агуулгаар нь томъёолох.

2. ЭБШ хуулийн 68 дугаар зүйлд зааснаас үзвэл гэмт хэргийн ангилал харгалзахгүйгээр цагдан хорих албадлага хэрэглэх зохицуулалт тусгагдсан нь практикт хүндэвтэр гэмт хэрэгт цагдан хорих албадлагыг ихээр хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзэж байна.

Жишээ нь: Хүний эрхийн үндэсний комиссоос 2011 онд хөдөө, орон нутгийн баривчлах, цагдан хорих байранд хийсэн шалгалтын тайлан мэдээнд “Аймгуудын Цагдан хорих байранд цагдан хоригдож буй сэжигтэн, яллагдагчийн 70 орчим хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт заасан бусдын эд хөрөнгийг хулгайлах гэмт хэрэгт холбогдсон хүмүүс байгаа нь ихээхэн анхаарал татлаа. Уг гэмт хэрэг нь хүндэвтэр гэмт хэрэгт хамаарах тул тийм гэмт хэрэгт холбогдсон хүмүүст аль болох цагдан хорихоос өөр төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авч байх боломжтой боловч хууль тогтоогчоос хорьж болох үндэслэлийг нээлттэй байдлаар ерөнхий тодорхойлсноос болж хүндэвтэр гэмт хэрэгт холбогдсон хүмүүс ихээр хоригдох байдал харагдаж байна. Нөхцөл байдлыг газар дээр нь танилцаж явах үеэр **прокуроруудаас** тодруулахад “Наад хүн чинь урьд нь гэмт хэрэг үйлдэж байсан, оргочих гээд байдаг юм, гаргахаар хулгай хийчихээд байдаг юм” гэсэн тайлбарыг өгч байна гэжээ⁵⁹.

Хууль тогтоогчоос хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн тухайд өмнө авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн үндэслэл байвал цагдан хорихоор заасан. Гэтэл өмнө авсан ТСАХ-г зөрчсөн болон оргон зайлж болзошгүй гэдэгт чухам ямар үйлдлийг хамааруулах нь ойлгомжгүй мөрдөн байцаагч, прокурор, шүүхээс хэтэрхий субъектив үнэлэмжээр хандах бололцоог олгосон байна гэж үзэж байна.

Жишээ нь: Бидэнд байгаа хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагчид цагдан хорих албадлага хэрэглэх тухай шүүгчийн 17 захирамжаас үзвэл “... хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн, мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй үндэслэлтэй байх тул сэжигтнээр цагдан хорьсугай” гэжээ.

Гэтэл эдгээр шүүгчийн захирамжийн алинд нь ч “мөрдөн байцаалтаас оргон зайлж болзошгүй үйлдэл гаргасан, түүнийг нь нотлох баримтаар тогтоосон талаар ямар нэгэн үг, өгүүлбэр тусгагдаагүй байна. ЭБШ ажиллагааны явцад үйлдэгдэж байгаа шийдвэрийг

⁵⁹ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх удаагийн тайлан, УБ.,2012.

тусгасан бичиг баримт⁶⁰-ын тодорхойлох хэсэгт ямар шийдвэр гаргах гэж байгаа талаар болон тухайн шийдвэрийг гаргахад нөлөөлж буй нотлох баримтын эх сурвалжийг заавал дурьдсан байхыг шаарддаг хууль зүйн шаардлага хангагдаагүй байгаагаас үзвэл практикт мөрдөн байцаагч, прокурор, шүүгч субъектив үнэлэмжээр цагдан хорих албадлага хэрэглэдэг байж болох нь ажиглагдаж байна.

Санал 2: ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт заасан хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг зөвхөн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин гэмт хэрэг үйлдсэн” үндэслэлээр цагдан хорих албадлага хэрэглэхээр зохицуулалт хийх. Цаашилаад Эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд аль болох хүндэвтэр гэмт хэрэгт цагдан хорих албадлага хэрэглэхгүй байх бодлого барих нь зүйтэй байна.

3. ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.9 дэх хэсэгт “хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу хүнд өвчтэй этгээд, жирэмсэн эмэгтэй, хөхүүл хүүхэдтэй эмэгтэйн хувьд энэ хуулийн 68.2-г заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэхийг хориглоно” гэж заасан. Гэтэл Нэгдсэн Үндэстний Байгууллагын олон баримт бичигт, тухайлбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Токиогийн дүрэмд тодорхой хэргийг мөрдөх хийгээд нийгэм, хохирогчийг хамгаалах зорилгоор шүүхийн өмнөх шатанд хорьж саатуулах явдлыг ЭБШ ажиллагааны онцгой арга хэмжээ болгон хүнд хэлбэрийн эрүүгийн хэрэгт хэрэглэх ёстой гэдгийг онцгойлон заасан байна⁶¹. Гэтэл манай улс нэгдэн орсон гэрээ, конвенциор хүлээсэн үүргээ үл биелүүлэн өнөөг хүртэл хөнгөн гэмт хэрэгт цагдан хорих албадлага хэрэглэх зохицуулалттай явж байгаа нь зүйд нийцэхгүй байна.

Санал 3: ЭБШ хуулийн 68 дугаар зүйлийн 68.9 дэх хэсгээс “хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн буюу” гэх хэсгийг хасч, хүнд өвчтэй этгээд, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй, жирэмсэн эмэгтэйн тухайд хөнгөн гэмт хэргээс бусад ангиллын хэрэгт цагдан хорьж болохоор өөрчлөх, ингэхдээ санал 2-т дурдсан агуулгыг харгалзах

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 58 дугаар зүйлд зааснаар сэжигтнийг оргон зугтахыг завдсан, эсхүл хүнд, онц хүнд гэмт хэрэгт сэрдэгдсэн бол баривчилж болохоор хуульчилсан байна. Оргон зугтахыг завдсан гэдэг нь субъектив байдлаар тодорхойлогдох үндэслэл бөгөөд үүнийг практикт тодорхой нотолгоогоор бус харин тогтоолд дурдах төдий байдлаар хүнийг баривчилдаг. Мөн хүнд, онц хүнд гэмт хэргийн сэжигтнийг шууд баривчилж болохоор хуульчилсан нь хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх зөрчигдөх шалтгаан болж байна. Улсын дээд шүүхийн 2004 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 7 дугаар тогтоолоор сэжигтэн оргон зугтахыг завдсан гэдгийг тайлбарлахдаа “Сэжигтнээр тооцогдсон этгээд Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанаас зайлсхийх зорилгоор зориуд санаатай байнгын оршин суугаа газраа орхих, овог нэрээ өөрчлөх, гадаад улсад болон өөр орон нутагт явахаар виз, зорчигчийн тасалбар авч бэлэн болсон, анх саатуулагдах үед өөрийн биеийн байцаалтад холбогдох мэдээллийг зориуд буруу ташаа танилцуулан зугтах, нуугдахыг оролдсон идэвхтэй үйлдэл хийсэн зэрэг байдлыг ойлгож болно” гэж тайлбарласан байдаг. Гэтэл практикт мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар дээр дурдсан үндэслэлүүдийг нотлосон хангалттай нотлох баримтгүйгээр сэжигтнийг баривчилж байна.

⁶⁰ Шийдвэрийг тусгасан бичиг баримтанд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж хамаардаг.

⁶¹ Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 11 дэх удаагийн тайлан, УБ.,2012.

Санал 4: Шүүхээс нийгмээс тусгаарлах албадлагын арга хэмжээг авах, сунгах хүсэлтийг шийдвэрлэхдээ прокурор, өмгөөлөгчийн тайлбар, хүсэлтийг сонсох, мэтгэлцэх нөхцөлөөр хангах, холбогдох нотлох баримтыг шинжлэн судлах, хууль ёсны нотлох баримтын хүрээнд хуульд заасан үндэслэлээр шийдвэр гаргах ингэхдээ ямар нотлох баримтын эх сурвалжаар энэ төрлийн албадлага хэрэглэж байгааг заавал дурьдах

Я.Цэлмэн

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх ажиллагааны
онол, тактикийн тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

ГЭМТ ХЭРЭГ МӨРДӨХ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Монгол Улсын тухайд гэмт хэрэг мөрдөх нь хуучин ЗСБНХУ-ын арга тактик, номлолоор явагдаж ирсэн бөгөөд одоо ч ул мөр нь арилаагүй байна. Дэлхий нийтийн гэмт хэрэгт мөрдөх, түүнтэй тэмцэх чиг хандлага улам шинжлэх ухаанч болж байгаа нь хөгжилтэй улс орнуудын жишээ нь дээр харагдана. Судалгаанаас үзэхэд, Монгол Улсад гэмт хэрэг илрүүлэх үндсэн арга нь байцаалт байгаа нь олон судалгаанаас тодорхой харагдах болсон. Өндөр хөгжсөн улс, орнуудад хүний эрхийн баримжаатай мөрдлөг явуулахыг шаардаж хууль тогтоомж, эрх зүйн тогтолцоондоо суулгаж байгаа нь нэлээдгүй үр дүнд хүрсээр байна. Бид энэхүү илтгэлдээ Бүгд Найрамдах Солонгос Улсын гэмт хэрэг мөрдөх үйл ажиллагаандаа нэвтрүүлж, багагүй үр дүнд хүрч буй зарим чиг хандлага, үйл ажиллагаанаас жишээ авсан болно. Гэмт хэрэг мөрдөх талаар бид хүний хүчинд суурилсан чиг хандлагаа өөрчилж шинжлэх ухаан, техникийн дэвшлийг нэвтрүүлж, хэрэглэж хэвших шаардлагатай байна. Бидэнд мөрдөх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шинэ арга, технологиуд хэрэгтэй.

Дараах асуудлуудын хүрээнд авч үзэх болно. Үүнд:

1. Хэргийн газрын үзлэг.
2. ДНК /DNA/ гэмт хэрэг илрүүлэх, мөрдөхөд ашиглах
3. Дижитал шинжилгээ, мөрдөн шалгах ажиллагаа

1. Хэргийн газрын үзлэг

Манай мөрдөн байцаалтын ажиллагаанд хэргийн газрын үзлэгийг мөрдөн байцаагч удирдан явуулах хууль, эрх зүйн зохицуулалтай боловч үнэндээ өөрөө цаг хугацаагаа ихээр зарцуулан хэргийн газрын үзлэгийг тоочин бичих аргаар явуулж байгаа нь нэгэнт үр дүнгүй болсоор байна. Бид хэргийн газрын үзлэг гэдгийг мөрдөн байцаагчийн хийх ёстой тоочин бичих ажил гэж эндүү ташаа ойлгон ирсэнд асуудал нь байгаа юм. Орчин үед хэргийн газрын үзлэг нь цэвэр мэргэжлийн шинжээч нарын ажлын талбар болсон бөгөөд мөрдөгчийн үүрэг нь хэргийн газрын үзлэгийг тоочин бичих аргаар хийх биш, нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх биш, харин хэргийн газрын нөхцөл байдалтай биечлэн танилцаж, гэмт хэрэг хэрхэн үйлдэгдсэн байж болох төсөөлөлтэй болж, үүн дээрээ үндэслэн мөрдөн байцаалтын дараагийн шатны ажиллагааг хэрхэн явуулах вэ гэдгийг зохион байгуулах үйл ажиллагаа юм. Тэгвэл хэргийн газар хэн ажиллах ёстой вэ гэсэн асуулт урган гарч байгаа нь ойлгомжтой. Хариулт нь: хэргийн газар тал бүрийн мэргэжлийн шинжээчдийн баг ажиллах ёстой юм. Хэргийн газар нь гэмт хэрэгтний ул мөр үлдсэн байж болох хамгийн өндөр магадлалтай орчин юм. Гар хурууны хээ, хөлийн мөр,

биологийн мөр зэргээс гадна хүний нүдэнд харагдахгүй бичил мөрүүд хүртэл үлдсэн байдаг тул үүнийг илрүүлэх, цуглуулах, бэхжүүлэх, шалгах ажиллагаа бол цэвэр шинжээч нарын ажил юм.

Шинжээчдийн баг нь дараах төрөлтэй байж болно:

1. Хэргийн газрын үзлэг хийх баг;
2. Хэргийн газрыг нөхөн сэргээх баг;
3. Туршилт хийх баг;
4. Илэрсэн мөр бүр дээр ажиллах, шинжилгээ хийх мэргэжлийн шинжээч нар

Манай мөрдөн байцаалтын практикт хэргийн газарт криминалистикийн шинжээч л ажиллаж байгаа нь туйлын учир дутагдалтай. Тэд ил харагдах мөр дээр ажиллах бөгөөд, хэргийн газрын зураг авахаар үйл ажиллагаа, техник технологийн боломж нь хязгаарлагддаг. Энэ нь гэмт хэрэгтний маш олон бусад төрлийн мөрийг алдахад хүргэдэг. Хүний амь нас хохирсон хэрэгт криминалистикийн шинжээчээс гадна шинжээч эмч оролцож байна. Энэ хоёр хүнээр шинжээчдийн баг хязгаарлагдаж байна.

Тэгвэл БНСУ-д гэмт хэргийн газрын үзлэг хийж байгаа шинжээчдийн баг нь дүрс бичлэгийн шинжээч, бичиг баримтын шинжээч, ДНК шинжээч, шүүх эмнэлгийн шинжээч, сэтгэл зүйн шинжээч, дижитал нотлох баримтын шинжээч, биологийн, химийн, физикийн шинжээч гэх мэт бүрэлдэхүүнтэй ажиллаж байх бөгөөд хэрвээ хэргийн газрыг зориудаар балласан, нотлох баримтыг устгасан бол хэргийн газрыг нөхөн сэргээх шинжээчдийн баг эхэлж ажилладаг байна.

2. ДНК шинжилгээ

Манай улсын хувьд “Генетикийн мэдээллийн” буюу ДНК шинжилгээ нь харьцангуй шинэ төрлийн шинжилгээ. Бидэнд ДНК мэдээллийн сан байгуулах эрх зүйн орчин өнөөдөр дутмаг байгаа нь энэ төрлийн шинжилгээгээр гэмт хэргийг илрүүлэх мөрдөхөд саад болж байна.

Шүүхийн шинжилгээний практикт дэлхийн улс орнуудын ашиглаж байгаа “Генетикийн мэдээллийн сан” /ДНХ мэдээллийн сан ч гэдэг/ гэдэг нь хүний эс дэх 23 хос хромсом дээр байрладаг 13-15 локусын аллелийг бүрдүүлэгч нуклеотидийн дарааллыг тогтоосон үр дүнг хэлдэг. Хувь хүнийг ДНХ-ийн шинжилгээгээр адилтган харьцуулах шинжлэх ухааны энэ ололт амжилт, арга технологийг АНУ, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улс, ХБНГУ, Франц, Канад болон өндөр хөгжилтэй ихэнх улс шүүхийн шинжилгээний практикт гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаад 15 гаруй жил болж байна.⁶²

Хүний бие 60 орчим их наяд эсээс бүрддэг бөгөөд бүх эсэд ДНК агуулагддаг ба бүгд ижил байдаг. ДНК нь нүдэнд харагдахгүй хэдий ч хэргийн газар ихэвчлэн үлддэг онцлогтой. Нэг эсийн хоёр ихэрээс бусад хүний ДНК өөр байдаг.

ДНК шинжилгээ нь дараах үе шаттай:

1. Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хэргийн газраас ДНК илрүүлэх,
2. 2 дахь шатны ДНК тогтоох шинжилгээ.

ДНК шинжилгээг хийхэд: а. ДНК илрүүлэх, б. ДНК дээжийг ялгаж авах, в. PCR⁶³ ашиглан томруулах, г. ДНК мэдээллийг шинжлэх гэсэн дарааллаар явагддаг. Эцэст нь шинжилгээний нэр болон генетикийн үзүүлэлтийг тоогоор илэрхийлнэ.

ДНК шинжилгээ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

⁶² Улсын их хурлын тамгын газрын судалгаа, шинжилгээний хэлтэс. Шүүхийн шинжилгээний практикт “генийн мэдээллийн санг” ашиглаж гэмт хэргийг илрүүлж буй гадаадын зарим улс орны туршлага, эрх зүйн орчин (харьцуулсан судалгаа), 2013, уб

⁶³ Pcr-polymerase chain reaction гэсэн үг. Полимеразын гинжин урвал гэсэн утгатай бөгөөд днк-ийн жижиг хэсгийг судалгааны материал дотроос илрүүлэх техник.

- ДНК мэдээллийн санг бүрдүүлэх;
- Илрээгүй гэмт хэрэгтнийг илрүүлэх. /Жишээ: БНСУ-ын ДНК шинжээч нь онц хүнд хүн амины гэмт хэргийг сэжигтэн этгээдийн идээд хаясан жимсний хальснаас илрүүлсэн ДНК шинжлэн илрүүлсэн байна. Үүнээс энэ төрлийн шинжилгээ нь гэмт хэргийг илрүүлэхэд ихээхэн түлхэц өгнө гэдэг нь харагдана./
- Цуврал аллагыг илрүүлэх;
- Томоохон ослоос хохирогч нарыг тогтоох;
- Төрөл төрөгсдийг тогтоох;
- Зам тээврийн гэмт хэрэг мөрдөх.

БНСУ-д ДНК мэдээллийн санг ашиглан гэмт хэргийн үзүүлэлтийг 2010.7.26-2015.3 хүртэлх хугацаанд авч үзвэл⁶⁴:

- Хулгайлах 1003
- Хүчиндэх 248
- Дээрэмдэх, танхайрах 53
- Хүнийг санаатай алах 5
- Бусад 203

Энэ үзүүлэлт нь Монгол шиг цөөхөн хүн амтай улсад бол ДНК шинжилгээг хийх, ДНК мэдээллийн сантай болох нь гэмт хэргийн илрүүлэлтийг даруй олон хувь өсгөх боломжтойг харуулж байна.

Дэлхий дээр өнөөдрийн байдлаар 50 гаруй улсад 5 сая орчим гэмт хэрэгтний ДНК мэдээллийн санд төвлөрүүлсэн байна⁶⁵.

3. Дижитал шинжилгээ, мөрдөн шалгах ажиллагаа

Шинжлэх ухаан хөгжихийн хэрээр гэмт хэрэгтэй тэмцэх арга, технологи ч хөгжиж байна. Үүний нэг нь дижитал шүүхийн шинжилгээ, дижитал мөрдөх ажиллагаа юм. Орчин цагт дижитал төхөөрөмж, технологийг ашигладаггүй хүн бараг үгүй болсон байна. Дижитал тоног төхөөрөмжинд хувийн суурин цахим тооцоолуураас гадна, зөөврийн нөүтбүүк, гар утас, зөөврийн хатуу диск, флаш зэрэг бүх төрлийн мэдээлэл агуулагч орчин үеийн техник технологиуд ордог.

БНСУ-д дижитал шинжилгээний хэлтэс нь 2015 онд байгуулагдсан бөгөөд 1995 оноос суурь нь тавигдсан байна.

Дижитал шинжилгээ гэдэг нь компьютер болон бусад төрлийн дижитал тоног төхөөрөмжөөс өндөр технологийн тусламжтайгаар дижитал мэдээллийг цуглуулан шинжилгээ хийснээр эд мөрийн баримт олдог бүх төрлийн ажиллагааг хэлдэг⁶⁶.

Дижитал эд мөрийн баримт нь дараах онцлогтой. Үүнд:

1. Нууц, далд байдалтай оршдог;
2. Их хэмжээтэй;
3. Өөрчлөгдөж хувирах сул талтай;
4. Сүлжээний орчинд ажиллаж болох тул байр зүйн бэрхшээлгүй.

⁶⁴ Joo, Mhen-Chel, Prosecutor, Korean Institute of Justice /Capacity Building For Managerial Level Officers of Law Enforcement University, Mongolia/

⁶⁵ Lee, Seung hwang, Chief of DNA analysis lab, DNA forensic div, Korean Institute of Justice /Capacity Building For Managerial Level Officers of Law Enforcement University, Mongolia/

⁶⁶ Ян, Сог Жу, БНСУ-ын ПЕГ-ын дижитал мөрдөн шалгах хэлтсийн дарга, “Дижитал мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн байдал ба алсын хараа” Korean Institute of Justice /Capacity Building For Managerial Level Officers of Law Enforcement University, Mongolia/

Дижитал шинжилгээ, мөрдөн шалгах ажиллагаа нь БНСУ-д 2010-2014 оныг хүртэлх хугацаанд нийт мөрдөн шалгах ажиллагааны 34 хувийг эзлэх хүртэл өссөн байна. Мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлж дижитал нотлох баримтыг шилжүүлэх цагдаа, прокурор зэргийг холбосон “DFIS” системийг нэвтрүүлсэн бөгөөд дижитал эд мөрийн баримтад цогц дүн шинжилгээ хийх “DFAS v2.0” системийг ашиглаж байна.

Эд мөрийн баримтын өргөтгөлөөс нь хамааран дараах шинжилгээг хийж байна.

- Файл;
- И-мэйл;
- Цахим шийдвэр;
- Санхүү, дансны бүртгэл;
- Мобайл-ярианы жагсаалт гэх мэт.

Дижитал шинжилгээ нь эд мөрийн баримтыг илрүүлэх, хураах, хадгалах, мэдээллийг шинжлэх, сэргээх, дүн шинжилгээ хийх гэсэн үндсэн үүрэгтэй. Үүнээс онцолвол ярианы шинжилгээ хийгч, дансны шинжилгээ хийгч програм хангамжууд нь гэмт хэргийн бүлгийг болон түүний зохион байгуулагчийг олж тогтоох, сүлжээний болон бусад дансны аргаар үйлдэгддэг банк, санхүүгийн болон, аж ахуйн нэгж байгууллагын татвараас зугтах хэргүүдийг илрүүлэхэд өндөр үр нөлөөтэй ажилладаг байна.

Энэ нь манай улсад ашиглахад өндөр үр дүнтэй шинжилгээ байх бөгөөд улс орон дамнасан гэмт хэргийг илрүүлэхэд мөн үр нөлөөтэй гэж хэлж болно.

Дүгнэлт

Дэлхий нийтээр гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, нотлох үйл ажиллагаанд хүний эрхийн чиг баримжаатай, орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн ололтыг түлхүү нэвтрүүлж ашиглах чиг хандлагатай болсоор байна. Монгол Улсын тухайд нийгэм, эдийн засгийн байдлаас шалтгаалж жил ирэх тутам гэмт хэргийн тоо өсөж, түүний илрүүлэлт улам буурсаар л байна. Бид олон жил эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд гэмт хэрэгтэнтэй тэмцэж ирсэн боловч энэ нь хүний хүчинд суурилсаар ирснийг үгүйсгэх аргагүй юм. Одоогийн хууль, эрх зүйн орчин ч цаг үеэсээ хоцроод байгааг олон судлаач нар дуу нэгтэй хэлцгээх болсон цаг үед бид ирээд байна. Өндөр хөгжилтэй улс орнуудын тэргүүн туршлагаас шууд нэврүүлэх боломж бидэнд байгаа ч улс орны эдийн засгийн байдлаас шалтгаалж бидэнд хөрөнгө мөнгөний хүндрэл үргэлж учирч байгааг ч нуух аргагүй. Гэхдээ хийх хүн арга олдог гэдэг шиг бид дотоод зохион байгуулалтаа өөрчилж, ойрын сайн хөршүүдийнхээ тэргүүн туршлагаас тэдний тусламжтайгаар нэвтрүүлж хэрэгжүүлэх боломж бидэнд байна.

Санал

1. Хэргийн газрын үзлэгийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд шинжилгээний багийг хэргийн газарт ажиллуулдаг болох;
2. Мөрдөгч, шинжээч нараа мэргэшүүлэн сургах;
3. ДНК шинжилгээг явуулах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, шинжээч нарыг техник технологиор хангах;
4. Мөрдөх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх дижитал шинжилгээний хэлтсийг байгуулах;
5. Мөрдөх ажиллагаанд орчин үеийн шинжлэх ухаан, техник технологийн ололтыг түлхүү ашиглах ажлыг гүнзгийрүүлэх;
6. Мөрдөх чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын ачааллыг зөв тооцоолох.

ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ЧИГ ХАНДЛАГА

Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх явцад хуульд заасан үндэслэл байвал бусдын хүсэл зоригийг үл харгалзан тэдний зан үйлд гаднаас шууд нөлөөлөх ажиллагааг албадлага гэнэ. Албадлагын арга хэмжээний нэгэн төрөл нь таслан сэргийлэх арга хэмжээ бөгөөд уг арга хэмжээг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үе шатанд авч болдог.

Таслан сэргийлэх арга хэмжээ нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, эрүүгийн хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг үйлдэж болзошгүй зэрэг байдлуудыг гаргуулахгүй байх, мөн байцаан шийтгэх ажиллагаа хэвийн, түргэн шуурхай явагдах нөхцөлийн хангах зорилгоор дээрх оролцогч нарын үйл хөдлөл, үйл ажиллагааг хянах, зарим эрхийг хязгаарлах замаар эрх бүхий албан тушаалтнуудаас авч буй эрүүгийн процессын албадлагын арга хэмжээ юм.

Таслан сэргийлэх арга хэмжээ Эрүүгийн процессын хуулийн түүхэн хөгжлийн явцад гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нарын жам ёсны эрх, эрх чөлөөг хүндэтгэх, байцаан шийтгэх ажиллагаа хэвийн явагдах нөхцөл бололцоог хангах үүргээ зохих түвшинд биелүүлж ирсэн ба таслан сэргийлэх арга хэмжээний төрөл, агуулга түүхэн он цагт баяжигдан боловсронгуй болж, зарим арга хэмжээнүүд нийгмийн өөрчлөлттэй холбоотойгоор ач холбогдол, нөлөөллөө алдсанаас тухайн заалтыг хасаж өөрчилж иржээ.

2012 оноос одоогийн явагдаж байгаа эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр эрчимтэй хэрэгжиж эхэлсэн.

Энэхүү эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн хүрээнд Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийг өөрчлөхөөр Эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл энэ цаг мөчид УИХ-д өргөн баригдаад байна.

Энэ цаг үед эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилтыг хангах нэгэн чухал хэрэгсэл болох таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж буй нөхцөл байдал, цаашдын чиг хандлагыг судалж тодорхойлохыг зорилоо.

Таслан сэргийлэх арга хэмжээний нэг онцлог нь хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд төрийн албадлага хэрэглэн эрх бүхий албан тушаалтнаас сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хүсэл зоригийг үл харгалзан тэдний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, зан үйлд шууд нөлөөлдөг онцгой арга хэмжээ.

Мөн нөгөөтэйгүүр таслан сэргийлэх арга хэмжээ үр нөлөөгөө алдсан тохиолдолд байцаан шийтгэх ажиллагааны зорилт хэрэгжихэд хүндрэл учирч гэмт хэргийн улмаас хохирсон иргэний хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх боломж багасч Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах үүргээ биелүүлэх боломжгүй болох аюултай.

2002 онд УИХ-аас баталсан Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль одоо хүчин төгөлдөр үйлчилж байна.

Энэ хуульд оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө барьцаалах, цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх, цагдан хорих зэрэг 5 төрлийн таслан сэргийлэх

арга хэмжээнээс сонгон авч хэрэглэж болохоор хуульчилсан. Эдгээр таслан сэргийлэх арга хэмжээг практик байгууллагад хэрхэн хэрэглэж байгаа байдлыг тодруулах үүднээс нийслэлийн 6 дүүргийн нийт 30 хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нараас судалгаа авахад өөрийн шалгаж байгаа хэргийн нийт сэжигтэн, яллагдагчийн 72%-д батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээ, 9%-д цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, 10%-д оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах, 6%-д хөрөнгө барьцаалах, 3% цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авдаг гэж хариулсан байна.



Дээрхи судалгаанд оролцогч нараас хэрэг бүртгэгч нар батлан даалтанд өгөх, оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа хувь өндөр байгаа бол, олон жил ажилласан мөрдөн байцаагч нар цагдан хорих, батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээг голчлон хэрэглэдэг гэсэн судалгаа харагдаж байгаа нь мөрдөн байцаалт явуулж байгаа хэргийн ангилал, сэжигтэн яллагдагч нарын хувийн байдал, хэргийн ээдрээ төвөгтэй байдал зэрэгтэй холбоотой гэж дүгнэж болохоор байна.

Дээрх судалгааг нэгтгэн дүгнэвэл, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, ажилласан туршлага бага, их хэн ч бай батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээг өргөн хэрэглэж байгаа нь энэ арга хэмжээний хэрэгцээ шаардлага, үр нөлөө ямар хэмжээнд байгааг харуулж байна.

Батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээ гэж оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг, хөрөнгийн эх үүсвэртэй, батлан даагчийн үүргийг бүрэн хүлээх чадвартай, насанд хүрсэн иргэнээс сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг төлөв томоотой байлгах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн дуудсан цагт ирүүлж байхыг хариуцаж, бичгээр үүрэг авахыг хэлнэ.

Батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээ нь бусад таслан сэргийлэх арга хэмжээнээс нэг онцлог нь түүнийг хэрэглэх явцад хүний эрх, эрх чөлөөг ноцтой хязгаарлах шаардлага байдаггүйд оршино. Батлан даагч нь 2-оос доошгүй байх ба даалгуулагч этгээд оргон зайлбал эрэн сурвалжлах бүх зардлыг хариуцаж, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасны дагуу торгууль оногдуулна. Энэ тохиолдолд батлан даагч нь бусдын өмнөөс хариуцлага хүлээх ба үүнийг Эрүүгийн хуулийн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх зарчимд нийцэхгүй байна гэх үзэл баримтлал байдаг. Гэвч батлан даагч нь өөрсдийн хүсэлтээрээ, сайн дурын үндсэн дээр батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээг зөрчихгүй гэж итгэж найдсан хүнээ батлан даалтанд авч хэрэв оргон зайлвал түүнээс гарах үр дагаврыг хариуцахаа илэрхийлсэн эрх зүйн бүрэн чадамжтай хүн байдаг онцлогтой.

Одоо УИХ-д өргөн барьж байгаа Эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд хувийн баталгаа гаргах, барьцаа авах, баримт бичгийг хураан авах,

тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, зорчих эрхийг хязгаарлах, цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх, цагдан хорих зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэглэхээр заасан байна.

Яллагдагч нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, эрүүгийн хэргийг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах үндэслэл бүхий сэжиг байгаа бол мөрдөгч хувийн баталгаа гаргах, прокурор барьцаа авах, хувийн баталгаа гаргах, шүүгч мөрдөн байцаалтын явцад барьцаа авах, баримт бичгийг хураан авах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, зорчих эрхийг хязгаарлах, цэргийн албан хаагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх, цагдан хорих, мөн шүүх эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх бүх таслан сэргийлэх арга хэмжээ авч болохоор тусгажээ.

Байнга оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг яллагдагч нь шүүх, прокурорын дуудсан цагт хүрэлцэн ирэх, дахин гэмт хэрэг үйлдэхгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх талаар хувийн баталгааг шүүх, прокурор, мөрдөгчид бичгээр гаргах ба шүүгч, прокурор, мөрдөгч нь тухайн яллагдагчийн үйлдсэн гэмт хэргийн шинж, хувийн байдлыг харгалзан хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээг авах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

Хувийн баталгаа гаргасан яллагдагч байнга оршин суугаа хаяг, холбоо барих утасны дугаар, шуудангийн хаяг өөрчлөгдсөн, эсхүл өөрчлөгдөх гэж байгаа талаар шүүх, прокурорт даруй мэдэгдэх, шүүх прокурорын дуудсан цагт хүрэлцэн ирэх зэрэг үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаанаар ирэх боломжгүй тохиолдолд энэ тухайгаа урьдчилан мэдэгдэнэ.

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан гэх үндэслэл байгаа боловч цагдан хорих шаардлагагүй гэж үзвэл яллагдагчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

Барьцааг яллагдагч өөрөө, эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд гаргаж болно. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд барьцаа гаргахыг хориглоно. Энэ таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагчид шүүх, прокурорын дуудсан цагт ирэх, эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх үүргийг хүлээлгэнэ.

Шүүх баримт бичгийг хураан авах таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа яллагдагчийн гадаад паспорт, жолооны үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгээс хураан авах баримт бичгийг тодорхой заасан шийдвэр гаргаж яллагдагчид гардуулна.

Хэрэв яллагдагч хураалгасан баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай болсон бол шүүх, прокурорт хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Яллагдагчаар татаж эрүүгийн хэрэг үүсгэх тогтоолыг хүчингүй болгосон, хэрэг хянан шалгах ажиллагаа дуусгавар болсон тохиолдолд шүүх баримт бичиг хураан авах таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, хураан авсан баримт бичгийг яллагдагчид буцаан олгоно.

Шүүх төрийн албанд ажиллах, тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс эсхүл тусгай зөвшөөрлөөр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, албан үүргээ биелүүлэхийг тодорхой хугацаагаар түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээ авч болно. Энэ тохиолдолд прокурор, мөрдөгч яллагдагч болон түүний ажилладаг албан байгууллага, хуулийн этгээдэд энэ шийдвэрийг даруй хүргүүлнэ. Энэ шийдвэрийг хүлээн авсан албан байгууллага, хуулийн этгээд заавал биелүүлж 3 хоногийн дотор энэ талаараа хариу мэдэгдэнэ. Мөн хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг нь хязгаарлаж болно.

Яллагдагчийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гарахыг шүүхийн шийдвэрээр тодорхой хугацаагаар хязгаарлаж зорчих эрхийг хязгаарлах таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

Энэ таслан сэргийлэх арга хэмжээ авсан, хүчингүй болгосон тухай шүүхийн шийдвэрийг прокурор, мөрдөгч холбогдох байгууллагад даруй мэдэгдэнэ.

Шүүх, цэргийн алба хааж байгаа яллагдагчийг цэргийн ангийн удирдлагад хянан харгалзуулахаар өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа яллагдагчийг төлөв томоотой байлгах, прокурор, шүүхээс дуудсан цагт ирүүлж байх үүргийг цэргийн ангийн удирдлагад хүлээлгэнэ.

Прокурор, мөрдөгч нь цэргийн албан хаагч ямар хэргийн учир яллагдагчаар татагдаж, энэ таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан тухай цэргийн ангийн удирдлагад мэдэгдэнэ.

Шүүх эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, хохирогч, гэрч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, шинжээч, шүүх, прокурор, мөрдөгч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, гэмт хэрэг дахин үйлдэх, үйлдэхээр завдсан гэмт хэргээ төгсгөх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа, урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээний үндэслэл, журмыг зөрчсөн, шүүх, прокурорын дуудахад ирээгүй нь хүндэтгэн үзэх шалтгаангүй байсан зэрэг үндэслэлийн аль байсан тохиолдолд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.

Харин цагдан хорих таслан сэргийлэх авах үндэслэлийг прокурор шүүхэд танилцуулж нотлох үүрэг хүлээнэ.

Яллагдагчийг цагдан хорих үндсэн хугацаа 1 сараас хэтрэхгүй байна. Гэхдээ хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол шүүх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр нэг сар хүртэл хугацаагаар сунгах бөгөөд яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа ердийн гэмт хэрэгт 12 сар, хүнд гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй гэж заасан боловч хэргийн зүйлчлэлийн хувьд онцгой Эрүүгийн хуульд заасан дараах Хорлон сүйтгэх, Хүнийг хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар санаатай алах, Хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар хулгайлах, Төрлөөр устгах зэрэг гэмт хэргийн яллагдагчийг 18 сараас илүү хугацаагаар цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болно гэж заасан.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасан батлан даалтанд өгөх таслан сэргийлэх арга хэмжээ энэ төсөлд огт тусгаагүй ба харин оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй тухай баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээний агуулгыг өөрчилж хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ болгон өөрчилж, шинээр баримт бичгийг хураан авах, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх, зорчих эрхийг хязгаарлах зэрэг шинэ таслан сэргийлэх арга хэмжээний төрлүүдийг тусгасан байна.

СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧААС МЭДҮҮЛЭГ АВАХ СЭТГЭЛ ЗҮЙН ТАКТИКИЙН АСУУДАЛ

Сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах ажиллагаа нь шүүх сэтгэл судлалын /Судебная психология/ нэг чухал асуудал юм. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйд нөлөөлөн гэмт үйлдэл нэг бүрийг илрүүлэн тогтоох гэмт хэргийн зорилго, сэдэлт харьцаа хандлагын тухай танин мэдэх гол ажиллагаа байдаг.

Мэдүүлэг авах нь эсрэг хоёр талынхаа сэтгэхүйд нөлөөлөн, өнгөрсөн үйлдлийг хуучин байдлаар оюун санааны үйл ажиллагаагаар танин мэддэг, тодорхой арга барил шаарддаг юм. Үүнд:

Нэгдүгээрт: Өөр өөр хүсэл, сонирхол бүхий хоёр талын хүмүүсийн зөрчил.

Сэжигтэн, яллагдагч үйлдсэн гэмт хэргээ нуун далдлах, худал мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах, хэргийг будилуулах сөрөг сонирхолтой байдгийг анхааран үзэх шаардлага тулгардгийг санахад илүүдэхгүй.

Хоёрдугаарт: Энэ зөрчил нь ажил хэргийн хэд хэдэн зорилгыг шийдвэрлэхэд тусална.

Сэжигтэн, яллагдагчаас мэдүүлэг авах бүрт эсрэг, тэсрэг зүйлээр хариу өгөх магадлал их байдгийг анхаарахад илүүдэхгүй юм. Гэвч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь ЭБШХ-д заасан үндэслэл, журмын дагуу мэдүүлэг авах, хуульд захирагдах ёстой.

Гуравдугаарт: Мөрдөн байцаалт явуулах нь тактикийн тусгай арга барил хэрэглэхийг шаарддаг онцлогтой. Үүнээс үндэслэн мөрдөн байцаах тактик, үзлэгийн тактик, нэгжих тактик зэрэг мөрдөн байцаалтын тодорхой ажиллагааны тактикууд хоорондоо холбоотой байдаг.

Энэ сэдвээр хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын арга барилыг судалж тэд ямар арга ухаан хэрэглэдэг, хэзээ хэрэглэдэг, бас хэрэглэх ур дүй нь ямар болох, тэдний “хувийн онол” “хувийн арга” юу болохыг судалснаа танилцуулж байна.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нарын хэрэглэдэг тактик буюу арга барилыг дараах байдлаар дүгнэж байна. Үүнд:

1. **Санаагүй, бодоогүй зүйлийг гэнэт асуух.** Энэ нь өмнө өгсөн мэдүүлэгтэй огт холбоогүй зүйлийг асуух, эсхүл сэжигтэн, яллагдагч нарын мэдээгүй, нотлох баримтыг гарган асуулт тавина. Сэжигтэн, яллагдагчаас хариулт өгөөгүй байхад санаанд нь ороогүй, санамсаргүй асуулт бэлтгэн тавих нь сандралд оруулах, хэргээ хүлээхэд нэмэр болно.

2. **Дэс дараатай лавшруулж асуух.** Өмнө нь өгсөн мэдүүлгийг холбон асуух, бүрэн нотолгоо гаргахаас өөр аргагүй боллоо гэсэн ойлголт, бодлыг сэжигтэн, яллагдагчид тулгана. Энэ арга нь өмнөх арга барилын эсрэг талын арга юм.

3. **Түгшүүр үүсэх асуулт асуух.** Сэжигтэн, яллагдагчид олон асуулт тавилгүй цөөхөн, бага хугацаанд, бодит нотолгоонуудыг нэгэн зэрэг гарган асуухна. Энэ арга нь янз бүрийн яриа, хариултаар үймүүлэх, самууруулах бололцоогүй болгоно. Хэргийн гол зүйлийг нэг зүйлд хандуулан бодуулж, яриа чөлөөтэй, хариулт нь түргэн, худал зүйл зохиож бодох зай, цаг олгохгүй байдаг онцлогтойг анхаарах шаардлага тулгарна. Харин олон цагийн

турш асууж байцаах нь ашиг багатай бөгөөд сэжигтэн, яллагдагчийг ядраан залхааж хариулт бүрхэг болох сөрөг тал гарна.

4. **Сэтгэл зүйн түгшүүр, эмзэглэлийг асуух.** Зарим сэжигтэн, яллагдагч мэдүүлэг өгөхөөс татгалзаагүй боловч хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зүгээс түүнтэй ярилцах боломжгүй болдог. Мэдүүлэг авах байдал бүрдээгүйгээс, илүү зүйл хэлчих вий гэж эмзэглэх, айх, хэт ядрах, олон асуултанд хариулах зэргээс шалтгаалан сэжигтэн, яллагдагч биеэ барьсан шинжтэй тохиолдолд байцаалт авах шаардлагагүй байдаг. Гэхдээ энэ аргын эерэг тал нь сэтгэл зүйн хямрал, хөвчрөлийг⁶⁷ арилгах хангалттай мэдүүлэг авах бололцоо өгч болох юм.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагчийн сэтгэл санаа, төрх, бодол төлөвлөгөөг байнга хянаж байх хэрэгтэйг мартаж болохгүй. Хэрвээ түгшүүртэй, эмзэглэсэн байдалд автагдсан бол мэдүүлгээ түр хугацаагаар хойшлуулж, тэр хүний яаж амьдардаг, юу сонирхдог, ажил, амьдралд нь юу саад болж байгаа зэрэг жирийн байдлаар ярилцан санал бодлоо солилцож болдог. Ингэж найрсаг яриа өрнүүлснээр сэжигтэн, яллагдагч хүнд байдал, түгшүүр болгоомжиллоос гарч, сэтгэл санаа нь тайвшран хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчтай ойлголцох хандлага бий болдог. Ийнхүү хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчтай “чин сэтгэлийн яриа хийе” гэж боддог хүн олон байдгийг анхаарч байх хэрэгтэй. Энэ илэн далангүй ярианаас тэмдэглэж бичиж авах зүйлийг заавал тэр хүний өмнө бичиж тэмдэглэх нь хэрэггүй санагддаг. Зарим хүн тэмдэглэлээс болгоомжилж ярих зүйлээ товчилдогийг санах нь зүйтэй.

5. **Сайн талыг нь асуух.** Сэжигтэн, яллагдагчийн сайн талыг олж мэдсэний үндсэн дээр түүний үнэнч шударга, шулуун цайлган, зоригтой, зан чанарыг нь түшиглэх нь зүйтэй юм. Мөн түүний гавьяа зүтгэл, ажлын болон хувийн амьдралын байдлыг ашиглан мэдүүлгээ авч болдог.

6. **Сэтгэл зүйн сул талыг нь ашиглаж асуух.** Аймхай, хулчгар, хурдан дүрсхийн уурладаг, бухимддаг хүмүүсийн сэтгэл зүйд тохирох асуултыг хурцаар тавьж асууж болдог.

7. **Үлгэр,⁶⁸ домог буюу худал ярихыг нь сонсож асуух.** Сэжигтэн, яллагдагч нь худалж ярьж “Хувийн үлгэр домог” зохиож байгааг нь мөрдөн байцаагч мэдэж байвч түүнийг нь тэсвэрлэн сонсох явдал бас байдаг. Ийм тохиолдолд надад итгэж байна, анхааралтай сонсож байна гэж итгэлтэйгээр өөрийгөө буруугүй мэтээр нотолгоо гаргахыг оролдоно. Энэ үлгэр, домог яриаг хэлүүлэх нь сэжигтэн, яллагдагч нь мөрдөн байцаагчийн анхаарлыг юунд хандуулж байна, юуг, яаж нууж байна, юунд итгүүлэх гэж оролдож байна, мөрдөн байцаалтаас юуг нь хөндийрүүлэх, холдуулах санаатай байна гэдгийг мэдэхэд тус болдог. Ер нь худал мэдүүлэг нь ямагт үнэнийг тойрч эргэдэг. Үүнийг ажиглан бодит үнэнд ойр ба хол хэсгийг илрүүлэх нь чухал. Мэдүүлэг өгч байгаа этгээд нь үнэнийг өөртөө, дотроо бодож байж, үнэн зөвийг санаж байж худал хэлдэг гэж үздэг.

8. **Худал мэдүүлэг өгүүлэхгүй асуух.** Зарим үед худал мэдүүлэгт итгэж байна гэсэн ойлголт, бодлыг мэдүүлэг өгөгчид төрүүлэхгүй, харин үнэмшихгүй эргэлзэж байна гэдгийг мэдэгдэх нь зүйтэй байдаг. Энэ нь мэдүүлэг өгөгчид үр ашиг өгөхгүй, үнэнээ л ярьа гэсэн ойлголт бодлыг авахад тусална.

9. **Шуурхай, эрчимтэй асуух.** Зарим хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч мөрдөн байцаалтыг шуурхай явуулах хэрэгтэй болдог. Мөрдөлтийн санаачилгыг гартаа авч,

⁶⁷ С. Жанцан Хууль зүйн сэтгэл судлал УБ., 2005 он, 323 дахь тал

⁶⁸ Ж. Хурцгэрэл Криминалистик 2 УБ., 2002 он, 306 дахь тал

идэвхтэй шуурхай байр эзлэн элдэв хариулт, цохилт бэлтгэх зай завсар, өрсөлдөгч талд олголгүй сэргийлж, түүний бодол, санаанаас түрүүлэн явах хэрэгтэй болдог. Ийм тохиолдолд асуултыг түргэн тавьснаас мэдүүлэг өгч байгаа этгээд худал мэдүүлэх, эсхүл мөрдөлтийн эсрэг хариултыг тухтай бодож чадахгүй, тархи оюундаа нэгэнт үлдэж хоцорсон ул мөрийн талаар үнэн зүйлийг хэлэхэд хүрдэг байна.

10. Аажим асуух. Зарим үед аажим удаан асууж мэдүүлэг авах тохиолдлууд гарна. Учир нь сэжигтэн, яллагдагч хурдан түргэн цувруулан тавьсан асуултуудаас өөртөө аль осолтой асуултыг нь орхин алгасч, хариултаа олигтой хариулахгүй, гол чухал асуудлаас зайлсхийн хөндийрүүлэхийг оролдоно. Иймээс удаан асууж мэдүүлэг авах нь мөрдөлтийг үндэс суурьтай, бодолтой нарийн явуулахад тус болно.

11. Яриандаа халсныг нь ашиглан хэлүүлэх. Зарим хүн мэдүүлэг өгөхдөө өөр бусад юм ярьж байгаад тэр эрчиндээ буюу хүчээр хэлэхгүй гэсэн юмаа хэлчихдэг явдал бий. Туршлагатай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бол нэг төрлийн яриаг нөгөө ярианд ургуулан орлуулж, жинхэнэ чухал сэдвийг хэлүүлдэг юм. Аль чухал үндсэн асуудлыг хөндөн яриулахыг хичээх, бас тэгж хэлүүлэх цаг үе, тохироог яриан дундаа зөв олох нь чухал.

12. Хариулт бодуулахгүй асуух. Сэжигтэн, яллагдагч этгээд бол мөрдөн байцаагчийн асуултуудыг сайтар тогтоон авч түүний аль нь чухал болох, аль нь үндсэн биш асуулт вэ? гэдгийг мэдэж авах гэж хичээдэг онцлогтой. Иймээс өөртөө ашиг тус болох аль нэг зүйлд анхаарал, хариултаа чиглүүлнэ. Энэ үед мөрдөн байцаагч мэдүүлэг өгөгч этгээдийн анхаарлыг зориуд гол бус зүйл руу чиглүүлж, асуулт, хариултынхаа аль чухал хэсгээс хөндийрүүлэхийг хичээх хэрэгтэй юм. Энэ үед сэжигтэн, яллагдагч болгоомжлон сэргийлэх, эмзэглэн хаширлахаа больж мөрдөн байцаагчид хэрэгтэй мэдээ баримтыг өгөхөд хүрнэ.

13. Мэдүүлгийг давтан⁶⁹ явуулж асуух. Мэдүүлгийг давтан авах нь ашигтай болон хор уршигтай гэдгийг сайн санаж байх ёстой юм. Дахин мэдүүлэг авахын хооронд мэдүүлэг өгөгч нь худал мэдүүлэг өгөх бэлтгэл сургууль хийдэг гэсэн үзэл байдаг. Гэвч түрүүчийн тавьсан асуултаараа дахин мэдүүлэг авах явдал заримдаа хэрэгтэй байдаг. Ингэж мэдүүлэг авахад сэжигтэн, яллагдагч мэдүүлгийнхээ зарим нарийн эгзэгтэй хэсгийг мартсан байдаг. Ингэж дахин мэдүүлэг авах нь:

а/ Эхний үеийн мэдүүлгээс гажсан зөрүүтэй зүйл юу байгааг олж мэддэг

б/ Худал мэдүүлэг өгч байгааг нотлох баримт сэлт гаргаж авах зорилготой байдаг.

Давтан мэдүүлэг авах нь мэдүүлгийн зөрөөг илрүүлэх, худал хэлэх тутам гарч ирдэг зөрөө ялгааг мэдэхэд тусалдаг гэж үздэг.

14. Эргэцүүлэх хугацаа өгөх. Хэдэн удаагийн мөрдөн байцаалт хоорондоо завсарлага зайтай байдаг. Энэ үед сэжигтэн, яллагдагчийн сэтгэл санаанд хувирал өөрчлөлт гардаг. Үнэнийг мэдүүлэх санаа сэдэл ч төрж магадгүй. Ийм тохиолдолд мөрдөн байцаагчтай уулзах ярилцах хүсэл төрдөг. Энэ тохиолдолд мөрдөн байцаагч мэдүүлэг авахыг яарахгүй, хойшлуулах, өөрийгөө илчлэн баримт, нотолгоо бий болгохоос өмнө түр хүлээлгэх нь зүйтэй байдаг. Ингэж азнаж мэдүүлэг авах нь эхний худал мэдүүлгийн үүрэг холбогдлыг үгүй болгож байгаа хэрэг юм.

15. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бүгдийг мэдэж байна гэсэн ойлголт төрүүлэн асуух. Сэжигтэн, яллагдагчийг хуурч мэхлэхгүйгээр ийм бодлыг төрүүлэх хэрэгтэй. Үүнд:

⁶⁹ Ж. Хурцгэрэл Криминалистик 2 УБ., 2002 он, 307 дахь тал

а/ Бие, үйл хөдлөлөө зөв байлгах

б/ Мөрдөн байцаагчид мэдэгдээгүй гэж бодсон үнэн зөв баримт, нотолгоог түүнд гарган хэлж өгөх, намтар түүх, хэрэг явдлаас зарим нарийн хэсгийг сануулах замар хандах нь зүйтэй.

Мэдсэнээ ингэж цухуйлгах нь мөрдөн байцаагч бүх болсон асуудлыг сайн мэдэж байна гэсэн ойлголтыг бий болгож цааш мэдүүлэг өгөхөөс сэргийлнэ.

16.Энэ нь дутуу байна гэсэн ойлголтыг өгөөд яриулах. Энэ тохиолдолд нотлох баримт хангалтгүй энэ хэсэг л дутуу байна, тэр зүйл нь тодорхой бус байна эдгээрийг гүйцээх юм бол бидэнд маргах хэлэлцэх зүйл байхгүй болно гэдгийг итгүүлж ойлгуулах нь чухал байдаг. Дутуу буюу бүрхэг зүйлийг мөрдөн байцаагч тэмдэглэн хэлж өгөхөд мэдүүлэг өгч байгаа этгээд тайвширч мэдүүлгээ утгатай, дэс дараалалтай зөв өгөх эрмэлзэлтэй болдог.

17.Халз маргаанд дуудан ярилцаж ялах. Сэжигтэн, яллагдагчтай утга агуулгаараа зөв, дэс дараалалтай яриа өрнүүлэх мөрдөн байцаагчид ашигтай байдаг. Ялангуяа оюун сэтгэхүйн хөгжлөөр сайн хүмүүстэй харьцахад нилээд аятайхан боломжтой байдаг. Ингэж тэр хүмүүсийг халз маргаанд дуудан оруулж болно. Мөрдөн байцаагч эхлээд ялын шийтгэлийн талаар аль хүчтэй маргааныг үүсгэх хэрэгтэй бөгөөд сэжигтэн, яллагдагч маргах дуртай болно. Цааш нь мөрдөн байцаагч нь нотлох баримт бүхий бол хүчтэй асуултыг тавьж хүчтэй зүйлийг тайлбарлахыг шаардаж асуух бөгөөд мөрдлөгийн асуух утга, дэс дарааг эвдэх оролдлого биелэхгүй болсныг ойлгуулах хэрэгтэй. Энэ яриандаа хэрэг ач холбогдол бүхий мэдээллийг олж авах ёстой.

18.Хамтарч ярилцан хэрэг илрүүлэх. Мөрдөн байцаагч мэдүүлэг өгөгч хоёр ярилцах явцад сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгийн бүтэц, утгыг сайн анхааран харж, түүний үндсэн дээр мөрдөн байцаалтанд хэрэг болохуйц зүйлийг олж авна.

Дээрх дурдсан 18 зүйлийн аргыг эмхтгэн цэгцэлж ангилж авч үзвэл:

1. **7, 11, 12, 13 дугаарт** дурьдсан арга бол сэжигтэн, яллагдагчаас мэдээ, баримт сэлт олж авах, түүний хувийн байдлын тухай хэргийн бодит үнэнийг тогтоож мэдэхэд чиглэгдсэн байна.

2. **4 ба 18 дугаарт** дурдсан арга бол сэжигтэн, яллагдагчтай холбоо тогтооход чиглэгдсэн өөр сэдвээр ярилцах, асуулт мэдүүлгийнхээ байдлыг урьдчилан харж, мэдэх асуултаа зөв эхлэх дуусгахтай холбоотой юм.

3. **1, 3, 4, 9, 10, 14 дүгээр** зүйлд гарч буй арга нь сэжигтэн, яллагдагчийн сэтгэл зүйд нөлөөлөх, ямар нэгэн шинэ байдал, өөрчлөлт үүсгэх, ярилцахад чиглэсэн байна.

4. **5, 6 дугаарт** заасан арга бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн бие хүний хувийн чанарт ганцаарчлан хандаж нөлөөлсөн арга барил байна.

5. **2, 8, 12, 15, 16, 17 дугаар** арга бол сэжигтэн, яллагдагчид хэргийн талаар тодорхой бодол төсөөлөл, ойлголт төрүүлэн улмаар нотлох баримтыг гаргуулахад чиглэгдсэн гэж үзэж болохоор байна.

6. **13 дугаар** зүйлд гарч байгаа мэдүүлгийг давтан явуулж асуух арга нь сэжигтэн, яллагдагчийн мэдүүлгийн үнэн худлыг тодорхойлон илрүүлэхэд нэмэлт туслалцаа үзүүлэх арга байна.

Дээр дурдсан сэтгэл зүйн тактик буюу арга бүрийг алдаагүй, хэрэглэх нь тухайн хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчийн туршлага анхаарал, авхаалж самбаа, сэтгэлгээнээс шалтгаалдаг гэдгийг хэлэх нь зүйтэй болов уу. Эдгээр аргуудын аль аргыг нь хэдүйд, ямар цаг хугацаанд хаана, хэрхэн яаж хэрэглэхийг сайтар бодож нягтлан боловсруулж хэрэглэх чухал юм.

КРИМИНАЛИСТИКИЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ

Д.Алтантуяа

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Шинжлэн
магадлахуйн тэнхимийн багш, цагдаагийн хошууч*

ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГТ КРИМИНАЛИСТИКИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ОРОЛЦОО, АНХААРАХ АСУУДАЛ

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д: "Үзлэг хийхэд уг хэрэгт хувийн сонирхолгүй мэргэжилтэнг урьж болно".

ЭБШХ-ийн хэм хэмжээнд мөрдөн байцаах ажиллагаанд мэргэжилтэнг татан оролцуулдаг ч түүний эрх зүйн үндэс суурь нь бараг тодорхойгүй, эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд мэргэжилтний үйл ажиллагааг урьдчилсан нөхцөлд дүрэм тогтоох нь чухал хэрэгтэй байна.

Криминалистикийн мэргэжилтний эрх зүйн байдлыг хуульчлахгүй бол практикт мэргэжилтэн гэж хэнийг хэлээд байгаа ЭБША-нд хэн гэдэг ямар эрх үүрэг, хүлээх хариуцлагагүй этгээдийг оруулаад байгаад эргэлзээтэй асуудал юм.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 502 дугаар тушаалаар баталсан код 200-д⁷⁰ шуурхай удирдлагын албаны үйл ажиллагаа "Хэргийн газрын үзлэгийн баг"- Мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч, эрүүгийн төлөөлөгч, нохойн төлөөлөгч, мэргэжилтэн, шинжээч зэргээс бүрдсэн хэсэг, баг байж болно гэж заасан байна. Код 200.4.10 е/ мөрдөн байцаагч, криминалистикийн мэргэжилтэн нар хэргийн газрын үзлэгийг бүх талаас нь бүрэн хийж, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, сэжигтнийг олж тогтоох зэрэг хойшлуулшгүй ажиллагааг явуулна. Манай улсын хууль тогтоомжид криминалистикийн мэргэжилтний эрх зүйн орчинг бүрдүүлж өгөөгүй, хуульчлаагүй нь учир дутагдалтай байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2006 оны 153 дугаар тушаалын хавсралт криминалистик, шүүх эмнэлгийн шинжээчийн жижүүрийн үүрэг гүйцэтгэхдээ дагаж мөрдөх журамд зааснаар 1.3. жижүүрийн үүрэг гүйцэтгэхээр томилогдсон шинжээч нь /цаашид "жижүүрийн шинжээч" гэх/ гаргасан хуваарийн дагуу 24 цагийн турш байнгын бэлэн байдалд жижүүрийн үүрэг гүйцэтгэнэ. Мөн жижүүрийн шинжээчийн үүрэг, эрх бусад зүйл журам боловсруулсан байна.⁷¹ Уг журамд хэргийн газрын үзлэгт оролцох жижүүрийн шинжээчийн эрх зүйн байдлыг журамлаж өгсөн байна.

Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд удирдлагын санамж бичиг, журам батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний төвийн захирлын 2006 оны хамтарсан тушаал "Цагдаагийн болон Шүүхийн шинжилгээний байгууллагын хамтын ажиллагааны чиглэл батлах" тухай,

⁷⁰ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2010 оны 502 дугаар тушаал

⁷¹ Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2006 оны 153 дугаар тушаалын хавсралт

- Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2009 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 73/102 дугаар хамтарсан тушаалаар “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын хамтран ажиллах журам”,

- Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын 2012 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 385/а278 дугаар хамтарсан тушаал “Цагдаа, шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчид хэргийн газрын үзлэгт хамтран ажиллах журам”

Дээрх журмаар цагдаагийн болон шүүхийн шинжилгээний байгууллагууд гэмт хэрэг илрүүлэх, гэмт этгээдийн үйлдлийг нотлон тогтоох чиглэлээр хэргийн газрын үзлэгийг зохион байгуулж явуулах, хэргийн холбогдолтой ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, хураан авах, тэдгээрт шинжилгээ хийж дүгнэлт магадлагаа гаргах, нэгдсэн сан бүрдүүлэх, хадгалах, баяжуулах, ашиглах харилцан мэдээлэл солилцох чиглэлээр хамтран ажиллах харилцааг зохицуулсан байна.

Гэмт хэргийг цаг алдалгүй богино хугацаанд илрүүлэх, гэмт этгээдийг олж тогтоох ажиллагаа нь хэргийн газрын болон гэмт хэргийн газрын үзлэгийн үр дүнгээс шууд шалтгаална. Иймд гэмт хэргийг илрүүлэх, ул мөр эд мөрийн баримт үлдэж хоцордог тул илрүүлж, бэхжүүлэх, хураан авах ажиллагаа нь хамгийн чухал юм. Учралын газарт хийгдэж буй үзлэгт анхаарлаа хандуулбал үзлэгийг хайхрамжгүй, дутуу хийх, албаны бэлэн байдлыг хангаагүйгээс цаг алдаж очих, ноцтой хэргийн шинж бүхий учралын газарт олон хүн цуглаж, удирдлагагүй ажиллах зэрэг дутагдал байсаар байна⁷². Чухамдаа цаг алдаж очих, учралын газарт олон хүн цуглах зэрэг асуудал одоо ч байсаар, цаашдаа ч байхаар төлөвтэй нь ажиглагдаж байна. Яагаад гэвэл гэмт хэргийн газрын хамгаалалт гэдэг ажиллагаа хийгдээгүй байгаа нь хэргийн газраас ул мөр илрүүлэх, бэхжүүлэх, цаашдын хэргийн үйл ажиллагаанд муу нөлөө үзүүлсээр байна.

Хэргийн газарт ажиллах бие бүрэлдэхүүнийг очиход хэргийн газрыг хамгаалтанд аваагүй байдаг тул сониуч зантай олон хүн цугларах, ялангуяа ноцтой хэргийн газарт хүчний байгууллагын удирдлагууд очиж, хэргийн газрын ул мөрийг баллах, нэмэлт мөр үүсгэх, хэргийн газрын орчинг бохирдуулах, бичил мөр адилтгалын шинжилгээнд тэнцэх байсан гутлын, гарын болон бусад мөрүүдийг устгадаг. Энэ нь гэмт хэргийн газраас илрүүлсэн ул мөрийн мэдээлэлд тулгуурлан хийх мөрдөн байцаалтын, эрэн сурвалжлах, шинжээчийн ажилд сөргөөр нөлөөлж цаашид хэргийн бодит үнэнийг тогтоох, чиглүүлэх, гэмт хэрэгтний талаарх мэдээлэл авах, хэргийн хүрээг хумих, цаг алдахгүй байх, таамаглал дэвшүүлэх, халуун мөрөөр нь илрүүлэх зэрэг ажиллагаанд саад болдог.⁷³ Хэргийн газрын үзлэг эхлэхээс өмнө хэргийн газрын хамгаалалт авагдах ёстой боловч амьдралд огт хэрэгжихгүй байна


Манай улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо жилээс жилд өсөж, гэмт хэрэгтнүүдийн үйлдлийн арга нь улам нарийсаж нууц далд аргаар, бүлэг зохион байгуулалттай үйлдэгдэж түүнийг илрүүлэхэд шинжлэх ухааны үндэстэй шинжилгээ түүний нотолгоо хамгийн чухлаар тавигдаж байна. Иймд шинжилгээний алба, ажилтнууд шинжлэх ухаан, техник технологийн ололт амжилтыг бүрэн ашиглах, энэ талын мэдлэг, дадлагаа ямагт дээшлүүлэх нь гэмт хэргийн илрүүлэлтэнд ихээхэн ач холбогдолтой. Гэмт хэрэгтэй тэмцэхэд криминалистикийн мэргэжилтний шинжлэх ухааны тусгай мэдлэг зайлшгүй чухал бөгөөд криминалистикийн шинжээчдийн гар дээр ашиглагдаж буй

⁷² Б.Жаргалсайхан "Учралын газрын үзлэг" 2008 он

⁷³ Д.Адилбаяр Хэргийн газрын хамгаалалтыг хэрэгжүүлэх илтгэлээс

шинжилгээний багаж тоног төхөөрөмж дутагдалтай байгаа нь гэмт хэргийг бодит нотлох баримтаар цаг алдалгүй түргэн шуурхай илрүүлэх цагдаагийн байгууллага болон шүүхийн шинжилгээний албаны хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

2014 онд шүүхийн шинжилгээний байгууллагын криминалистикийн шинжээчид 29108 хэргийн газрын үзлэгт биет нотлох баримт илрүүлж, бэхжүүлсэн байна. Үүнээс, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжилгээний хэлтсийн шинжээчид 199 удаа, Нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжээчид 18674 удаа, аймгуудын шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн шинжээчид 10235 удаа хэргийн газрын үзлэгт мэргэжилтнээр оролцсон байна⁷⁴.



Криминалистикийн мэргэжлийн шинжээчдийн нөхөн хангалт дотоодод академик сургалтаар жил бүр хийгдэж байна. Криминалистикийн шинжилгээний алба 1993 оныг хүртэл хуучнаар ЗХУ-д мэргэжлийн боловсон хүчнээ бэлтгэдэг байсан. 1993 оноос хойш 10 жилийн дараа криминалистикийн дээд боловсролтой боловсон хүчин дотооддоо бэлтгэх бодлогын хүрээнд 2003 оны 10-р сарын 28-ны өдөр криминалистикийн шинжээчийн ангийг БСШУЯ-наас олгосон тусгай индекс, зөвшөөрлөөр нээн хичээлүүлж эхэлснээс хойш 5 удаагийн төгсөлт болсон буюу 2005 онд 28, 2007 онд 17, 2010 онд 26, 2011 онд 28, 2012 онд 22, нийт 129 шинжээчийг бэлтгээд байна. Одоо “Криминалистикийн шинжилгээ-эрх зүй” мэргэжлээр 1, 2, 4 дүгээр дамжаанд 95 сонсогч суралцаж байна. Үүнээс гадна "Криминалистикийн мэргэжилтэн" бэлтгэх дамжааг дотооддоо 1992 онд 22, 1997 онд 6, 1998 онд 22, 1999 онд 27, 2001 онд 32, 2009 онд 14 тус тус төгсгөсөн байна. Монгол улсын хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд шинээр батлагдан мөрдөгдөж

⁷⁴ Шүүх шинжилгээний статистик мэдээ 2014

байгаа хууль тогтоомжийн дагуу цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдөж, аймаг нийслэлийн цагдаагийн газар, хэлтсүүд 2-3 хуваагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнтэй холбогдуулан шүүхийн шинжилгээний байгууллагын аймаг, нийслэлийн албадад хэргийн газрын үзлэгийн мэргэжилтний орон тоог нэмэгдүүлэх асуудал тулгарсан. Үүний дагуу Хууль сахиулахын их сургууль, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирлын хамтарсан тушаалаар их сургуулийн Ахлагчийн сургууль, Шинжлэн магадлахуйн тэнхим, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн хамтран 2013 онд 22, 2014 онд 32 бэлтгэх дамжааг дахин бэлтгэн, сургалт зохион байгуулсан байна.

Орон нутагт мэргэжлийн нэгээс доошгүй шинжээчид ажиллаж байгаа өнөө үед тэдний онолын болон практик мэдлэгийг шинжилгээ, судалгааны ажилд бүрэн дүүрэн ашиглахад зайлшгүй шаардлагатай зүйлсийн нэг бол техник хэрэгслийн хангалт мөн юм. Гэмт хэрэг үйлдэж буй этгээд гэмт санаа зорилгоо хэрэгжүүлэхдээ орчин үеийн дэвшилтэд техник, технологийг ашиглаж байгаа бөгөөд түүнээс үлдсэн ул мөрийг шинжилж буй криминалистикийн шинжээчдийн гар дээр ямархуу багаж, техник хэрэглэгдэх шаардлага гарч байгааг хэлэхэд илүүц зүйл юм. Мөн дүүрэг, орон нутгийн шүүхийн шинжилгээний албаны байрыг шинжилгээ судалгаа явуулахад тохиромжтой зориулалтын эрүүл ахуйн болон бусад техникийн шаардлагыг бүрэн хангасан стандартын дагуу байлгах нь ажлын үр дүнд сайнаар нөлөөлнө. Гэмт хэргийн газраас хураагдсан хэрэгт ач холбогдол бүхий ул мөр, эд мөрийн баримтыг хадгалах, төрөл бүрийн овор хэмжээтэй, янз бүрийн зүйлээр бохирлогдсон, муудсан шинжилгээний объектуудад үзлэг шинжилгээ хийхэд ажлын байран дахь нөхцөл чухал юм.

Дүүргүүдийн шүүхийн шинжилгээний албаны криминалистикийн тасагт Папилон 7.7.2 систем иж бүрдлийн хамт, хэргийн газрын үзлэгийн цүнх, дижитал аппарат, компьютер зэрэг техник хэрэгсэл ашиглагдаж байгаа хэдий ч гэмт хэргийн газрын үзлэгт ашиглагддаг ул мөр илрүүлж бэхжүүлэн авах зориулалттай төрөл бүрийн нунтгууд шаардлага хангахгүй, зарим төрлийн техник хэрэгсэл дутагдалтай байна.

Дээрхээс дүгнэн үзээд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хуулийн дагуу бие даасан, хараат бус үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох. Цагдаа, Шүүхийн шинжилгээний байгууллагын хамтарсан тушаал шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулж, албадын ажлын уялдаа холбоог бэхжүүлэх

2. Криминалистикийн болон бусад төрлийн шинжилгээнд ашиглагдах орчин үеийн тусгай техник хэрэгслийн хангалтыг цаг тухайд нь хийж байх. /материаллаг баазыг бэхжүүлэх/

3. Хэргийн газрын үзлэгт алба хаагчдын багаар ажиллах чадварыг дээшлүүлэх чиглэлээр шаталсан сургалт зохион байгуулах, шинжилгээний орчин үеийн арга барил, дэвшилтэт технологийг бүрэн эзэмшүүлж, дотоодод болон гадаадад урт, богино хугацааны мэргэшүүлэх сургалтад хамруулах.

4. Гэмт хэрэгтэй тэмцэх, шинжилгээний чиг үүргийг хэрэгжүүлэхэд ажиллах нөхцөл, орчин үеийн шинжилгээний тоног төхөөрөмж хангамжийг сайжруулах, хэргийн газрын үзлэгт ул мөр илрүүлж, бэхжүүлэн авах зориулалттай нунтгуудыг чанаржуулах, тоо төрлийг олшруулах, хангалтыг нэмэгдүүлэх зэрэг болно.

БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТ ШҮҮХ ЭМНЭЛГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД АНХААРАХ НЬ

Товч агуулга: Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг мөрдөх явцад шүүх эмнэлгийн шинжилгээгээр шийдэх асуудал олон байдаг. Үүний тулд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтуудтай танилцаж шинжээч томилох тогтоолд ямар асуулт тавих, шүүх эмнэлгийн гаргасан дүгнэлтийг хэрхэн ойлгох талаар зарим асуудлуудыг хөндөж тавьсан.

Түлхүүр үг: Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл

Хүчиндэх гэмт хэргийн ноцтой үр дагавар нь бие махбодийн болон сэтгэл санааны хүнд гэмтэл, цочрол авсны улмаас хохирогч амиа хорлох явдал юм. Ийм тохиолдолд шүүх эмнэлэг, шүүх сэтгэцийн хавсарсан шинжилгээ хийх хэрэгтэй.

Насанд хүрээгүй хүн хүчиндүүлсэн, түүнийг нотлох ямар нэгэн бичиг баримт байхгүй тохиолдолд шинжээч томилох тогтоолд нас тогтоох тухай асуултыг тавих шаардлагатай. Зарим тохиолдолд хэрэгт холбогдогч этгээдэд ч ийм асуулт тавьж шүүх эмнэлгийн шинжилгээ хийлгэнэ.

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тухайд шүүх эмнэлгийн шинжээч жам ёсны бэлгийн харьцаатай холбоогүй, өөрөөр хэлбэл, бэлгийн дур хүслээ бусад хэлбэрээр хангадаг байсан эсэхийг тогтоох шаардлага гардаг. Жишээ нь: шулуун гэдсээр бэлгийн харьцаанд ордог байсан эсэх г.м

Шулуун гэдсээр хурьцал үйлдсэн тохиолдолд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг эсэхийг тогтоох нь хууль зүйн ач холбогдолтой. Шүүх эмнэлгийн шинжилгээгээр идэвхтэй хамтрагчийн бэлэг эрхтний толгой, титэм ховилыг нарийн үзэх хэрэгтэй. Идэвхгүй хамтрагчийн шулуун гэдэсний арчдаст эр бэлгийн эс илрүүлэх нь чухал. Мөн идэвхгүй хамтрагчийн шулуун гэдэсний салст бүрхүүл улайх, хошногны амсар суларч ангайх, шулуун гэдэсний доод хэсэг юүлүүр хэлбэртэй болох зэрэг бүтцийн өөрчлөлтүүд илэрдэг⁷⁵. Хүчирхийллийн шинж тэмдэг болох гэмтлийн элементүүд бие дээр байгаа эсэх, зарим тохиолдолд хохирогч холбогдогч нарын насыг тогтоох шаардлага гардаг байна.

Шүүх эмнэлгийн шинжилгээгээр бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэх хүний биед учирсан механик гэмтлийг тодорхойлно. Харин эмэгтэй хохирогчийн хувьд:

- Охин хальсны гэмтэл өөрчлөлт байгаа эсэх,
- Урьд нь бэлгийн харьцаанд орж байсан эсэх,
- Биеийн болон бэлгийн хүчирхийллийн шинж байгаа эсэх,
- Жирэмсэн эсэх,
- Бэлгийн замын халдварт өвчтэй эсэх, өвчтэй бол ямар өвчнөөр хэдийд халдварлагдсан байж болох вэ? г.м асуултуудыг шинжээчид тавьж болно.

Охин байдал ба хурьцал үйлдэгдсэн эсэхийг тогтоох:

⁷⁵ Э.Ганбат.,М.Цэрэнбат.,Шүүх эмнэлэг.УБ.2005

Охин байдлын гол шалгуур нь охин хальс хурьцал үйлдэгдэж гэмтээгүй байхыг ойлгоно. Охин хальс нь холбогч эд ба булчингийн ширхэг, судас мэдрэлээс тогтсон үтрээний орох хэсгийн хананд бэхлэгдсэн салст бүрхүүл юм. Охин хальсны бүтцийг чөлөөт ирмэг буюу зах, нүх, суурь гэсэн 3 хэсэгт авч үзнэ.

Охин хальсны хэлбэр янз бүр байна. Үүнд:

- Цагираг-дугуй ба зуйван нүхтэй цагираг хэлбэртэйг хэлнэ. Өргөн буюу захаас суурь хүртэлх зай нь янз бүр байж болно. Ийм хэлбэрийн охин хальс нимгэн, уян, амархан татагддаг, сунамтгай чанартай тул хурьцал үйлдэгдсэн ч урагдахгүй байж болно.
- Тал сар-доод хэсэгтээ өргөн, нүх нь дээд хэсэгтээ байрлана.
- Таславчит-дундуураа таславчтай, нүх нь хоёр хэсэг зуйван.
- Битүү-хальсанд нүх байхгүй. Ийм хэлбэр маш ховор тохиолддог ба анхны биений юм ирэхэд оношлогддог.
- Салбант-чөлөөт зах хэсэг нь салбарласан байна.
- Ургацагт-чөлөөт зах хэсэг нь олон тооны ургацаг хэлбэртэй байдаг.

Охин хальсны өндөр янз бүр байдаг, ихэнх тохиолдолд 1.0-1,5 см, зарим тохиолдолд 2-2.5 см хүртэл өндөр байдаг. Ховор тохиолдолд маш намхан буюу үтрээний салст түвшинтэй ижил өндөртэй буюу байхгүй байж болдог.

Эхний бэлгийн хавьтал буюу бэлгийн харьцаанд орсноор охин хальс гэмтэхийг урагдалт -дефлорация гэдэг. Урагдалт буюу гэмтэл нь нэг, хоёр эсвэл түүнээс олон байрлалд үүссэн байж болно. Ихэнх тохиолдолд 4-8 цагийн байрлалд сууриа хүртэл урагддаг. Ховор тохиолдолд охин хальс өнгөц буюу зах ирмэгийн түвшинд язарч урагддаг. Энэ нь хурьцах үед эрэгтэйн бэлэг эрхтэн охин хальсны доод хэсэгт үрэх, дарах үйлчлэл үзүүлдэгтэй холбоотой юм.

Шинжээчийн дүгнэлтээр охин хальс зөвхөн бэлгийн харилцаанд орсноор гэмтэж, урагдахаас гадна, охин хальсыг гараар оролдох, гадны биет хийснээс мөн цөөн тохиолдолд бусад төрлийн гэмтлийн үед хавсарч урагдсан байж болохыг тогтоож болно.

Шинээр урагдахад цус бага зэрэг гарч, цус хурж хавагнана. 2-3 хоногт цус гарсан, үтрээний үүдэвч хэсэгт цус хурсан, урагдсан хэсгийн ирмэг нь улайж, хавагнасан байна. 3-5 хоногт хаван багасч, урагдлын зах ирмэг нь цагаан өнгөрөөр хучигдана. 5-8 дахь хоногт үрэвслийн өөрчлөлт багасч урагдлын ирмэг нь сорвижно.

Эдгэрэх буюу бүрэн сорвижих хугацаа нь охин хальсны бүтэц, тогтцын болон хувь хүний бие махбодийн онцлогоос хамааран харилцан адилгүй байх боловч дунджаар 12-20 хоногт бүрэн сорвижно.

Сорвижилтын дараа хийгдэх магадлан-шинжилгээгээр хэзээ урагдсаныг баттай тогтоох боломжгүй болдог. Иймд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч нь шинжлүүлэгчийг аль болох яаралтай шинжээч эмчид үзүүлэх нь хэргийн бодит байдлыг тогтооход чухал юм.

Охин хальсны бүтцийн өөрчлөлт нь урагдалт үүссэн хугацаанаас хамаарахаас гадна охин хальсны хэлбэр, өндөр, урагдлын гүн, үтрээний үүдэвч хэсгийн салст бүрхүүлийг хамарч урагдсан байдал зэрэг олон хүчин зүйл, нөхцлөөс шалтгаалж янз бүр байдаг. Дахин гэмтэл авах, халдварлаж үрэвсэх, сарын тэмдэг ирэх зэрэг нь урагдалтын сорвижих хугацааг уртасгадаг. Охин хальсны шинэ урагдалтыг /эхний 7-12 хоног/ оношлох нь сарын тэмдэг ирснээс бусад үед харин охин хальсны хуучин урагдалтыг /урагдалт үүссэнээс хойш 12-20 хоног, түүнээс дээш/ зөв оношлох, түүнийг төрөлхийн сэтэрхийт, салбант,

хэвийн бүтцээс ялгах нь хэцүү бөгөөд шүүх эмнэлгийн практикаас ажиглахад дадлага туршлага багатай мэргэжлийн шүүх эмнэлгийн шинжээч эмч биш бусад мэргэжлийн эмч нарын хувьд буруу тогтоох байдал цөөнгүй тохиолддог бөгөөд мэргэжлийн шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын хамтарсан магадлан шинжилгээгээр бодитой тогтоогдож засагддаг.

Хурьцал үйлдэгдсэн эсэхийг тогтоох

Хурьцал үйлдэгдсэнийг батлах гол нотолгоот шинж үтрээнээс үрийн шингэн эр бэлгийн эс илрэх явдал юм. Үтрээнд үрийн шингэн 2-3 хоног, эр бэлгийн эс 3-5 хоног, харин эр бэлгийн эсийн бүтцийн элемент /толгой, их бие, сүүл хэсэг/ эс судлал /цитолог/-ийн шинжилгээгээр 8-9 хоногийн дотор илрэх боломжтой. Энэ тохиолдолд шинжлүүлэгч тэдгээрийг устгах зорилгоор янз бүрийн арга хэмжээ аваагүй байх хэрэгтэй. Энэ шинжилгээг хийхдээ шинжээч эмч шинжлүүлэгчийн үтрээний арын хүнхрэнээс самбаан болон зориулалтын тампоноор арчдас аваад тосгүй хуурай зориулалтын хавтгай шилэн дээр наалдац авч тасалгааны нөхцөлд хатааж шинжилгээнд илгээдэг.

Эрэгтэйн үрийн шингэний бүлгийн харьяалал нь тухайн хүний АВО системийн бүлгийн харьяалалтай тохирч байдаг тул энэ шинж дээр тулгуурлан холбогдогч этгээдийн болон хувцас болон бусад эд материал дээр байгаа үрийн шингэний бүлгийн харьяаллыг тогтоодог. Үүний тулд үтрээнээс авсан арчдас, наалдацыг харьцуулах шинжилгээнд ашигладаг. Хэрэв бэлгийн харьцаанд амны хөндий болон шулуун гэдсээр орсон тохиолдолд үрийн шингэн, эр бэлгийн эс илрүүлэх шинжилгээг шулуун гэдэс, амны хөндийгөөс авсан арчдас наалдцанд илрүүлэхээр хийдэг.

Бүлгийн харьяалал буюу ялгаруулагчийг тодорхойлохын тулд хохирогч, холбогдогчдын хоёулангийнх нь шүлс, эсвэл цусыг шинжилгээнд авдаг. Хэрэв бэлгийн гэмт хэрэгт холбогдсон гэх этгээд нас барсан тохиолдолд харьцуулах шүүх биологийн шинжилгээнд цогцосноос цөс, шээс, цусыг заавал авах хэрэгтэй.

Бэлгийн харьцаанд орсны хамгийн баталгаат шинж нь жирэмслэх, улмаар бэлгийн харьцаанд орсон байж магадгүй гэх шинжид бэлгийн замын халдварт өвчин илрэх явдал байдаг гэхдээ бэлгийн замын халдварт өвчин нь бусад замаар халдварлагдаж болохыг анхаарах хэрэгтэй.

Шүүх эмнэлгийн шинжилгээгээр охин хальс шинэ гэмтэл урагдалтай байх, эмэгтэйн гадна бэлэг эрхтний орчмоор механик гэмтэл илрэх зэрэг шинжүүд илэрч болно. Зарим тохиолдолд эрэгтэйн гар болон бусад зүйлсээр охин хальс гэмтэж урагдаж болохыг анхаарах хэрэгтэй. Бэлгийн хүчирхийллийн үед хохирогчид сул дорой /хүнд өвчтэй байх, сэтгэцийн өөрчлөлт, хүнд хэлбэрийн согтолт г.м/ байдлын шинж байдаггүйг шинжээч томилох эрх бүхий этгээдүүд тогтоох хэрэгтэй байдаг.

Шулуун гэдсээр хурьцал үйлдсэн гэх тохиолдолд идэвхгүй хамтрагчийн шулуун гэдэсний доод хэсэг юүлүүр хэлбэртэй болох, шулуун гэдэс хошногны амсар суларч ангайх зэрэг шинжүүдийг шинжээч эмч сайтар үзэж хөгшрөлтийн өөрчлөлт, бусад өвчин, эмгэгээс ялган оношлох чадвар эзэмшсэн байхыг шаарддаг.

Иймээс шинжээч томилох эрх бүхий этгээдүүдийн шинжээчид тавих асуултууд, шинжээчийн хийх шүүх эмнэлгийн шинжилгээ нь бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй байх тухай хариуцлагатай үүргийг дээрх субъектүүд хүлээдэг байна.

Бэлгийн хүчирхийллийн үеийн бие махбодид илрэх гэмтэл өөрчлөлтүүдийн онцлог.

Бэлгийн хүчирхийллийн үеийн бие махбодид илрэх гэмтэл өөрчлөлтүүд нь арьсны зулгаралт, шалбаралт, цус хуралт, ховор тохиолдолд шарх зэрэг механик гэмтлийн элементүүдээр илэрдэг.

Гэмтлийн элементүүдийн байрлал нь ихэвчлэн гадна бэлэг эрхтэн, гуя цавь, мөр хүзүү, амны эргэн тойронд, хоёр хөх орчмын зөөлөн эдэд үүссэн байна. Эцэст нь сануулахад биеийн аль ч хэсэгт үүсэж болно.

Шинжээчид дараах асуултыг заавал тавих хэрэгтэй:

- Шинжлүүлэгчийн биеийн хаана нь ямар гэмтэл учирсан бэ?
- Гэмтэл учирсан бол тэр нь ямар хүчин зүйлийн үйлчлэлээр үүсгэгдэж болох?
- Ямар механизм\үйлчлэлээр\-аар уг гэмтэл нь үүссэн бэ?
- Гэмтэл үүссэн хугацааг тогтоох боломжтой эсэх?
- Үүссэн гэмтэл нь ямар шалгуур шинжээрээ гэмтлийн ямар зэрэгт хамаарах?

Бэлгийн хүчирхийллийн үед механик гэмтэл учрахгүйгээр гар болон бэлэг эрхтнээрээ охидын гадна бэлэг эрхтнийг оролдож, цочроосноос улайж хавагнах, идээлж үрэвссэн шинж илэрч болно. Энэ үйлдэл олон дахин давтагдснаас гадна бэлэг эрхтний салст бүрхүүлийн архаг үрэвсэл үүсч болдог.

Жирэмсэн эсэхийг тогтоох

Энэ төрлийн шинжилгээг эх барих-эмэгтэйчүүдийн эмчийн хамт хийж болно. Дааврын ба биологийн урвалаар эрт үед нь оношлох боломжтой. Хожуу үед эх барих эмэгтэйчүүдийн үзлэг болон бусад шинжилгээ\дүрс оношлогоо г.м\-гээр оношилно.

Бэлгийн замын халдварт өвчнийг илрүүлэх.

Бэлгийн замын халдварт өвчнийг илрүүлэх шинжилгээг арьс өнгөний эмчийн хамтаар, тусгай лабораторид өнгөний өвчин илрүүлэх шинжилгээ хийснээр явуулдаг.

Бандидах болон бусад хэлбэрийн хурьцал үйлдэгдсэн гэх үед сэжигтэн буюу холбогдогч этгээдийг шинжлэх үед:

- Хурьцал үйлдэх чадвартай эсэх?
- Тухайн эмэгтэйтэй сүүлийн үед бэлгийн харьцаанд орсон байж болох уу?
- Бие дээр ямар нэгэн гэмтлийн шинж тэмдэг байгаа эсэх? г.м асуултуудыг шинжээчид тавих боломжтой.

Хурьцал үйлдэх үр тогтоох чадвартай эсэхийг тогтоох

Зарим тохиолдолд холбогдогч нь шүүх эмнэлгийн шинжилгээгээр хөгшрөлт болон өвчний улмаас хурьцал үйлдэх чадваргүй болох нь тогтоогдож бэлгийн маргаантай асуудал буюу гэмт хэрэгт холбогдолгүй болдог.

Эрчүүд ихэвчлэн 50-55 наснаас эхлэн бэлгийн сулралд орж эхэлдэг бөгөөд 60-70 насанд бүрэн дарангуйлагддаг гэж үздэг. Ховор тохиолдолд 80 насанд ч хурьцал үйлдэж, үр тогтоох чадвартай байж болно. Иймд шүүх эмнэлгийн шинжилгээний дүгнэлтэд дээрх насны эрчүүдэд эрүүл физиологийн давуу байдлын улмаас хурьцал үйлдэж, үр тогтоох чадвартай гэсэн дүгнэлт гарч болохыг анхаарах хэрэгтэй.

Эрэгтэй хүн хурьцал үйлдэх чадваргүй байх гол шалтгаан нь хэдэн настай байхаас үл хамааран сэтгэц, мэдрэлийн эрхтэн тогтолцоо, биеийн бусад өвчин, эмгэгийн шалтгаантай байж болдог. Иймд энэ төрлийн шүүх эмнэлгийн шинжилгээг сэтгэл зүйч, мэдрэлийн эмч, шээс бэлгийн замын эмгэг судлаач эмч \урологи\, арьс өнгөний эмч зэрэг нарийн мэргэжилтэн оролцуулан хамтарсан шинжилгээ явуулах илүү үр дүнтэй байдаг.

Зарим тохиолдолд эрэгтэйн хурьцал үйлдэх чадваргүй байдал нь гадна бэлэг эрхтний орчмын механик гэмтлийн шалтгаантай байж болдог. Жишээ нь цавины эвэрхий, бэлэг эрхтний төрөлхийн гаж хөгжил, гэмтлийн дараах үлдэц хор уршиг, сорвижилт г.м

Тухайн эмэгтэйтэй хамгийн сүүлд бэлгийн харьцаанд орсон эсэхийг тогтоохын тулд урьд дурдаж байсанчлан жам ёсны, эсвэл бусад байдлаар бэлгийн харьцаанд орсон байж болзошгүй гэдэг үүднээс шүүх биологийн шинжилгээгээр эмэгтэйн үтрээний агууламж, өтгөн, шүлс, умдагны үс, бөс даавууны ширхгийг эрэгтэйн бэлэг эрхтнээс, хумсны завсар, хувцас хэрэглэл дээрээс мөн үтрээний салст шүүрэл, эсийг илрүүлэх шинжилгээг хийлгэж болдог.

Үтрээний эс эрэгтэйн бэлэг эрхтний хөвчин дор 2-3 хоног, угааж цэвэрлээгүй тохиолдолд эрэгтэйн гадна бэлэг эрхтэнд 5 хүртэл хоног задрахгүйгээр бүтцээ хадгалсаар байдаг байна. Хувцас, хэрэглэл, хумсны завсар үтрээний эсүүд удаан хугацаагаар хадгалагддаг, тэр ч байтугай гараа хэд хэдэн удаа угаасны дараа ч эсийн шинжилгээгээр үтрээний эс илэрсэн тохиолдол байдаг байна. Хэрэв шүүх эд эсийн \цитологи\ шинжилгээгээр холбогдогчоос авсан шинжилгээний дээжинд хохирогч эмэгтэйн үтрээний эс болон бусад биологийн гаралтай зүйлс илэрсэн тохиолдолд бэлгийн харьцаанд орсныг баттай нотлох баримт болдог.

Үтрээний шүүрэл, эсийн тусламжтайгаар тухайн эмэгтэйн бүлгийн харьяаллыг тогтоохоос гадна эстроген дааврын шүүрлийн идэвхжлээр нь сарын тэмдгийн мөчлөгийн аль үед бэлгийн харьцаанд орсон байж болохыг ч тогтоодог байна. Үүний нэгэн адил шинжилгээгээр илэрсэн бусад биологийн гаралтай эд мөрийн баримт болох цус, үс, шүлс зэргээр бүлгийн харьяаллыг тогтоож болно.

Ховор тохиолдолд жирэмсэн эмэгтэйд хүчиндсэн эсвэл бэлгийн харьцаанд орсон эсэх асуудлыг тодруулах шаардлага гардаг энэ тохиолдолд шүүх эмнэлгийн шинжилгээ хийлгэхдээ жирэмсэн эмэгтэйтэй бэлгийн харьцаанд орсон уу гэдэг асуултыг тавих хэрэгтэй. Шүүх эмнэлгийн шинжээч нь шинжилгээгээр холбогдогчийн бэлэг эрхтэн болон хувцас /дотуур өмд/ дахь үтрээний шүүрэлд жирэмсэн үеийн гормон болох хорионы гонадотропины дааврын шүүрлийг илрүүлэх нь ач холбогдолтой.

Бэлгийн дур хүслээ гаж хэлбэрээр хангах өөрөөр хэлбэл, шулуун гэдсээр хурьцал үйлдсэн гэж үзвэл холбогдогч этгээдийн гадна бэлэг эрхтэнд өтгөн түүний элементүүд болох ялзлагч бичил биетний өндөг, шулуун гэдэсний салст бүрхэвчийн эс, гэдэсний хэвийн бичил биетүүд, хэрэв амаар үйлдэгдсэн гэх тохиолдолд шүлсний ферментүүд, амны хөндийн хэвийн бичил биетнийг илрүүлэх шинжилгээ хийж тогтоох боломжтой.

Дээрх шинжилгээнүүд нь нотолгооны чухал ач холбогдолтой хэдий ч цаг хугацааны эрхээр, эсвэл зориудаар ул мөрийг арилгаж устгаснаар шинжилгээний дээж үгүй болж шинжилгээ хийх боломжгүй болох нь бэлгийн харьцаанд орсныг үгүйсгэх шалтгаан болохгүй.

Санал: Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн үед хэргийн бодит үнэнийг олж, гэмт хэргийг богино хугацаанд илрүүлэхэд шинжээч томилох эрх бүхий этгээдүүд цаг алдалгүй шинжилгээ хийлгэх тогтоол үйлдэж, хэргийн мөн чанарт тохирсон үндэслэл бүхий асуултуудыг оновчтой сонгож шүүхийн шинжилгээ хийлгэх явдал юм. Улмаар шинжээч томилсон этгээд нь шүүх эмнэлэг, шүүх биологийн шинжээчийн шинжилгээ хийсэн акт, түүний дүгнэлтийн хэсгийг уншиж ойлгосноор, түүнд тулгуурласан хэрэгт ач холбогдол бүхий үнэлэлт өгөх нь гэмт хэргийг мөрдөхөд ач холбогдолтой байх болно.

МӨР БИТҮҮМЖЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт нь аливаа гэмт хэргийг бүрэн илрүүлж гэмт этгээдийг олж тогтоох гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангахад оршино гэсэн зорилтыг хэрэгжүүлэхэд мөрийг бүрэн дүүрэн ашиглах ёстой.

Үүний тулд криминалистикийн шинжлэх ухааны ололт амжилтыг сайтар танин мэдэж, энэ салбарт мэргэшсэн өндөр ур чадвартай мэргэжилтэн албан хаагчдыг олноор нь бэлтгэн гаргасны үр дүнд цаг алдахгүй илрүүлэх, гэмт этгээдийн үйлдэл, санаа бодлыг таслан зогсоох хамгийн оновчтой арга зам болно гэж үзэж байна.

Мөр судлал нь дараах байдлаар хөгжиж ирсэн байдаг.

1. Хүний мөр судлал
2. Эвдлэгч багаж хэрэгсэл үйлдвэрийн механизмын мөр судлал
3. Тээврийн хэрэгслийн мөр судлал
4. Үнэрийн мөр судлал
5. Мал амьтан судлал
6. Галт зэвсэг, буудлагын улмаас үүссэн мөр судлал

Учир нь мөр судлах нь бусад хэргийн газраас илрүүлсэн мөртэй адилтгах зэрэг онолын болон практик ач холбогдолтой энэ гэмт хэргийг бүрэн дүүрэн илрүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Мөрийг судлах, мөрөөс мэдээлэл олж авах /унших/ нь гэмт үйлдлийг, гэмт хэрэгтнийг танин мэдэх гол арга мөн. Нотолгооны хүрээнд эд мөрийн баримтын ач холбогдол улам бүр нэмэгдэх нь зүй ёсны хэрэг⁷⁶ бөгөөд эрх зүйн зөрчлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, хуулийн дагуу илчлэн нотлож байгаа нь байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөөг хангаж буй бодит механизм болох юм. Иймээс практикт гэмт хэрэг түүнийг үйлдсэн этгээдийг мөрөөр нь нотлох ажил чухал байр суурь эзэлдэг.

Криминалистикийн буюу «шинжлэн магадлахуйн судлал нь орчин үед өөрийн гэсэн онол, судлах зүйл, арга зүй бүхий бие даасан шинжлэх ухаан болсон»⁷⁷ гэж эрдэмтэн, судлаачид баталсан байдаг. Мөртэй ажиллахад дараахь үе шатуудыг баримталж ажилладаг. Үүнээс хэргийн газраас хурааж авсан биет эд мөрийн баримтыг битүүмжлэхэд практикт алдаа гарсаар байна.

Мөртэй ажиллах үе шат

Мөр эрэх	Гэмт хэргийн орчин, үйл явдал, гэрч, хохирогчийн мэдүүлэг, мөр тодорхойлох арга хэрэгслийн тусламжтайгаар идэвхтэй хайх шат.
Мөр тодорхойлох	Гэмт хэргийн газарт буй энгийн нүдэнд үл харагдах мөрийг хэрэгт хамааралтай болохыг тогтоож, дугаарлах, ялгаж ангилах зэргээр мөшгөхөд бэлтгэх үе шат.
Мөр унших	Мөр үүссэн явц зүйг задлан шинжлэх замаар гэмт хэрэгтний биеийн\анатом\ сэтгэл зүйн \психологи\ үйлдлийн шинж байдлын

⁷⁶ Эд мөрийн баримт сэтгүүл. Редакторын үг. Ж.Бямбаа. ХЗҮТ. 5 тал

⁷⁷ Н.П.Майлис., Моя профессия-судебный эксперт., Москва., 2006. 10 дахь тал.

	талаар мөр шинжлэх шат.
Мөр мөшгих	Гэмт хэрэгтний явсан чиглэл, үйлдлийг тодорхойлох зорилгоор цуваа мөрийг шинжин дагах шат.
Мөр хүлээлгэн өгөх	Мөр мөшгих явцад уг мөр нь хамгаалалттай зурвас бүс болон хилийн шугам руу нэвтрэн орсон бол эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч үргэлжлүүлэн мөшгүүлэх шат.
Мөр бэхжүүлэх	Мөрийн шинж тэмдэг, шинж чанарыг хэвээр нь хадгалж үлдээхийн тулд хамгаалах, баталгаажуулах хэрэгсэл ашиглах шат.
Мөр тусгаарлах	Эрүүгийн хэрэгт хавсаргах улмаар шинжлэх зорилгоор мөр тээгч объектоос салгаж, ижил төрлийн мөрүүдээс ялгаж авах үе шат. Энэ зорилгоор тусгай хэрэгсэл ашиглагдана.
Мөр савлах	Мөрийн төрөл, шинж чанар түүнийг бэхжүүлсэн арга, барилаас хамааран зориулалтын хайрцаг, сав дугтуйнд байрлах шат.
Мөр битүүмжлэх шат	Мөрийг савласны дараа нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүй байх, үрэгдэж гээгдэхээс сэргийлэх зорилгоор хаяглах, лацдах
Мөр зөөвөрлөх	Мөрийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байх зорилгоор хэргийн газраас шилжүүлэн тээвэрлэх ажиллагааг хэлнэ.
Мөр хадгалах	Адилтгагч объект тодорхой бус байгаа үед аргачлалын дагуу битүүмжлэн хадгалах, эсхүл бүртгэлд авч хадгалах үе шат.
Мөр шинжлэх	Адилтгалын болон оношилгооны шинжтэй асуудлыг шинжлэхийн тулд нотолгооны хэрэгсэл болгон ашиглах шат.
Мөр ашиглах	Байцаан шийтгэх ба шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад нотлох баримтыг дэлгэц үзүүлэх замаар нотолгооны хэрэгслийг ашиглах шат.
Ийнхүү мөрөнд үзлэг хийх, мөрийг үнэлэх, мөр хамгаалах, үйл явц нь дээр дурдсан үйлдэл, мөртэй ажиллах шат бүхэнд хэрэгжинэ.	

Хууль сахиулахын их сургуулийн Цагдаагийн сургуулийн Шинжлэн магадлахуйн тэнхимийн Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил мэргэжлээр төгсөх 346 дугаар дамжаа Нийслэлийн Шүүхийн шинжилгээний албадуудад хэргийн газрын үзлэгээр дадлага хийсэн 22 сонсогчдын дунд санал асуулгын хуудас бөглүүлэн судалгаа хийж үзэхэд хэргийн газраас илрүүлж, бэхжүүлж авсан мөрийг битүүмжлэх ажиллагаанд архины шил, хутга,



биологийн гаралтай мөр эд, мөр бодисыг битүүмжлэх ажиллагаанууд, мөр битүүмжлэх техник хэрэгслүүдийн судалгааг авлаа.

Үр дүн: Эхний диаграммаас харахад хангалтгүй нь 69% буюу нийт судалгаанд оролцсон 22


хүнээс 12 нь сонгосон байна. 31% буюу 10 хүн дунд гэсэн байна.



Үр дүн: 2 дахь диаграммаас харахад хангалтгүй нь 49% буюу нийт судалгаанд оролцсон 22 хүнээс 6 нь сонгосон байна.

26% буюу 13 хүн дунд, 25% буюу 3 хүн сайн гэсэн байна.

Биологийн гаралтай мөр бодисыг хэрхэн битүүмжилж байна вэ.




Үр дүн: 3 дахь диаграммаас харахад хангалтгүй нь 36% буюу нийт судалгаанд оролцсон 22 хүнээс 8 нь сонгосон байна. 50% буюу 11 хүн дунд, 14% буюу 3 хүн сайн гэсэн байна.

Битүүмжилсэн эд зүйлийг зөв хаяглаж байгаа эсэх



Үр дүн: 4 дахь диаграммаас харахад хангалтгүй нь 29% буюу нийт судалгаанд оролцсон 22 хүнээс 2 нь сонгосон байна. 39% буюу 11 хүн дунд, 32% буюу 9 хүн сайн гэсэн байна.

Битүүмжлэх техник хэрэгсэл байгаа эсэх



Үр дүн: 5 дахь диаграммаас харахад хангалтгүй нь 50% буюу нийт судалгаанд оролцсон 22 хүнээс 11 нь сонгосон байна. 41% буюу 10 хүн дунд, 9% буюу 2 хүн сайн гэсэн байна.

Судалгаанаас харахад мөр битүүмжлэх ажиллагаанаас

мөр хаягтай байх зарчим үр дүнтэй, харин бусад сав баглаа боодолтой байх, лац ломботой байх зарчмууд практикт хангалтгүй байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд хүргэгдэж байгаа биологийн гаралтай биет эд мөрийн баримтууд сав баглаа боодлын битүүмжлэл гялгар ууттай ирэх үүнээсээ болоод нойтон бохирлогдсон зүйлүүд муудах, шинжилгээний шаардлага хангахгүй хуулийн байгууллагын хооронд үл ойлголцох /шинжилгээнд үл мөрүүд тэнцэхгүй/ байдал үүсч байна. Мөн архины шилэнд нь шингэн зүйл байж, зөөвөрлөх явцад асгарах зэрэг үүнээс үүдэн шилний гадаргуйд байсан гарын мөрүүд устдаг. Архины шил, хутга зэрэг бусад зүйлүүдийг гялгар уут, тор гэх сав баглаа, боодолд хийсээр байна.

Мөр битүүмжлэх гэдэг нь мөрний нотолгооны ач холбогдлыг хангах, аливаа эрсдлээс сэргийлэх зорилгоор хамгаалахыг хэлнэ.⁷⁸ Хууль сахиулагч, шинжээч, мэргэжилтэн, эрүүгийн төлөөлөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгч нараас мөртэй ажиллахдаа заавал баримтлах зан үйлийн чиг шугамыг мөртэй ажиллах зарчим гэнэ. Мөртэй ажиллах зарчмыг баримтлахгүй бол уг мөр нь гэмт хэрэг илрүүлэх нотолгооны ач холбогдлоо алддаг. Тиймээс мөр битүүмжлэхэд дараах зарчмыг баримтална.

1. Савлах. Мөрийг түүний шинж чанарт тохирсон зориулалтын болон ахуйн хэрэглээний хайрцаг, сав боодолд хийх бөгөөд зөв савлаагүйгээс болж мөр нотолгооны ач холбогдлоо алдах аюултай.

⁷⁸Б.Лхагвасүрэн. Мөр. УБ хот., 2015, 36 дугаар тал

2. Хаяглах. Мөрний төрөл, ангиллыг ялган таних, өөр хэргийн газраас илрүүлэн мөртэй солихоос сэргийлэх, мөр зөөвөрлөх, хадгалах, зэрэгт ашиглах зорилгоор мөрний сав дээр тэмдэглэл бичихийг ойлгоно.

Мөр илрүүлсэн он сар өдөр / огноо / 2015 оны 10 дугаар сарын 26 өдөр
Хаана, хэргийн өнгө Жнь: БЗД-н 1 хорооны нутаг дэвсгэрт байрлах Алтайн 1-2 тоотод хүний амь нас хохирсон хэргийн газар
Мөрний төрөл, онцлог Жнь: хашааны үүднээс урагш 2 метрийн зайд баруун хөлийн 29х12 см хэмжээтэй гутлын улны мөр дүрсний хажуунаас хурааж авсан архины шил 1 ширхэг
Мөрний тоо ширхэг: Битүүмжилж авсан архины шил 1 ширхэг
Мөр битүүмжилсэн: албан тушаалтан: цол, гарын үсэг, нэр, огноо
Мөр зөөвөрлөх явцад анхаарах таних тэмдэг:  дээш харсан сум тавибал, доош харуулж болохгүй,  цахилгааны зураг байвал электрон бараа, шүхэр, шилэн аяга, аюултай бодис /ууршимтгай/ нийтийн галт тэрэг, онгоцонд ачихийг хориглоно гэсэн тэмдэгтүүдийг харуулсан зургийг наан байршуулна.

3. Лацдах. Мөрийг савнаас нь авах, солих устгах зэргээс сэргийлэн тусгай тэмдэглэгээ хийх, савны амсар тагийг бэхэлж, лац, ломбо тавина.

Дүгнэлт

- Практик байгууллагуудад мөр битүүмжлэх зориулалтын сав баглаа боодлыг хийж нийлүүлдэг байгууллагууд байдаггүй.
- Цус болон бусад биологийн гаралтай мөр бодис, хувцсыг тасалгааны температурт хатаах, өрөө тасалгаа, хайрцаг сав байхгүй байна.
- Харин шинжилгээ томилдог эрх бүхий этгээдүүд мөртэй холбоотой зүйлийг битүүмжлэхдээ сав баглаа боодолд анхаарахгүй байна. Шинжилгээнд хүргэгдэж байвал хамаагүй мэтээр ойлгож, хэргийн илрүүлэлтэнд нөлөөлнө гэдгийг ойлгохгүй байна.
- Гар доорх ахуйн хэрэглээний сав баглаа боодлыг мөр, эд мөрийн баримтыг битүүмжлэхдээ тогтмол ашиглах, хэвших.
- Нойтон шингэн цустай зүйлийг хатаасны дараа цаасан хайрцаг саванд хийх. Хэрхэвч гялгар уутанд хийхгүй байхыг сануулж байна.

ШҮҮХ СЭТГЭЦ ГЭМ СУДЛАЛЫН ШИНЖИЛГЭЭ НОТЛОХ БАРИМТЫН ЭХ СУРВАЛЖ БОЛОХ НЬ

Товч агуулга: Шүүх сэтгэц гэм судлалын шинжилгээг гэмт хэргийн нотлох баримт болгож байсан түүх, шүүх сэтгэц гэм судлалын магадлагаа хийлгэсэн тайлан мэдээ, хууль сахиулах болон эрх зүйн чиглэлээр сургалт явуулж байгаа их, дээд сургуулиудад шүүх сэтгэц гэм судлал хичээлийг судалж байгаа өнөөгийн байдалд судалгаа хийж, зөвлөмж боловсруулсан.

Түлхүүр үг: Шүүх сэтгэц гэм судлал, анагаах ухаан, хууль зүйн ухаан

Шүүх сэтгэц гэм судлал гэдэг нь эрүүгийн хийгээд иргэний хэрэгт холбогдсон хүмүүсийн сэтгэцийн байдалд дүгнэлт гаргадаг анагаах ухааны салбар, хууль зүйн ухааны хавсарга шинжлэх ухаан мөн. Зарим шинжээч, хуульчид хэрэг хариуцах чадваргүй байдлыг тодорхойлдог **цорын ганц** салбар шинжлэх ухаан гэж онцолдог.

Монгол Улсад анх хэрэг хариуцах чадваргүй байдлыг 1926 онд Шүүх цаазын бичгийн гуравдугаар бүлэгт “Ял үл хэлэлцэх нь” хэмээн тайлбарласан байдаг. Манай улсад шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагааг анх 1947 онд хийжээ⁷⁹. Гэтэл 1926 онд хуульчилснаас үзвэл, 1947 оноос өмнө шүүх сэтгэц эмгэг судлалын магадлагааг хийж байсан эсвэл хэрэгт холбогдогчийн сэтгэцийн байдлын талаар нотлох баримт байсан болох нь нотлогдож байна. Албан ёсны шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээг хийх комисс 1954 онд байгуулагджээ⁸⁰. Үүнээс хойш жил ирэх бүр шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээг хийлгэх тохиолдол нэмэгдсээр байна.



Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тайлангаас үзвэл, шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын магадлан шинжилгээ хийлгэсэн нийт 5889 шинжлүүлэгчийн 33.16% нь буюу 1953 нь сэтгэцийн ямар нэгэн эмгэгтэй. Эдгээрээс 99.04% нь эрүүгийн хэргийн улмаас, 0.837% нь иргэний хэргийн улмаас магадлан шинжилгээ хийлгэсэн байна. Мөн төвийн тайланд 2012 онд 1513 хүн шүүх сэтгэц гэм судлалын шинжилгээ хийлгэснээс 82 хүн хэрэг хариуцах чадваргүй гэсэн дүгнэлт үйлдэгджээ⁸¹.

Судлаач Д.Лянхуа, Т.Ганцэцэг нарын үзэж байгаагаар, 1998-2006 онд стационараар магадлагаа хийлгэсэн болон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан 132

⁷⁹ С.Бямбасүрэн, Ш.Доржжадамба.Шүүх сэтгэц гэм судлал. УБ., 1990. 9 дэх тал

⁸⁰ Мөн тэнд. 9 дэх тал

⁸¹ СЭМҮТ-ийн тайлан 2012.

эмчлүүлэгчдийн 35 нь стационараар магадлан шинжилгээ хийлгэсэн, 97 нь амбулаторийн нөхцөлд шинжилгээ хийлгэжээ. Энэ хугацаанд эрүү болон иргэний хэрэгт холбогдолтой бүхий л хэргийг амбулаторийн хэлбэрээр шийдсэн байна.

3.Хишигсүрэн, Л.Мөнхтуяа, С.Одонгэрэл нарын (2008) сүүлийн 10 жилийн хугацаанд СЭМҮТ-ийн хуулийн тасагт хэвтэн эмчлүүлэгсдийн байдалд хийсэн судалгааны дүнгээс зонхилох хувийг эрэгтэйчүүд эзэлж, насны бүлгээр үзвэл 76.6%-ийг 20-39 насны хүмүүс, харин 32.2% нь бага боловсролтой буюу боловсролгүй хүмүүс, өвчтөнүүдийн үйлдсэн нийгэмд аюултай үйлдлийн хэлбэрийг авч үзвэл танхайрах болон бусдын эрүүл мэнд, амь насанд халдах байдал хамгийн их буюу 53.5%-ийг эзэлж байна⁸².

Монгол Улсын ЭБШХ-ийн 156 зүйлийн 1.6 дахь хэсэгт онц хүнд гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлох⁸³ гэж заасан байна.

Дээрх баримтаас харахад, шүүх сэтгэц гэм судлалын шинжилгээ нь Монгол Улсын хуульд заасан чухал шинжлэн магадлахуйн төрөл бөгөөд гэмт хэргийг шинжлэх ухааны үндэслэлтэй мөрдөх, шүүн таслах үйл ажиллагааг явуулах нотлох баримт болж байна. Монгол Улсын ЭБШХ-ийн 85.4. Шинжээчийн дүгнэлтийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх заавал баримтлах үүрэггүй боловч дүгнэлтийг зөвшөөрөхгүй байгаа бол үндэслэлээ заасан байвал зохино⁸⁴ гэж хуульчилсан байгаагаас үзэхэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч зэрэг эрх бүхий этгээд шүүх сэтгэц гэм судлалын талаарх мэдлэг дутмаг байдал нь онц хүнд гэмт хэрэгтнийг байцаах, яллах тал дээр шүүх сэтгэц гэм судлалын шинжээчийн бүрэн хараат байдалд орохыг харуулж байна.

Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжээч нартай уулзаж ярилцахад хуульч, өмгөөлөгч, мөрдөн байцаагчид тус шинжилгээний талаар мэдлэг дутмаг байдал нь шинжээч ажлаа хийхэд хүндрэл учирдаг байна. Жишээлбэл, Шүүх сэтгэц гэм судлалын шинжилгээгээр шийдэх боломжгүй, ямар нэгэн ач холбогдолгүй, санаа давхцсан асуулт тавих, шинжилгээ хийлгэх үндэслэл тодорхой бус, үндэслэл, шаардлагагүй шинжилгээг давтан хийлгэх байдал байнга гардаг байна. Гэтэл Хууль сахиулахын их сургуульд Шүүх сэтгэц эмгэг судлал, Шүүх эмнэлгийн орон тооны багш батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээл орж байна. Үүнээс бусад Монгол улсын томоохон Улсын болоод хувийн их, дээд сургуулиудад “Шүүх сэтгэц гэм судлал” хичээлийг үндсэн хичээлээр судалдаггүй төдийгүй батлуулсан Шүүх сэтгэц гэм судлал хичээлийн хөтөлбөр байдаггүй байна.

Иймд хуульч, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагын ажилтнууд шүүх сэтгэц гэм судлалын шинжилгээнд мэргэжлийн зүгээс үнэлэлт өгөх шаардлагатай байгааг харуулж байгаа төдийгүй, шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээг гэмт хэргийн чухал нотлох баримт болж байна.

Дүгнэлт

Хэрэг хариуцах чадваргүй байдлын тухай 1926 оны Шүүх цаазын бичигт анх хуульчилсан, Шүүх сэтгэц гэм судлалын магадлагааг 1947 онд хийсэн, албан ёсны Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжилгээг хийх комисс 1954 онд байгуулагдсан, СЭМҮТ-ийн тайланд Шүүх сэтгэц гэм судлалын магадлагааг хийлгэх тохиолдол жилээс жилд нэмэгдэж байгаа, Монгол Улсын ЭБШХ, Эрүүгийн хуульд заасан шүүх сэтгэц гэм судлалтай холбоотой заалтууд зэрэг нь шүүх сэтгэц гэм судлалын магадлагааг гэмт хэргийн чухал нотлох баримт гэж дүгнэхэд хүргэж байна.

Санал

⁸² Гэмт хэрэгтэй тэмцэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын үүрэг, хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. 2014

⁸³ Төрийн мэдээлэл эмхтгэл., 2002. №6

⁸⁴ Мөн тэнд

1. Шүүх сэтгэц гэм судлалын түүхийг баримтад тулгуурлан нарийвчлан судлах.
2. Хуульч, өмгөөлөгч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын шүүх сэтгэц гэм судлалын талаарх мэдлэгийн түвшинг тодорхойлох.
3. Улсын болоод хувийн их, дээд сургуулиудад Шүүх сэтгэц гэм судлал хичээлийг баталсан хөтөлбөрийн дагуу судлуулах.

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



Б.Баянмөнх

*ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор,
цагдаагийн хошууч*

ТЕРРОРИЗМТАЙ ТЭМЦЭХ ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Терроризм нь даяаршиж байгаа нийгмийн аюулт үзэгдлийн нэг болох нь дэлхийн улсуудад үйлдэгдэж байгаа террорист халдлагуудын тоо, давтамж, учруулж буй хохирлын хэмжээ харуулж байна.

Терроризм⁸⁵ нь үзэл сурталжсан хүчирхийлэл дээр үндэслэсэн системтэйгээр хэрэглэгддэг, тэмцлийн хурц, сөрөг арга хэлбэр бөгөөд улс төрийн зорилго бүхий алан хядах бодлого, үйл ажиллагааг нэгтгэн илэрхийлж буй ойлголт юм.

Өнөөдөр өрнөдийн орнууд терроризмтой хийх тэмцэлд ердийн тэсрэх бодисоос эхлэн үй олноор хөнөөх зэвсгийг ашиглахаас гадна шинжлэх ухааны, технологийн сүүлийн үеийн шинэ ололтуудыг ашиглах явдал нэмэгдэх хандлагатай байна.

Үүний нэг нь хүний далд ухамсар, сэтгэцэд зайнаас нөлөөлөх арга, технологи буюу психотроны хэмээх шинэ зэвсэг бөгөөд шинэ зуунд хамгийн аюултай зэвсэг хэмээн нэрлэгдэж байна. Түүнчлэн, террористууд айлгах, сүрдүүлэх, хуурах, итгүүлэх, дарамтлах, барьцаалах зэрэг хүний оюун санаа, сэтгэл зүйд нөлөөлөх замаар зэвсэгт тэмцлийн бүхий л аргыг өргөнөөр хэрэглэж байгаа нь нийгмийн аюулт үзэгдлийн хор аюулын хэр хэмжээг улам нэмэгдүүлэх хандлагатайг харуулж байна.

Монгол Улс дэлхийн 2 том хүчирхэг гүрний дунд оршдог, терроризмын аюул нүүрлээгүй дэлхийн цөөн улсуудын нэг боловч өнөөдөр хоёр хөрш оронд маань террорист халдлага удаа дараа үйлдэгдэж, тэдэнтэй тэмцэл улам бүр нэмэгдэх хандлагатай болсоор байна.

Бид өнөөдөр террорист халдлага, түүний учруулсан хор аюулын талаарх мэдээллийг Ойрхи Дорнод, Өмнөд Азид болж буй үйл явдлаар төсөөлөн ойлгодог байсан бол өнөөдөр хөгжил дэвшил бүхий Баруун Европ, АНУ, манай хойд, урд хөршид гарч байгаа нь терроризм өөрөө даяарших хэлбэрт хэдийнээ шилжин орсонтой холбоотой.

Бүх төрлийн терроризмын үндсэн зарчим нь нэгдмэл, хүчирхийлэлд суурилсан, ертөнцийг үзэх үзэл, ёс суртахуун, улс төрийн үзэл бодол, бодлого мөн бөгөөд иргэд, олон

⁸⁵ Терроризмтой тэмцэх тухай хуулийн 3.1.1-д “Терроризм” гэж хууль бус зэвсэгт бүлэглэл, террорист этгээд өөрийн улс төр, шашин, үзэл суртлын зорилгодоо хүрэхийн тулд нийгмийг, эсхүл түүний тодорхой хэсгийг айдаст автуулахаар иргэдийн амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж буй харгис хүчирхийлэл, хүчирхийлэхээр заналхийлэх, гамшгийн нөхцлийг бүрдүүлэх ажиллагааг;

нийтийг алах, алахаар заналхийлэх, айлган сүрдүүлэх зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зорилгодоо хүрэх гол хэрэгсэл болгон сонгосонд оршиж байна.

Терроризмын зорилго нь нийгмийн тогтолцооны аюулгүй байдлыг алдагдуулах, иргэд, олон нийтийг айлган сүрдүүлэх арга хэрэгслийг ашиглан хүсэл зорилгоо гүйцэтгүүлэх явдал юм.

Бид юуны өмнө аливаа террорист халдлага аюул заналыг зэргэлдээ орнуудад болж буй үйл явдал, тэдний гадаад шинж төрх байдал, олон улс орныг хамрах хүрээ, далайц зэрэгт дүгнэлт хийж, улс орны хил хязгаарыг нэвтрэн орж ирж болзошгүй нөхцөлд хариу арга хэмжээг цаг алдалгүй авахад бэлэн байж, дотооддоо нэн сонор сэрэмжтэй, аюулыг урьдчилан сэргийлэх, илрүүлэхэд хууль сахиулах байгууллагуудаас гадна олон нийт өндөр мэдрэмжтэй, сонор сэрэмжтэй байхыг цаг үе зүй ёсоор сануулж байна. Түүнчлэн, хөрш орнуудад болж буй террорист халдлагатай холбоотой гарч буй үйл явдлыг байнга ажиглаж, холбогдох урьдчилан сэргийлэх арга хэмжээг байнга авч байх шаардлагатай болж байна.

Терроризмтой тэмцэх, терроризмын эсрэг дэлхийн улс орнуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр олон улсын нийтлэг эрх зүйн 19 баримт бичиг байдгаас өнөөгийн байдлаар 13-д нь манай улс 1971 оноос хойш нэгдэн орсон нь терроризмтой тэмцэх асуудлыг төрийн бодлогын хэмжээнд олон жилийн турш авч хэрэгжүүлж ирсний тод илрэл юм.⁸⁶

Нөгөө талаараа, Монгол Улс Терроризмын эсрэг олон улсын гэрээ, конвенц, протоколд нэгдэн орсноор дэлхийн улс орны өмнө олон талт үүрэг хүлээж байгаа бөгөөд дээрх олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг хэрэгжүүлэхэд олон улсын болон бусад орны байгууллагатай хамтран ажиллах хэлбэрийг зөв оновчтой, үр дүнтэй сонгож ажиллах шаардлагатай болж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2004 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр терроризмтой тэмцэх тухай хуулийг батлан гаргаснаар терроризмын эсрэг үйл ажиллагаа явуулах үндэсний эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн төдийгүй 2013-2014 онд Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Терроризмтой тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар терроризмтой тэмцэхэд чиглэсэн эрх зүйн тогтолцоогоо бэхжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар нь терроризмоос сэргийлэх ажлыг удирдах үндсэн субъект бөгөөд хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүргийг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл хүлээдэг.

Терроризмтой тэмцэх тухай хуулийн 6.3 “Үндэсний аюулгүй байдлын тухай хууль⁸⁷-д заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын терроризмоос сэргийлэх талаар мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тагнуулын төв байгууллагын даргаар ахлуулан байгуулж ажиллуулна⁸⁸” гэж зохицуулж өгсөн билээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2004 оны 12 дугаар сарын 147 тоот захирамжаар Терроризмоос сэргийлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийг Тагнуулын ерөнхий газрын дарга ахлан 16 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна.

Терроризмын аюулыг гарсан хойно нь тэмцэж, үйлдсэн этгээдийг илрүүлэхдээ бус харин терроризмын үндсэн суурь нөхцөл бүрэлдэн тогтохоос өмнө, гарч болох бүхий л шалтгаан нөхцлийг арилгах чиглэлээр цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг болоод байна.

⁸⁶ Олон улсын терроризм ба аюулгүй байдал. ЭШБХ-ийн эмхтгэл. УБ. 2015. 18 дахь тал

⁸⁷ Төрийн мэдээлэл. 2002. №3

⁸⁸ Төрийн мэдээлэл. 2004. №19

Тиймээс бид терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг өргөн цар хүрээтэй, үр дүнтэй арга хэлбэрийг сонгон авч хэрэгжүүлэх, гүйцэтгэх байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны арга зүйг сайжруулж, эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, тусгай чиг үүргийн байгууллагуудын харилцан, хамтын ажиллагааны цар хүрээг улам нэмэгдүүлэх, бэлтгэл сургуулилтыг чанартай хийж гүйцэтгэх шаардлага тулгараад байна.

Өнөөдөр цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд оролцох эрх зүйн үндэс нь дараах байдлаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дүгээр зүйл /Олон нийтийн аюулгүй байдлыг хангах/-ийн 11.1.3. нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах⁸⁹;
- Терроризмтэй тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйл /Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох байгууллагын хүч хэрэгсэл/-ийн 10.1.1.цагдаагийн төв, орон нутгийн байгууллага⁹⁰;

Мөн Терроризмтой тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан терроризмоос сэргийлэх арга хэмжээний үндсэн чиглэл дотор цагдаагийн байгууллагын шууд гүйцэтгэх үүрэгт хамаарахуйц дараах хэд хэдэн чиглэл байна. Тухайлбал:

- Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох цэрэг, тагнуул, цагдаагийн салбар, нэгжийг тусгайлан байгуулах, эсхүл томилох, тэдгээрийн үүрэг гүйцэтгэх бэлтгэл, чадавх, бэлэн байдлыг хангах;
- Иргэдийн аюулгүй байдал, эд хөрөнгийг болзошгүй террорист үйлдлээс сэргийлэх, хамгаалах;
- Галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хими, биологи /бактериологи/-ийн болон хүчтэй үйлчлэх хорт бодисыг террорист үйлдэлд ашиглахаас сэргийлэх;
- Төрийн байгууллага, эдийн засгийн дэд бүтцийн барилга, байгууламж болон соёл, олон нийтийн үйлчилгээний чухал газруудыг террорист үйлдлээс сэргийлэн хамгаалах;
- Террорист үйлдэлд өртөх эрсдэлийг бууруулах, үүдэн гарах хор уршиг, хохирлыг багасгахад чиглэгдсэн арга хэмжээг урьдчилан авах;
- Бусад улс, тэдний хууль сахиулах байгууллага, тусгай албад, олон улсын холбогдох байгууллагатай терроризмоос сэргийлэх, террорист үйлдлээс сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах.

Харин цагдаагийн байгууллагын хуулиар хүлээсэн бүхий л үүргийг хэрэгжүүлж байдаг нэгж бол цагдаагийн хэсэг билээ. Харин цагдаагийн байгууллагын үндсэн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг ард иргэдийн дунд зохион байгуулах гол үндсэн албан тушаалтан бол хэсгийн байцаагч юм.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаанд хамгийн их ашиглагдаж байгаа хуулиудыг дурдвал:

- Цагдаагийн албаны тухай хууль;
- Эрүүгийн хууль;
- Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль;
- Захиргааны хариуцлагын тухай хууль;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль;
- Галт зэвсгийн тухай хууль;

⁸⁹ Төрийн мэдээлэл. 2013. №29

⁹⁰ Төрийн мэдээлэл. 2002. №3

- Тамхины хяналтын тухай хууль;
- Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Садар самуунтай тэмцэх тухай хууль;

Харин хэсгийн байцаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа “Хэсгийн , байцаагчийн ажлын заавар”, “Цагдаагийн байгууллагын үйлчилгээний стандарт”, “Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” болон цагдаагийн төв болон нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэр, эрх зүйн актуудыг ашиглаж байна.

Цагдаагийн хэсгийн байцаагч нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2003 оны 229 дугаар тушаалаар батлагдсан “Хэсгийн байцаагчийн ажлын заавар”-аар дараах 33 чиглэлийн үүрэг гүйцэтгэж байна. Тухайлбал,

- Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр – 7
- Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр – 13
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр – 8
- Цагдаа-олон нийтийн хамтын ажиллагааны чиглэлээр – 5

Гэтэл өнөөдөр цагдаагийн хэсгийн байцаагч террорист халдлага үйлдэгдсэн бүс, нутаг дэвсгэрт очоод ямар журмаар, хэрхэн яаж гүйцэтгэх нь тодорхойгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод байна.

Нөгөө талаараа цагдаагийн хэсгийн байцаагчийн терроризмын талаарх мэдлэг харьцангуй бага түвшинд байгаа нь учирч болох эрсдэлийг улам нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна.

Терроризмтой тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хэсгийн байцаагчийн объектын судалгаа маш чухал үүрэгтэй.

Учир нь хэсгийн байцаагч нь өөрийн хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, тэнд байрлах байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хүн амын суурьшил, байршил, амьдралын түвшин болон үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг нарийн судалж шинжилж, дүгнэлт өгч, ажлаа зохион байгуулдаг. Түүнчлэн, хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ үйлдэгдсэн гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэх, эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг судлах, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд хөрөнгийг олох чиглэлээр биечилсэн судалгаа хийдэг бөгөөд ингэснээр оршин суугчдынхаа зан заншлын онцлогийг нарийн судалж мэдэх боломж давхар бүрддэг байна.

Өнөөдөр хэсгийн байцаагч 15 чиглэлийн объектын судалгааг зааврын дагуу хийдэг бөгөөд үүнийг чанартай сайн хийх нь терроризмтой тэмцэх үндсэн суурь нөхцөл болно гэдгийг анхаарах шаардлагатай.

Ялангуяа террорист халдлага үйлдэж болзошгүй, эсхүл терроризмын нөлөөнд өртөж, террорист байгууллагад олзлогдож болох этгээдүүдийн талаарх субъектын судалгааг хэсгийн байцаагч хийдэг тул терроризмын эсрэг тэмцэлд ихээхэн чухал үүрэгтэй байна.

Террорист халдлага үйлдэж болзошгүй этгээдэд дараах хүмүүс хамаарна гэж үзэж болно. Тухайлбал,


- Архаг архичид;
- Гадаадын иргэн, харъяалалгүй хүн;
- Гэмт хэрэгт холбогдож болзошгүй хүмүүс;
- Насанд хүрээгүй хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд татан оруулагч хүн;
- Мансууруулах бодис худалдан борлуулдаг этгээд;
- Согтуурах, мансуурах донтой өвчтэй иргэн;
- Сэтгэл мэдрэлийн өвчтэй хүн;

- Сургууль завсардсан хүүхэд;
- Тэнэмэл, оршин суух хаяг нь тодорхойгүй, хүүхэд, насанд хүрэгчид;
- Шашны үзэл номлолд хэт итгэгчид;
- Гэмт хэрэг үйлдсэний улмаас ял эдлээд тодорхой хугацаанд цагдаагийн байгууллагаас тавих захиргааны хяналтад байгаа хүмүүс гэх мэт;


Тиймээс цагдаагийн хэсгийн байцаагч терроризмтой тэмцэх үйл ажиллагаанд ихээхэн чухал үүрэгтэй оролцдог болох нь харагдаж байна.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, тэр дундаа хэсгийн байцаагчийн терроризмтой тэмцэх ажлын түвшин, чадавхийг тогтоох зорилгоор Баянзүрх дүүргийн цагдаагийн I, II хэлтсийн 11 хэсгийн байцаагчаас хэсэгчилсэн байдлаар анкет асуулгын аргаар судалгаа авч үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Тухайлбал,

Та терроризмын аюулын талаар хэр мэдэх бэ?




Таны хариуцсан хороонд террорист халдлага болоход та ямар арга хэмжээ авахаа мэдэх үү?




Та хариуцсан хороон дээрээ терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулж байсан уу?




Та терроризмын тухай хууль, түүнтэй холбогдон гарсан эрх зүйн акттай уншиж, танилцаж байсан уу?



Та терроризмын аюул тулгарахад ямар байгууллагатай хамтарч ажиллахаа мэдэх үү?



Танай газар хэлтсээс терроризмын аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиглэлээр хичээл сургалт, заавар, зөвлөмж өгч байсан уу?



Дүгнэлт

Энэхүү цагдаагийн байгууллагын нэгж, хэсгийн терроризмтой тэмцэх ажиллагааны чадавхийг үнэлэх зорилгоор хийсэн бичил судалгааны дүнгээс үзэхэд дараах дүгнэлтэд хүрлээ.

Террористтэй тэмцэхэд цагдаагийн анхан шатны нэгж бэлэн биш, хэсгийн байцаагчийн терроризмтой тэмцэх чиглэлийн эрх зүйн мэдлэг хангалтгүй байгаа нь терроризмоос учрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Үүнээс гадна нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад терроризмтой тэмцэх дадлагажуулах сургалт, явагддаггүйгээс гадна хэсгийн байцаагчдын тэсэрч, дэлбэрэх бодисын талаарх мэдлэг хомс, шаардагдах техник, тусгай хэрэгсэл, аюулгүй хамгаалалтын хувцас хэрэгсэл байхгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Энэхүү судалгаагаар дараах асуудлууд тулгамдсан асуудал байна гэж үзэж болох юм. Тухайлбал,

- Террорист халдлага үйлдэгдсэн тохиолдолд цагдаагийн байгууллагын анхан шатны нэгж буюу цагдаагийн хэсгийн байцаагчийн авах арга хэмжээний талаарх төлөвлөгөө, зураглал байхгүй, түүнийг зохицуулж зааварчилсан эрх зүйн журам, заавар байхгүй;
- Цагдаагийн хэсэг, хэсгийн байцаагчийн тусгай чиг үүргийн байгууллагуудтай хэрхэн хамтран харилцан ажиллах чиглэлээр журам, заавар байхгүй;
- Терроризмтой тэмцэх чиглэлээр цагдаагийн байгууллага болон төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтарсан сургалт байхгүй, хийгдэж байгаагүй.

Цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх эрх зүйн үндэс нь цагдаагийн албаны тухай хууль болон терроризмтой тэмцэх тухай хуулиар бүрдүүлж өгсөн хэдий ч хамгийн гол нь цагдаагийн алба хаагч ямар заавар, журмаар хэрхэн гүйцэтгэх нь тодорхойгүй байгаа нь өнөөдрийн хамгийн том тулгамдсан асуудал болоод байгааг холбогдох албан тушаалтнууд анхааралдаа авах шаардлагатай.

Санал

Цагдаагийн байгууллагын терроризмтой тэмцэх ажиллагааны чадамжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам"-ын код 500 /Олон нийтийн аюулгүй байдлыг хангах/-ийн бүрдэл хэсэгт "Террорист халдлага үйлдэгдсэн үед

олон нийтийн аюулгүй байдлыг хангах” гэсэн нэртэйгээр код 505-ыг шинээр бий болгон журамлах;

2. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, албан хаагчдын терроризмтой тэмцэх чадамжийг дээшлүүлэх дадлага, сургалтыг улирал тутам 1-ээс доошгүй удаа зохион байгуулж хэвшүүлэх;
3. Терроризмтой тэмцэх цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд цагдаагийн анхан шатны нэгж, хэсгийн байцаагчийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, боломжийг зөв үнэлэх;
4. Хэсгийн байцаагчийн объектын судалгааг бодитойгоор хийж, объектын судалгаанд тулгуурласан хэсэгчилсэн болон хамтарсан сургалтыг зохион байгуулж, албаны шуурхай байдлыг нэмэгдүүлэх;
5. ХСИС-ийн Эрдэм шинжилгээ, хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн, судлаачдын тусламжтайгаар терроризм, түүнтэй тэмцэх, инженер, үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах болон иргэний хамгаалалтын асуудлуудыг онолын түвшинд судалж, ур чадварын түвшинд болзошгүй террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны үед цагдаагийн анхан шатны нэгжээс дэмжлэг үзүүлэх, аюулын үед үүрэг гүйцэтгэх, ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, удирдан явуулах дадлага, чадварыг эзэмшүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ



*Ц.Мөнхдэлгэр
Монголын үндэсний их сургуулийн
Хууль зүйн сургуулийн ахлах багш,
магистр*

БНХАУ-ЫН ЗАХИРГААНЫ ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНЦЛОГ

1970-аад оноос БНХАУ-д эдийн засгийн шинэчлэл хийж дэлхий дахинд нээлттэй бодлого явуулж эхэлсэн үеэс захиргааны эрх зүйн үндэс тавигдсан гэж үздэг. Хятадын коммунист нам 1980-аад оны эхээр Захиргааны эрх зүйг хууль эрх зүйн боловсролын системд нэвтрүүлж, улмаар 1986 оноос их, дээд сургуулийн сургалтад оруулж эхэн үедээ зөвхөн захиргааны ажилтан, намын “кадрууд”-ыг бэлтгэхэд анхаарч ирсэн байна.

Wikipedia нэвтрэхий тольд “... эдийн засгийн шинэчлэл хийхээс өмнө БНХАУ-д Захиргааны эрх зүйн тухай ойлголт байсангүй. 1980-аад оноос захиргааны эрх зүйн орчныг хамарсан шинэ хуулиудыг батлан гаргаж захиргааны удирдлагын хяналтын механизм болон Хятадын коммунист намын сахилгын хороог үндэслэн байгуулав.” гэжээ.

1982 оны Үндсэн хууль болон 1989, 1993, 1999, 2004 онуудын нэмэлт, өөрчлөлтүүдээр төрийн удирдлага ба төрийн захиргааны байгууллагуудын эрх хэмжээ, төрийн болон намын удирдах байгууллагуудын хамтарсан эрх зүйн акт, захиргааны шугамаар давж заалдах, төрөөс олгох захиргааны нөхөн төлбөр зэрэг асуудлыг шинээр оруулж захиргааны процессын эрх зүйн үндсийг тавьжээ. Мөн 1982-1988 онд Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн захиргааны эрх зүйн харилцааг зохицуулах болон захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэхэд чиглэгдсэн 130 гаруй хууль тогтоомжийг батлан гаргаж хэрэгжүүлсэн нь ихээхэн ач холбогдолтой болсон байна.

Мөн захиргааны процессын эрх зүйн гол эх сурвалж болсон Захиргааны процессын \Засаг захиргааны заргын тухай хууль\ хуулийн төслийг 1987 оноос эхлэн боловсруулж, 1989 онд Захиргааны маргааныг хянан шийдвэрлэх тухай хууль \Засаг захиргааны заргын тухай хууль\ нэртэйгээр батлан гаргаж, 1990 оны 10 сарын 1 буюу БНХАУ-ыг тунхагласан өдрөөр хэрэгжүүлж эхэлсэн байна

1988 оны эцсээр Захиргааны хэргийг хянан хэлэлцэж, захиргааны шийтгэл хүлээлгэж байх үүрэгтэйгээр Хятадын ардын дээд шүүхэд Захиргааны эрх зүйн танхим, 1400 гаруй шүүхийг байгуулжээ.

БНХАУ-ын захиргааны эрх зүйн хэм хэмжээг тогтоосон 130 гаруй хууль, тогтоомж байдгаас дурдвал:

- БНХАУ-ын Төрийн зөвлөлийн зохион байгуулалтын тухай хууль

- Ардын төлөөлөгчдийн орон нутгийн хурлуудын болон янз бүрийн шатны орон нутгийн ардын засгийн газрын зохион байгуулалтын тухай хууль
- Захиргааны процессын тухай хууль
- Захиргааны хяналтын тухай хууль
- Захиргааны шийдвэрийг хянан үзэх тухай хууль
- Төрийн албаны тухай түр журам
- Төрөөс олгох нөхөн төлбөрийн тухай хууль
- Захиргааны хариуцлагын /шийтгэлийн/ тухай хууль зэргийг нэрлэж болно.

1990 онд Захиргааны хяналтын журам, Захиргааны хэргийг дахин хянах журам гэсэн журмууд гарган түүнийгээ сайжруулж, улмаар 1997, 1999 онд хууль болгон батлан гаргажээ. 1993 онд Төрийн албаны тухай түр журмыг боловсруулан гаргахын тулд 8 жил бэлтгэж, түүний дотор 4 жилийн туршид төв, орон нутгийн байгууллагуудад туршсаны дээр өнөө хүртэл түүнийгээ өөрчлөн сайжруулж, түр журам хэвээр нь хэрэгжүүлсээр байна. 1994 онд Төрөөс олгох нөхөн төлбөрийн тухай хууль, 1996 онд Захиргааны хариуцлагын /шийтгэлийн/ тухай хуулийг тус тус батлан гаргажээ.

Захиргааны эрх зүйн үндсэн эх сурвалжийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Үндсэн хууль - 1982 онд баталж, 1993, 1999, 2004 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон
- Үндсэн хууль дээр үндэслэгдсэн, төрийн захиргааны байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг тодорхойлсон органик хуулиуд,
- Төрийн засаглалын болон янз бүрийн түвшний төрийн удирдлагын байгууллагуудаас гаргасан хэм хэмжээ тогтоосон актууд,
- Төрийн захиргааны байгууллагууд, Хятадын коммунист намын удирдах байгууллагууд, олон нийтийн байгууллагуудын хамтран гаргасан гадагш чиглэсэн хэм хэмжээ тогтоосон актууд
- Хоёр буюу түүнээс дээш захиргааны байгууллагуудын хамтран гаргасан хэм хэмжээ тогтоосон актууд гэж ангилжээ.

БНХАУ-ын захиргааны процессын эрх зүйн гол эх сурвалжууд нь:

- Захиргааны процессын тухай хууль /Засаг захиргааны заргын тухай хууль/
- Захиргааны хяналтын тухай хууль
- Захиргааны шийдвэрийг хянан үзэх тухай хууль
- Төрөөс олгох нөхөн төлбөрийн тухай хууль
- Захиргааны шийтгэлийн тухай хууль

Эдгээр эх сурвалжаас үзэхэд захиргааны процессын эрх зүй нь:

- а) Бүх нийтээр сахин биелүүлэх захиргааны эрх зүйн харилцааны хэм хэмжээг зөрчсөн иргэн, хуулийн эдгээд, байгууллагад хариуцлага хүлээлгэх
- б) Төрийн захиргааны байгууллага болон захиргааны байгууллагаас захиргааны эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх, уг хэм хэмжээг зөрчсөн захиргааны байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх гэсэн үндсэн хоёр чиглэлд хуваагдаж байна.

Бүх нийтээр сахин биелүүлэх захиргааны эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, байгууллагад хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон процесс ажиллагаа нь Захиргааны хариуцлагын тухай хууль, төрийн захиргааны түүнчлэн орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагаас хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гарган нийтээр дагаж мөрдөж байгаа захиргааны эрх зүйн хэм хэмжээ тогтоосон хуулийн хүчин төгөлдөр актаар зохицуулагддаг байна.

БНХАУ нь төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс хэдий ч орон нутгийн удирдах байгууллагадаа Үндсэн хууль болон бусад хуулиудад нийцүүлэн, зарим заалтыг тодотгох зорилгоор орон нутгийн онцлогт тохируулан хүний эрхийг хязгаарлахаас бусад эрх зүйн хэм хэмжээ тогтоон хэрэгжүүлэх хязгаарлагдмал эрхийг олгосон байдаг. Орон нутгийн хурлын болон төрийн удирдлагын байгууллага тухайн нутаг дэвсгэр дээрээ батлан гаргасан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актдаа тухайн эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх, түүнийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага, хариуцлага хүлээлгэх журмын талаар заасан байдаг тул процессын чанартай эрх зүйн акт гэж үзэх үндэслэлтэй юм.

Захиргааны шийтгэл, түүнийг хэрэглэх журмыг тогтоох, захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа захиргааны шинжтэй арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих, нийгмийн ашиг сонирхол болон нийгмийн дэг журмыг хамгаалах, иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хангах зорилгоор Захиргааны хариуцлагын тухай хуулийг 1996 оны 3 сард батлан гаргаж 10 сарын 1-ээс дагаж мөрдсөн байна.

Захиргааны шийтгэлийг оногдуулахдаа эрх зүйн эсрэг үйлдлийг шинж, нөхцөл байдал, нийгмийн хор аюулын зэргийг харгалзан бодит баримтад үндэслэн маш анхааралтай хандаж байхыг уг хуульд заасан бөгөөд шийтгэл нь хүмүүжүүлэх үр нөлөөтэй байхын дээр хуулийг ухамсартайгаар биелүүлэхэд чиглэсэн байх зарчмыг хуульчилсан байна.

Захиргааны шийтгэл хүлээлгэх ажиллагааны үед эрх зүйн эсрэг үйлдэл хийсэнд тооцогдож байгаа иргэн, хуулийн этгээд, бусад байгууллага өөрийгөө хамгаалах зорилгоор тайлбар өгөх эрхтэйгээс гадна захиргааны шийтгэл ноогдуулахаар гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч дахин хянаж үзэх талаар гомдол гаргаж болно.

Мөн захиргааны байгууллагаас ногдуулсан шийтгэл нь гэм буруугийн хэмжээнд тохироогүйн улмаас хохирол учирсан гэж үзсэн иргэн, хуулийн этгээд, байгууллага зохих хууль тогтоомжид заасны дагуу хохирлоо нэхэмжлэх эрхтэй байдаг.

Иргэн, хуулийн этгээд, байгууллага эрх зүйн эсрэг үйлдэл хийсэн нь нотлогдвол дараах шийтгэлийн аль нэгийг ноогдуулахаар заажээ. Үүнд:

- Урьдчилан анхааруулах
- Торгох
- Хууль бусаар олж авсан эд хөрөнгийг болон хууль бусаар хуримтлуулсан үнэт зүйлсийг хураах
- Үйл ажиллагааг нь зогсоох шийдвэр гаргах
- Лиценз болон патентын үйлчилгээг түр эсвэл бүрмөсөн зогсоох
- Захиргааны журмаар баривчлах
- Хууль болон захиргааны бусад хууль, тогтоомжид заасан захиргааны бусад шийтгэл

Үүнээс гадна эрх зүйн эсрэг үйлдэл хийсэн этгээд уг үйлдлийнхээ үр дүнд бусдад хохирол учруулсан бол иргэний хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Захиргааны шийтгэлийг хуульд заасан эрх бүхий байгууллагууд ногдуулдаг. Энэ хуульд зааснаар:

- Муж, автономит районы төрийн зөвлөл эсвэл ардын засгийн газраас захиргааны шийтгэл ноогдуулах эрх олгосон захиргааны байгууллага, (харин иргэний эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон шийтгэлийг зөвхөн нийгмийг аюулаас хамгаалах байгууллага ноогдуулна)
- Хууль болон хуульчлагдсан захиргааны актаар захиргааны шийтгэл ноогдуулах үүрэг хүлээсэн байгууллагууд

- Захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн эрх үүргийнхээ хүрээнд захиргааны шийтгэл ноогдуулж болно. Харин захиргааны байгууллагууд бусад байгууллага болон хүмүүст захиргааны шийтгэл ногдуулахыг даалгаж болохгүй.

Захиргааны шийтгэл ноогдуулахыг бусдад даалгах эрхтэй байгууллага нь Үйлдвэрлэлийн бус, олон нийтийн асуудал эрхэлдэг, орон тоондоо зайлшгүй шаардлагатай мэргэжлийн ажилтантай, шаардлагатай үед техникийн хяналт болон шинжилгээ хийх боломжтой байгууллагад захиргааны шийтгэл ноогдуулахыг даалгаж болох бөгөөд тэднээс захиргааны шийтгэл ноогдуулж байгаа байдалд хяналт тавихын дээр эцсийн хариуцлагыг даалгасан байгууллага хүлээнэ.

Эрх зүйн эсрэг үйлдэл хийгдсэнээс хойш 2 жил өнгөрсөн бол захиргааны шийтгэл ноогдуулахыг хориглох ба бусад тохиолдолд ердийн журмаар шийдвэрлэх бөгөөд ингэхдээ эрх зүйн эсрэг үйлдлийг газар дээр нь тодруулж, шаардлагатай бол холбогдох шалгалтыг 2 ба түүнээс дээш хүн хийж албан ёсны протокол хөтлөн, мөрдөн шалгах ажиллагаа явуулж дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- Эрх зүйн эсрэг үйлдэл нотлогдвол захиргааны шийтгэл ноогдуулах тогтоол гаргана.

- Хэрэв эрх зүйн эсрэг үйлдэл нь бага хэмжээний бол захиргааны шийтгэл ноогдуулахгүй байж болно.

- Хэрэв эрх зүйн эсрэг үйлдэл биш байвал захиргааны шийтгэл ногдуулахгүй.

- Хэрэв гэмт хэргийн шинжийг агуулсан байвал шүүхийн байгууллагад шилжүүлнэ.

Лиценз, патентыг цуцлах, их хэмжээний торгууль ногдуулахаар бол тогтоол үйлдэхийн өмнө шүүн хэлэлцэж, талуудыг сонсох ажиллагаа явуулдаг ба шүүн хэлэлцэх журмыг энэ хуулиар тогтоосон байдаг.

Уг хуулиар захиргааны шийтгэл ноогдуулсан шийдвэрийг биелүүлэх механизм, захиргааны шийтгэл буруу хэрэглэсэн захиргааны байгууллага, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан байна.

Төрийн захиргааны байгууллага болон захиргааны байгууллагаас захиргааны эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх, уг хэм хэмжээг зөрчсөн захиргааны байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон процесс ажиллагаа нь Захиргааны процессын тухай хууль, Захиргааны хяналтын тухай хууль, Захиргааны шийдвэрийг хянан үзэх тухай хууль, Төрөөс олгох нөхөн төлбөрийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулагддаг байна.

Анх 1987 онд Ардын дээд шүүх болон орон нутгийн ардын шүүхүүдэд захиргааны хэргийг хянан шийдвэрлэх эрх олгож захиргааны хэргийн танхимуудыг байгуулжээ.

Улмаар 1989 оны 4 дүгээр сарын 4-нд батлагдан 1990 10 сарын 1-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдсөн Захиргааны процессын хуулийг батлан гаргаснаар захиргааны процессын эрх зүйн үндэс бүрэлдэн тогтсон байна. Үүнээс хойш Захиргааны процессын хууль ёсоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн үйлдлийн талаарх гомдлыг ардын шүүхүүд хүлээн авч шийдвэрлэдэг болов.

Уг хуулийн 3 дугаар зүйлд “Ардын шүүх хороо засаг захиргааны хэргийг шүүн таслах эрхээ хууль ёсоор бие даан хэрэгжүүлнэ. Засаг захиргааны байгууллага, нийгмийн бүлэг, хувь хүн оролцохыг хориглоно. Ардын шүүх хороо засаг захиргааны шүүн таслах танхим байгуулж, засаг захиргааны хэргийг шүүн шийдвэрлэнэ” гэж заажээ.

Мөн хуульд ардын шүүхээр шийдвэрлэвэл зохих захиргааны хэргийг хуульчилж, гол төлөв баривчлах, торгох, зөвшөөрөл, гэрчилгээг хураах, үйлдвэрлэлийг зогсоох, эд хөрөнгийг хураах, барьцаалахтай холбогдсон захиргааны шийдвэрүүд хамаардаг байна.

1980-аад оноос хойш хөдөөгийн оршин суугчдын хороо, түрээслэгч - тариаланчдын хоорондын захиргааны шинжтэй маргаан ихээр гарах болсон нь захиргааны хэргийн нэг гол объект болж байна.

БНХАУ-ын захиргааны процесс нь дараах үндсэн зарчмуудыг удирдлага болгодог.

- Шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд хууль ёсыг сахих,
- Шүүх нь захиргаа, олон нийтийн байгууллага хувь хүний нөлөөнөөс ангид байх,
- Захиргааны хэргийг 2 шаттайгаар ил тод хянан шийдвэрлэх,

БНХАУ-д Захиргааны хэргийг 2 шаттайгаар шийдвэрлэдэг. Үүнд:

Нэг. Эхний шатанд иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагаас захиргааны шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг эрх бүхий захиргааны байгууллага хянан шийдвэрлэдэг.

Хоёр. Дараагийн шатанд хуульд тусгайлан заасан эсвэл захиргааны шийдвэрийг хянан үзсэн шийдвэрийг эс зөвшөөрсөн иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагаас гаргасан нэхэмжлэлийн дагуу үүсгэсэн захиргааны хэргийг ардын шүүхээр хянан шийдвэрлэдэг.

Иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагаас захиргааны шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлыг эрх бүхий захиргааны байгууллага хянан шийдвэрлэх ажиллагаа нь Захиргааны шийдвэрийг хянан үзэх тухай хуулиар зохицуулагдана.

Захиргааны шийдвэрийг хянан үзэх тухай хууль нь 1999 онд батлагдан гарсан, 7 бүлэг, 43 зүйл бүхий, захиргааны хууль бус эсвэл буруу үйл ажиллагааг гаргуулахгүй байх, гарсан тохиолдолд түүнийг засаж залруулах, иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, захиргааны байгууллагуудын хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэргжүүлэх боломжийг хангах, түүнд хяналт тавих харилцааг зохицуулах зорилготой юм.

1989 онд батлагдсан Захиргааны процессын хууль нь 9 бүлэг, 75 зүйлтэй, ардын шүүхээр захиргааны хэргийг шүүн хэлэлцэх ажиллагааг боловсронгуй болгож, зөв явуулах, иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагын хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, захиргааны байгууллагаас хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, түүнд хяналт тавих боломжийг олгох зорилготой юм.

Захиргааны процессын хууль нь ерөнхий зүйл, хүлээн авч шийдвэрлэх хэрэг, шүүхүүдийн эрх мэдлийн хүрээ, процесс ажиллагаанд оролцогчид, нотлох баримт, нотлох ажиллагаа, гомдол гаргах, гомдлыг хүлээн авах, хэргийг шүүн хэлэлцэх, шийдвэр гаргах, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөхөн төлбөр олгох, захиргааны процесст гадаадын иргэнийг оролцуулах, нэмэлт зүйл гэсэн үндсэн асуудлуудыг багтаасан харилцааг зохицуулсан байна.

Мөн ардын шүүх хүлээж авахгүй байх захиргааны хэргүүдийн талаар тодорхой заажээ. Үүнд:

- Үндэсний батлан хамгаалалт болон гадаад харилцаатай холбоотой төрийн актууд,
- Захиргааны байгууллагаас боловсруулан гаргаж олон нийтэд зарласан заавал биелүүлэх хүчин чадалтай, захиргааны дүрэм, журам эсвэл шийдвэр, тушаал,
- Байгууллагынхаа албан хаагчдыг шагнах, шийтгэх эсвэл томилох, чөлөөлөхтэй холбоотой захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр,
- Захиргааны байгууллагаар эцэслэн шийдэгдсэн, хуульд нийцсэн захиргааны тусгай акт зэргийн талаар иргэн, хуулийн этгээд, бусад байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг ардын шүүх хүлээж авахгүй байхаар хуульчилжээ.

Түүнчлэн, дөрвөн шатны шүүхийн эрх хэмжээнд шийдвэрлэх хэргийг болон шүүхийн харьяаллыг хуулийн 3 дугаар бүлэгт тодорхой заажээ.

Хэргийн оролцогчдыг нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, шүүгч, прокурор гэх мэтээр тодорхойлсон байна.

Хэрэг үүсгэх ба хэргийг хүлээн авах гэсэн 6 дугаар бүлэгт зааснаар дараах 2 тохиолдолд иргэн, хуулийн этгээд, бусад байгууллага ардын шүүхэд хандана. Үүнд:

1. Захиргааны шийдвэрийг хянан үзэж гаргасан захиргааны эрх бүхий байгууллага болон дээд шатны захиргааны байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрсөн,
2. Хуулиар тухайн захиргааны маргааны асуудлаар шууд ардын шүүхэд хандахаар заасан бол,

Ардын шүүх, захиргааны байгууллагын даргыг эсвэл албан тушаалтныг захиргааны сахилга зөрчсөн гэж үзвэл түүнд холбогдох материалыг

- Захиргааны байгууллага
- Дээд шатны захиргааны байгууллага
- Байцаагч
- Боловсон хүчний хэлтсийн аль нэгэнд, харин Ардын шүүх, дээрх хүмүүсийн үйлдлийг Эрүүгийн хэрэг гэж үзсэн бол холбогдох материалыг Нийгмийг Аюулаас Хамгаалах байгууллага болон прокурорын байгууллагад явуулна.

Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн тогтоол, шийдвэр тодорхой алдаатай байвал талууд дээд шатны шүүхэд гомдол гаргаж болно. Харин уг тогтоол, шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөх болно.

Харин доод шатны шүүхийн шийдвэрийн гаргасан алдааг дээд шатны шүүх нь илрүүлсэн байвал доод шатны шүүхэд дахин хэлэлцүүлэхээр, прокурор шүүхийн тогтоол, шийдвэрийн алдааг илрүүлсэн бол хяналтын шатны шүүхэд эсэргүүцэл бичнэ.

Талууд хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй бөгөөд хэрэв иргэн, хуулийн этгээд, бусад байгууллага шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзвал захиргааны байгууллага ардын шүүхэд хүсэлт гаргаж түүнийг албадан хэрэгжүүлнэ.

Иргэн, хуулийн этгээд, бусад байгууллага захиргааны хууль бус актын улмаас хохирол хүлээсэн бол нөхөн төлүүлэхээр захиргааны байгууллагад хандана. Хэрэв захиргааны байгууллага хохирлыг нь нөхөн төлөхгүй бол ардын шүүхээр шийдвэрлүүлэнэ.

Түүнчлэн хуульд заасан зарчим, хуулийн үзэл санааг гуйвуулахгүй байх зорилгоор прокурорын хяналттай байхаар хуульчилсан байна.

ОХУ зарим эрдэмтэд БНХАУ-ыг өөрийн эрх зүйн уламжлал дээр тулгуурлан Хятадын онцлогтой социалист эрх зүйн тогтолцоог хөгжүүлэхдээ Ром – Германы эрх зүйн тогтолцооны зарим элементийг агуулсан холимог тогтолцоотой гэж үзсэн байна.

БНХАУ нь социалист орон бөгөөд өөрийн онцлог бүхий зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин орж, хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, эдийн засгаа либеральчилсан, өмчийн олон хэлбэр бүхий, төрийн зохицуулалттай эдийн засагтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл, парламентын бүгд найрамдах улс юм. Харин улс төрийн хувьд либеральчлагдаагүй, нэг \коммунист\ намын удирдан жолоодох үүрэг нь хэвээрээ байна.

Тус улсын захиргааны эрх зүй нь 1980-аад оноос шинэ тутам хөгжиж байгаа хэдий ч БНХАУ-ын эрх зүйн тогтолцоонд захиргааны эрх зүй зохих байр суурийг эзэлж цаашид өргөжин хөгжих хандлагатай байгаа бөгөөд захиргааны материаллаг болон процессын эрх зүй нь хамрах цар хүрээ, зохицуулах харилцаа, эх сурвалж, эрх зүйн хэм хэмжээний хувьд харьцангуй өргөн далайцтай, нилээд нарийвчлалтай болсон байна.

БНХАУ-ын Ардын шүүхийн 4 шатны шүүхэд захиргааны хэргийн танхимтай, захиргааны хэргийг “Захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийг эрх бүхий

захиргааны байгууллагаас хянан үзэх”, “хуулиар харъяалуулсан захиргааны хэргийг Ардын шүүхээр хянан шийдвэрлэх” гэсэн хоёр шаттайгаар шийдвэрлэдэг, Ардын шүүхийн 4 шатны шүүх нь бүгдээрээ захиргааны хэргийг анхан шатны журмаар шийдвэрлэдэг, давж заалдах шатандаа эцсийн шийдвэр гаргадаг боловч хууль зөрчсөн тодорхой үйлдэл байгаа тохиолдолд хяналтын журмаар шийдвэрлэдэг, хяналтын журмаар шийдвэрлэдэг шүүхийг “шүүхийн шийдвэрийн хороо” гэдэг.

Захиргааны хэргийн шүүх нь зөвхөн хэргийг шийдээд зогсдоггүй, шүүхийн шийдвэрийг биелүүлэх, биелэлтэд хяналт тавих, гэм буруутныг дахин эрх зүйн эсрэг үйлдэл хийлгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, хохирогчид төрөөс олгох нөхөн олговрыг иргэний журмаар шийдвэрлүүл гэж явуулдаггүй, захиргааны журмаар болон захиргааны хэргийн шүүхийн журмаар шийдвэрлэх эрх зүйн зохицуулалттай зэрэг онцлог болон давуу талтай байна.

Захиргааны хэргийн бие даасан шүүхгүй хэдий ч захиргааны хэргийн өсөлтийн хандлагаас үзэхэд цаашид төрөлжсөн шүүх байгуулах шаардлагатай болж болох юм. Тухайлбал, 1992 онд анхан шатны журмаар 27.1 мянган захиргааны хэргийг хянан шийдвэрлэж байсан нь өмнөх онтой харьцуулвал 5.7 % -аар өссөн байна.

Түүнээс гадна Хятадын нийт төрийн албан хаагчдын тоо 1978 онд 3.7 сая байсан бол 2010 онд 10.8 сая болж 2.8 дахин өссөн байна. Энэ нь захиргааны шийдвэр гаргагчдын тоо жилээс жилд эрчимтэй өсч байгааг харуулахын зэрэгцээ захиргааны хэрэг, маргаан төдий чинээ нэмэгдэж болохыг үгүйсгэх аргагүй.

Захиргааны байгууллага, албан тушаалтныг хууль бус үйлдлээс хамгаалах, иргэдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг аль болохоор зөрчүүлэхгүй байх зорилгоор төрийн албаны түр журмыг улам боловсронгуй болгосоор байна.

Ашигласан материал:

- Козырин А.Н. Административное право Китайской Народной Республики
- Административное право зарубежных стран.Издательство "СПАРК",1996. - 229 с.
- Закон КНР о пересмотре административных действий, 1999.
- Administrative Procedure Law of the People's Republic of China, 1996
- Система национального регулирования качества в Китае, Структура китайской правовой системы
- Law of the People's Republic of China on State Compensation
- Administrative Supervision Law of the People's Republic of China, 1996
- Administrative law in the People's Republic of China, Wikipedia
- Закон Китайской Народной Республики об административных наказаниях
- БНХАУ-ын хууль цааз, хууль тогтоомжуудын эмхтгэл.Хөх хот.2007